



МОНГОЛЫН ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН
НИЙГЭМЛЭГ ТББ

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР НӨЛӨӨНИЙ СУДАЛГАА

УЛААНБААТАР ХОТ 2020 ОН

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

СУДАЛГААНЫ ЗАХИАЛАГЧ:	СУДАЛГААГ ГҮЙЦЭТГЭСЭН
ЖАЙКА	“МОНГОЛЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙГЭМЛЭГ” ТӨРИЙН БУС БАЙГУУЛАГА
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ	<p>Судалгааны багийн ахлагч: Доктор, проф. Б.Амарсанаа (МУИС-ийн Хууль зүйн сургуулийн хувийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч)</p> <p>Гишүүд: С.Батбаяр (МХТН ТББ-ын судлаач) Н.Норовсамбуу (МХТН ТББ-ын судлаач) Б.Доржпагма (МХТН ТББ-ын судлаач)</p>

2020.03.16 сар

ТАЛАРХАЛ

Япон Улсын Олон Улсын Хамтын ажиллагааны байгууллага (Жайка)-ын захиалгаар “Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль”-ийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгааг 2020 оны 01 дүгээр сараас 2020 оны 03 дугаар сар хүртэл хийж гүйцэтгэв.

Энэхүү судалгааг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээлэл цугуулахад туслалцаа үзүүлж, хамтарч ажилласан Шүүхийн Ерөнхий Зөвлөл болон ШЕЗ-ийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн хамт олонд талархал илэрхийлье.

Судалгааны баг

Агуулга

УДИРТГАЛ.....	8
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ.....	9
1.1. Үнэлгээ хийх үндэслэл, шаардлага.....	9
1.2. Үнэлгээ хийх хүрээ	10
1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт.....	10
1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох.....	14
1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох.....	14
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох болон судлагдсан байдал	20
2.1. Судалгааны арга зүй, мэдээлэл цуглуулсан зохион байгуулалт.....	22
2.2. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлт	26
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	28
3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	28
3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	61
ДӨРӨВ. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО	70
4.1. Шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо.....	70
4.2. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл	74
4.3. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны төрөл	75
4.4. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа	76
4.5. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа өнөөгийн нөхцөл байдал	80
ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	82
Ашигласан эх сурвалжийн жагсаалт	90

Товчилсон үг

БМЭЗТ	Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төв
ИХШХШТХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ШШГТХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
ШЕЗ	Шүүхийн Ерөнхий Зөвлөл
МҮХАЙТ	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим

Графикийн жагсаалт

График 1. Судалгаанд оролцогчдын эрх зүйн байдал	26
График 2. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцсон туршлага /Эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах, шүүгч, өмгөөлөгч, хуульч/	27
График 3. Эвлэрүүлэн зуучлалд хандаж буй маргааны төрөл /эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах, шүүгч, өмгөөлөгч, хуульчийн хариулт/.....	30
График 4. Эвлэрэлт амжилттай болон амжилтгүй болоход нөлөөлж буй хүчин зүйлс (Эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах, шүүгч, өмгөөлөгчийн хариулт).....	31
График 5. Эвлэрэлт амжилттай болон амжилтгүй болоход нөлөөлж буй хүчин зүйлс (иргэдийн хариулт).....	32
График 6. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг цаашид илүү үр дүнтэй ажиллуулах талаар дэвшүүлсэн санал /Шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах, өмгөөлөгч, хуульчийн хариулт/.....	33
График 7. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтэд өгөх үнэлгээ /шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах, өмгөөлөгч, хуульчийн хариулт/	35
График 8. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтэд өгөх үнэлгээ /иргэдийн хариулт/	36
График 9. Шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалаас өөр төрлийн эвлэрүүлэн зуучлагч байдгийг мэдэх эсэх талаар иргэдийн өгсөн хариулт	40
График 10. Эвлэрүүлэн зуучлалын талаар иргэдийн мэдээлэл авдаг суваг	41
График 11. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаас гадуур эвлэрүүлэн зуучлагч ажиллах зохицуулалт үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх /Шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах, өмгөөлөгч, хуульчийн хариулт/.....	47
График 12. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаас гадуур эвлэрүүлэн зуучлагч ажиллах зохицуулалт хэрэгжихгүй байгаа шалтгаан /Шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах, өмгөөлөгч, хуульчийн хариулт/.....	47
График 13. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаас гадуур эвлэрүүлэн зуучлагчаар хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхээр хандах эсэх /иргэдийн хариулт/	49
График 14. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад бэрхшээл тулгарсан эсэх /иргэдийн хариулт/	62
График 15. Эвлэрүүн зуучлах ажиллагаанд тулгардаг хүндрэл бэрхшээл /иргэдийн хариулт/	63
График 16. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд тулгардаг хүндрэл бэрхшээл /Шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах, өмгөөлөгч, хуульчийн хариулт/	63
График 17. Маргааны шийдвэрлэж буй дундаж хугацаа (маргааны төрлөөр).	66
График 18. Нийт шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эзлэх хувь (2019)	81
График 19. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой маргааныг шүүхээр шийдвэрлэсэн байдал (2019).....	81

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Анкетын судалгаанд оролцогчийн тоо, эрх зүйн байдал.....	23
Хүснэгт 2. Ярилцлага хийсэн хүн, ярилцлагын арга.....	24
Хүснэгт 3. Судалгаанд оролцогчдын эрх зүйн байдал, нас, туршлага, хүйс.....	26
Хүснэгт 4. Санал асуулгад оролцсон иргэдийн эвлэрүүлэн зуучлалаар шийдүүлсэн маргааны төрөл.....	27
Хүснэгт 5. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд шууд хандсан өргөдөл, маргааны төрлөөр (2014-2019 он)	29
Хүснэгт 6. Иргэний хэрэг үүсгэхээс өмнө шүүхээс эвлэрүүлэн зуучлалд шилжүүлсэн өргөдөл, маргаан (2014-2019 он).....	29
Хүснэгт 7. Иргэний хэрэг үүсгэсний дараа шүүхээс эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлсэн өргөдөл, маргаан (2014-2019 он).....	29
Хүснэгт 8. Иргэний хэрэгт эвлэрүүлэн зуучлах ажиллагааны эзэлж буй жин, ачаалал бууруулж буй хувь (2014-2019 он).....	30
Хүснэгт 9. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилттай болон амжилтгүй шийдвэрлэгддэг хувь (маргааны төрлөөр) (шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах, өмгөөлөгч, хуульчийн хариулт).....	31
Хүснэгт 10. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаар иргэдийн өгсөн үнэлгээ.....	34
Хүснэгт 11. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаан дахь зарчмын хэрэгжилт /шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах, өмгөөлөгч, хуульчийн хариулт/	35
Хүснэгт 12. Шүүхээс гадуур төрийн болон төрийн бус байгууллагын дэргэд эвлэрүүлэн зуучлагч ажиллах зохицуулалт үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх	42
Хүснэгт 13. Төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх (шүүхээс бусад) эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд байгууллагдах эвлэрлийн гэрээг шүүгч баталгаажуулж шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах боломж	46
Хүснэгт 14. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэсэн маргааны төрлөөр (2014-2019 он)	53
Хүснэгт 15. Санал асуулгад оролцсон иргэдийн шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлүүлсэн маргааны төрөл, эрх зүйн байдал (хувиар)	54
Хүснэгт 16. Эвлэрүүлэн зуучлах тогтолцоо бий болсноор шүүхийн ажлын ачаалалд нөлөөлсөн эсэх.....	54
Хүснэгт 17. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаар маргааныг шийдвэрлэхдээ хийсэн уулзалтын тоо (иргэдийн хариулт)	67
Хүснэгт 18. Шийдвэр гүйцэтгэгчид ногдох гүйцэтгэх баримт бичиг (2017-2019.10 сар)	74
Хүснэгт 19. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны 2014-2019 оны мэдээ.....	80

Ярилцлагын жагсаал

Шигтгээ 1. Шүүгчтэй хийсэн ярилцлагаас	38
Шигтгээ 2. Их сургуулийн багштай хийсэн ярилцлагаас	38
Шигтгээ 3. Их сургуулийн багштай хийсэн ярилцлагаас	41
Шигтгээ 4. MYXAYT-ийн БЭЗМЭЗТ-ийн эвлэрүүлэн зуучлагтай хийсэн ярилцлагаас	43
Шигтгээ 5. Өмгөөлөгчтэй хийсэн ярилцлагаас	44
Шигтгээ 6. Татварын улсын байцаагчтай хийсэн ярилцлагаас.....	50
Шигтгээ 7. Банкны хуулийн хэлтсийн захиралтай хийсэн ярилцлагаас	51
Шигтгээ 8. Шүүгчтэй хийсэн ярилцлагаас	57
Шигтгээ 9. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчтай хийсэн ярилцлагаас.....	58
Шигтгээ 10. Эвлэрүүлэн зуучлагчтай хийсэн ярилцлагаас	58
Шигтгээ 11. Шүүгчтэй хийсэн ярилцлагаас	59
Шигтгээ 12. Шүүгчтэй хийсэн ярилцлагаас	60
Шигтгээ 13. Эвлэрүүлэн зуучлагчтай хийсэн ярилцлагаас	60
Шигтгээ 14. Шүүгчтэй хийсэн ярилцлагаас	61
Шигтгээ 15. Шүүгчтэй хийсэн ярилцлагаас	62
Шигтгээ 16. Эвлэрүүлэн зуучлагчтай хийсэн ярилцлагаас	64
Шигтгээ 17. Эвлэрүүлэн зуучлагчтай хийсэн ярилцлагаас	64
Шигтгээ 18. Шүүгчтэй хийсэн ярилцлагаас	65
Шигтгээ 19. Эвлэрүүлэн зуучлагчтай хийсэн ярилцлагаас	67
Шигтгээ 20. Эвлэрүүлэн зуучлагчтай хийсэн ярилцлагаас	67

УДИРТГАЛ

Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллага ("ЖАЙКА"), Монгол Улсын Дээд шүүхийн хамтран хэрэгжүүлсэн төслийн хүрээнд шүүх эрх мэдлийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөрийн дагуу Улсын Их Хурлаас шүүхийн багц хуулиуд баталсны нэг нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль юм.

Энэхүү хуулиар эрх зүйн маргааныг шүүхийн бус аргаар эвлэрүүлэн шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, улмаар тухайн ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах болсноор хэрэг, маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдсэн болно.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль хэрэгжсэнээр иргэн, хөдөлмөр, гэр бүлийн эрх зүйн маргааныг шүүхийн бус аргаар буюу эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдэж, Монгол Улсын үндэсний эрх зүйн тогтолцоо "Эвлэрүүлэн зуучлалын эрх зүй" хэмээх шинэ салбараар хүрээгээ тэлэх нөхцөл бүрдсэний гадна Иргэн, хөдөлмөр, гэр бүлийн эрх зүйн харилцааны процессын нэг чухал институц болон хөгжиж байна.¹

Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль хэрэгжиж эхэслнээс хойши 6 жилийн хугацаанд олон тооны хэрэг, маргааныг амжилттай шийдвэрлэж, тодорхой үр дүнд хүрээд байгаа боловч хууль бүрэн дүүрэн хэрэгжиж байгаа эсэх, тус хуулийн зохицуулалт нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эхэсэд үнэлэлт, дүгнэлт хийхэд хангалттай хугацаа өнгөрөөд байна.

Тиймээс ЖАЙКА-ын захиалгаар "Монголын Хууль тогтоомжийн нийгэмлэг" ТББ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал", мөн захиалгачаас өгсөн ажлын даалгаврын дагуу энэхүү хэрэгжилтийн үр нөлөөний судалгааг хийж гүйцэтгэв.

Энэхүү судалгааны зорилго нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн тодорхой зүйл, заалтуудад хэрэгжилтийн үнэлгээ хийснээр хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, хэрэгжилтийн явцад гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг байдлыг тодорхойлж, зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх хувилбарыг тодорхойлоход чиглэгдэнэ.

Ялангуяа, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаас бусад төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын хэрэгжилтийг голчлон авч үзэхээс гадна Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийг бүхэлд нь үнэлэхийг зорьсон болно.

¹ Монгол Улсын Дээд шүүх, Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны тайлан.
<http://www.supremecourt.mn/news/163>

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1. Үнэлгээ хийх үндэслэл, шаардлага

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасан. Өөрөөр хэлбэл Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль хэрэгжснээс хойш 6 жилийн хугацаа өнгөрсөн тул хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх зохистой хугацаа болсон байна.

Тиймээс тус хууль хэрэгжиж, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдаж эхэлснээс хойши хуюу 2014 оноос 2019 он хүртэлх эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлэгдсэн хэрэг маргааны тоо баримтыг авч үзье. 2014 онд нийт 32,181 хэрэг Иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн бол түүнээс 2,847 иргэний хэргийг Эвлэрүүлэн зуучлалаар амжилттай шийдвэрлэсэн. Энэ нь нийт шийдвэрлэгдсэн иргэний хэргийн 8.1 хувийг эзэлж байсан бол энэ үзүүлэлт жил ирэх тусам нэмэгдсэн эерэг үзүүлэлттэй байна.²

Тухайлбал, 2015 онд 35,493 иргэний хэрэг шийдвэрлэгдснээс 7881 хэргийг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэсэн нь нийт хэргийн 18.2 хувь, 2016 онд 39,773 иргэний хэргээс 8,909 хэрэг буюу 18.3 хувь, 2017 онд 37,271 иргэний хэргээс 10,013 буюу 21.2 хувь, 2018 онд 41,363 иргэний хэргээс 8,711 хэрэг буюу 17.4 хувь, 2019 онд 37,387 иргэний хэргээс 9,227 хэрэг буюу 19.8 хувийг тус тус эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар амжилттай шийдвэрлэсэн байна.

Энэ нь шүүх дэх Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хэрэгжсэн 6 жилийн нэгтгэсэн дүнгээр авч үзвэл нийт 223,468 иргэний хэргээс 47,587 хэрэг буюу дунджаар нийт иргэний хэргийн 17.2 хувийг эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар амжилттай шийдвэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл энэ хэмжээгээр иргэний хэргийн шүүхийн ачааллыг багасгах, талууд харилцан тохиролцож маргааныг шийдвэрлүүлсэн ач холбогдолтой юм.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан болон гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэнэ” гэж заасны дагуу эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилттай болсон хэргийг хуульд заасан хэрэг, маргааны төрлөөр нь ангилан авч үзэв. 2014-2019 оны хооронд нийт иргэний эрх зүйн маргаан 51,474, Хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан 463, Гэр бүлийн эрх зүйн 18,552 маргаан байна. Үүнээс иргэний эрх зүйн маргааны 45,193 буюу 87.8 хувь, хөдөлмөрийн ганцаарчилсан маргааны 323 буюу 69.8 хувь, гэр бүлийн эрх зүйн маргааны 2,557 буюу 13.8 хувьд эвлэрэлт амжилттай болсон байна.

Дээрх баримтаас үзэхэд иргэний эрх зүйн маргаанд эзэлж буй эвлэрлийн хувь хамгийн өндөр байгаа бол гэр бүлийн эрх зүйн маргааны эвлэрлийн хувь харьцангуй бага

² Иргэний хэргийн шүүх таслах ажиллагааны дүн, мэдээ 2014-2019 оны бүх мэдээллийг нэгтгэн боловсруулалт хийв.

үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь хэрэг, маргааны төрлөөс хамааран эрс, тэс ялгаа бүхий үр дүнтэй байгаа нь анхаарал татсан асуудал юм.

Иймд дараагийн хэсгүүдэд дээрх маргаануудын онцлог, тулгарч буй бэрхшээл, эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг дэлгэрүүлэн авч үзэх болно.

1.2. Үнэлгээ хийх хүрээ

Хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгааг гүйцэтгэхдээ тухайн хуулийн бүх зүйл, заалтуудад хэрэгжилтийн үнэлгээ хийхгүй бөгөөд хуулийн тодорхой зүйл заалтуудыг сонгон авах замаар хэрэгжилтийн үнэлгээ хийх хүрээг тогтоодог. Гэсэн ч судалгааны багийн зүгээс Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийг цогцоор нь дүгнэх зорилгоор аль болох олон зүйл, заалтуудын хэрэгжилтийг үнэлэхийг зорив.

Иймд энэхүү судалгааг гүйцэтгэхдээ Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ хийх зүйл заалтуудыг сонгохдоо Захиалагчаас өгсөн Ажлын даалгаврын дагуу дараах үндсэн зорилгын хүрээнд тодорхойлсон.

- Эвлэрүүлэн зуучлалаар амжилттай болон амжилтгүй шийдвэрлэгдэж буй хэрэг, маргааны төрлөөр хууль тогтоомжийн хэрэгжилтийг тооцох;
- Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаас бусад териин болон териийн бус байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төвүүдийн эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хэрэгжилтийг тооцох;
- Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах хуульд заасан хугацаа ба маргааныг шийдвэрлэж буй хугацааг харьцуулан хэрэгжилтийг тооцох;
- Эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэж буй сургалт, давтан сургалтын үйл явцад үнэлгээ хийх;
- Эвлэрлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахад албадан шийдвэр гүйцэтгэлийн хэрэгжилтийг тооцох;

Дээрх зорилгын хүрээнд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 5 дугаар зүйл, 7 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.1, 9 дүгээр зүйл, 11 дүгээр зүйлийн 11.1.2, 11.1.3, 11.1.4, 11.1.5, 14 дүгээр зүйл, 18 дугаар зүйлийн 18.5, 20 дугаар зүйл, 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 30 дугаар зүйл, 31 дүгээр зүйл, 32 дугаар зүйл болон дээрх зүйл, заалтуудтай холбогдох бусад зүйл, заалтын хэрэгжилтийн үнэлгээг хийхээр сонгон авав.

1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт

Хуулийн хэрэгжилтийн бодит байдлыг тодорхойлоход хэд хэдэн шалгуур үзүүлэлтүүдээс тохирох шалгуур үзүүлэлтийг сонгож хэрэгжилтийн үр нөлөөг үнэлдэг. Судалгааны багийн зүгээс “Зорилгод хүрсэн түвшин”, “Практикт нийцэж буй байдал” гэсэн хоёр шалгуур үзүүлэлтээр хуулийн хэрэгжилтийг үнэлэхээр сонгосон.

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтээр тухайн хууль хэрэгжиж өхөлснээс хойшхи хугацаанд тавьсан зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтоодог. Тиймээс 1.2 дахь

хэсэг буюу үнэлгээ хийх хүрээг тогтооход сонгон авсан хуулийн заалтуудаас дараах заалтуудыг зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд судлан үзнэ. Үүнд:

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 5 дугаар зүйлд Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зорилго, зарчим бодитой хэрэгжиж байгаа эсэхийг эвлэрүүлэн зуучлалаар үйлчлүүлсэн иргэдийн үнэлгээнд үндэслэн үнэлэх, мөн 7 дугаар зүйд заасан шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаатай харьцуулан нь авч үзнэ.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаас бусад төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод эвлэрүүлэн зуучлагчтай байх боломжтой зохицуулалт юм. Өөрөөр хэлбэл аливаа эрх зүйн маргаан нь өргөн хүрээтэй нийгмийн салбарыг хамарч байдаг онцлогтой тул маргааныг шийдвэрлэж буй этгээдээс өргөн хүрээний мэдлэг, уч чадварыг шаарддаг. Гэтэл энэ бүх цогц мэдлэг, ур чадварыг шүүгч, эвлэрүүлэн зуучлагч дангаараа бүрэн эзэмших боломжгүй бөгөөд маргааныг шийдвэрлэхдээ алдаа, дутагдал гаргах магадлалтай байдаг. Иймд аливаа байгууллага, мэргэжлийн холбоодод тухайн салбарын талаар мэдлэгтэй, туршлагатай, ур чадвартай хүнийг эвлэрүүлэн зуучлагчаар ажиллуулах замаар тухайн салбарын маргааныг шийдвэрлүүлэх нь оновчтой байх зорилгоор тус зохицуулалтыг хуульчилсан тул зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтэд хамааруулав.

Мөн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2-11.1.5 дахь заалтын хэрэгжилтийн хүрээнд эвлэрүүлэн зуучлагч бэлтгэх сургалт, давтан сургалт, ёс зүйн зөрчлийг хэрхэн шийдвэрлэж байгааг судлах зорилгоор сонгон авсан.

Түүнчлэн тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 30, 31, 32 дугаар зүйлүүдийн хэрэгжилтийг үнэлэнэ. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 30, 31, 32 дугаар зүйлүүд нь Иргэний хэрэг, Хөдөлөрийн эрх зүйн мрагаан, Гэр бүлийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаарх зохицуулалтууд юм.

Дээрх зохицуулалтууд нь маргааны төрөл тус бүрийн эвлэрүүлэн зуучлах ажиллагааны онцлог, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журмыг хуульчилсан. Өөрөөр хэлбэл маргаан тус бүрийн онцлогийг харгалзан эвлэрүүлэн зуучлах ажиллагааг амжилттай явуулахад чиглэгдсэн зорилготой гэж хэлж болно. Тухайлбал тус хуулийн 32 дугаар зүйлийн 32.4-т “Гэрлэгчдийг эвлэрүүлэх ажиллагаанд сэтгэл зүйч болон төрөл, садан, найз нөхөд, хамтран ажиллагдыг оролцуулж болно” гэж зааснаас үзвэл гэрлэгчдийг эвлэрэхэд илүү дэмжлэг болох бусад гуравдагч этгээдүүдийг оролцуулах боломжтой талаар заасан. Иймд дээрх зохицуулалтууд нь бодитоор зорилгodoо хүрч байгаа эсэх талаар судлах зорилгоор зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтэд хамааруулсан.

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл заалтууд:

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл заалтын агуулга
---	----------------------	----------------------

	5 дугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зорилго, үндсэн зарчим	5.2. Эвлэрүүлэн зуучлалыг дараах зарчимд үндэслэн явуулна: 5.2.1. талуудын сайн дурын үндсэн дээр хэрэгжих; 5.2.2. эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогчдын нууцыг хадгалах; 5.2.3. эвлэрүүлэн зуучлагч төвийг сахисан байр суурьтай байх; 5.2.4. эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд талууд тэгш эрхтэй оролцох.
2	7 дугаар зүйл. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч	7.1. Анхан шатны шүүх дээр орон тооны болон орон тооны бус эвлэрүүлэн зуучлагч ажиллана.
3	8 дугаар зүйл. Төрийн болон төрийн бус байгууллага дахь эвлэрүүлэн зуучлагч	8.1. Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу тухайн салбарын эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэх эвлэрүүлэн зуучлагчийг ажиллуулж болно.
4	11 дүгээр зүйл. Зөвлөлийн бүрэн эрх	11.1.2. эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх, давтан сургах сургалтын хөтөлбөрийг боловсруулах, сургалт зохион байгуулах; 11.1.3. эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулах, эрхийн гэрчилгээ олгох; 11.1.4. эвлэрүүлэн зуучлагчийг бүртгэх, нэrsийн жагсаалтыг олон нийтэд нээлттэй зарлах ажлыг зохион байгуулах; 11.1.5. эвлэрүүлэн зуучлагчийн эрхийг түдгэлзүүлэх, хасах, гэрчилгээг хүчингүй болгох, нэrsийн жагсаалтаас хасах;
5	30 дугаар зүйл. Иргэний хэрэгт эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх	30.1. Шүүхэд иргэний хэрэг маргаан үүсгэнээс хойш талууд хамтарч хүсэлт гаргасан, эсхүл шүүгч эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх нь зохистой гэж үзэж санал болгосныг талууд зөвшөөрсөн тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулж болно.
6	31 дүгээр зүйл. Хөдөлмөрийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа	31.1. Хөдөлмөрийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь ажил олгогч болон ажилтны хооронд гарсан хөдөлмөрийн ганцаарчилсан маргааны хүрээнд явагдана.
7	32 дугаар зүйл. Гэр бүлийн холбогдолтой маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа	32.4. Гэрлэгчдийг эвлэрүүлэх ажиллагаанд сэтгэл зүйч болон төрөл, садан, найз нөхөд, хамтран ажиллагсдыг оролцуулж болно.

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Практикт нийцэж байгаа байдал буюу хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтээр тухайн хуулийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эзрэг болон сөрөг үр дагаврууд, хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэлүүд байгаа эсэхийг тодорхойлдог. Энэхүү шалгуур үзүүлэлтээр Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн сонгон авсан зохицуулалтууд практикт нийцэж байгаа эсэх, тулгамдаж буй асуудлыг тодрлуулахад оршино.

Энэ хүрээнд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 9 дүгээр зүйл буюу Эвлэрүүлэн зуучлагчид тавигдах шаардлага, 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.5, 18.6, 20 дугаар зүйл буюу Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах хугацаа, 27 дугаар зүйл Эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангах зохицуулалтуудыг сонгон авч практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтээр үнэлэнэ.

Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл заалтууд:

1	9 дүгээр зүйл. Эвлэрүүлэн зуучлагчид тавигдах шаардлага	9.1. Энэ хуулийн 7, 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчид дараах шаардлага тавигдана:
		9.1.1. эрх зүйн бүрэн чадамжтай байх;
		9.1.2. дээд боловсролтой байх;
		9.1.3. эвлэрүүлэн зуучлагчийн сургалтад хамрагдан эрхийн гэрчилгээ авсан байх;
		9.1.4. эрх бүхий байгууллагын эвлэрүүлэн зуучлагчийн нэrsийн жагсаалтад бүртгэгдсэн байх;
		9.1.5. ял шийтгэлгүй байх.
2	14 дүгээр зүйл. Эвлэрүүлэн зуучлагчийн эрх, үүрэг	9.2. Эвлэрүүлэн зуучлагч нь үйл ажиллагаандын 10.1-д заасан Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлөөс баталсан ёс зүйн дүрэм болон бусад журмыг баримтлан ажиллана.
		14.1. Эвлэрүүлэн зуучлагч дараах эрх эдэлнэ:
3	18 дугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны нийтлэг үндэслэл	14.1.4. эвлэрүүлэн зуучлалд идэвхтэй оролцохыг талуудаас шаардах, талуудыг ганцаарчилсан болон хамтарсан уулзалтад дуудан ирүүлэх;
		18.5. Талууд эвлэрүүлэн зуучлалыг сонгосон, уг ажиллагаанд оролцсон байдал нь шүүхээс Иргэний хуулийн 79.1, 82.4-т заасны дагуу хөөн хэлэлцэх хугацааг сэргээх, эсхүл уг хугацааг тасалдсан гэж үзэх үндэслэл болно.
4	20 дугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах хугацаа	20.1. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг 30 хоногт багтаан явуулах бөгөөд талуудын хүсэлтээр энэ хугацааг нэг удаа сунгаж болно.
		27.1. Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ үүрэг гүйцэтгэгч биелүүлээгүй бол нөгөө тал

<p>гүйцэтгэлийг хангах</p>	<p>нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй.</p> <p>27.2.Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг тухайн шатны шүүгч баталгаажуулж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74.2, 74.6 дахь хэсэг, 75 дугаар зүйлд заасан журмын дагуу захирамж гаргана.</p> <p><u>/Энэ хэсэгт 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</u></p> <p>27.3.Энэ хуулийн 30.2-т заасны дагуу талуудын эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74.5-д заасны дагуу шийдвэрлэнэ.</p> <p><u>/Энэ хэсгийг 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/</u></p>
--------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэхдээ түүний хэрэгжилттэй холбоотой үүссэн асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран аль болох тохиромжтой харьцуулах хэлбэрийг сонгодог. Судалгааны багийн зүгээс дараах харьцуулах хэлбэрүүдийг сонгов.

- Байх ёстой болон одоо байгаа - хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар (одоо байгаа нөхцөл байдал)-ыг бодитой хэмжиж, тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хууль тогтоомжоор тогтоосон шаардлага, норм, хугацаа, давтамж, хэмжиж болохуйц тодорхой тоогоор илэрхийлэгдсэн тоон үзүүлэлттэй харьцуулах хэлбэрээр хууль тогтоомжийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтооно.
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш - хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль тогтоомж хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах нөхцөл байдал буюу хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад гарч байгаа үр дагавартай харьцуулан дүн шинжилгээ хийнэ.
- Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш-хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар судалж тогтооход чиглэгдэнэ..

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

№	Үнэлгээ хийх зүйл заалт	Тогтоосон шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэр	Шалгуур үзүүлэлтийг томьёолох

1	8.1.Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу тухайн салбарын эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэх эвлэрүүлэн зуучлагчийг ажиллуулж болно.	Зорилгод хүрсэн түвшин. Тухайн салбарын мэдлэгтэй, мэргэжлийн эвлэрүүлэн зуучлагчаар маргааныг шийдвэрлэх зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх.	Шүүх дэх эвлэрүүлэн зуучлал болон шүүхээс бусад төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилттай хэрэгжиж байгаа эсэх.	Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилттай хэрэгжиж байгаа эсэх.
2	9.1.Энэ хуулийн 7, 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчид дараах шаардлага тавигдана: 9.1.1.эрх зүйн бүрэн чадамжтай байх; 9.1.2.дээд боловсролтой байх; 9.1.3.эвлэрүүл эн зуучлагчийн сургалтад хамрагдан эрхийн гэрчилгээ авсан байх; 9.1.4.эрх бүхий байгууллагын эвлэрүүлэн зуучлагчийн нэrsийн жагсаалтад бүртгэгдсэн байх; 9.1.5.ял шийтгэлгүй байх.	Практикт нийцэж байгаа эсэх. Эвлэрүүлэн зуучлагчид тавигдах шаардлага практикт нийцэж байгаа эсэх. Маргааны төрлөөс хамааран эвлэрүүлэн зуучлалаар үйлчлүүлэгч болон эвлэрүүлэн зуучлагч, шүүгчтэй ярилцлага хийх.	Иргэн, хөдөлмөр, гэр бүлийн эрх зүйн маргааныг шийдвэрлэж буй тоо баримтад дүн шинжилгээ хийх. Эвлэрүүлэн зуучлалаар үйлчлүүлэгч болон эвлэрүүлэн зуучлагч, шүүгчтэй ярилцлага хийх.	Эвлэрүүлэн зуучлагчид тавигдах шаардлага ба эвлэрүүлэн зуучлагчийн хэрэг маргааныг шийдвэрлэх ур чадварт нийцэж байгаа эсэх.
3	14.1.Эвлэрүүлэн зуучлагч дараах эрх эдэлнэ:	Практикт нийцэж буй эсэх. Хуульд	Хууль тогтоомжид дүн шинжилгээ хийх.	Эвлэрүүлэн зуучлагчид талуудыг албадан

	<p>14.1.4.эвлэрүүлэн зуучлалд идэвхтэй оролцохыг талуудаас шаардах, талуудыг болон ганцаарчилсан хамтарсан уулзалтад дуудан ирүүлэх;</p>	<p>заасан эвлэрүүлэн зуучлагчийн эрх хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагаанд бүрэн хэрэгжиж байгаа эсэх. Эрх хэмжээ олгогдоогүйгээс маргааныг шийдвэрлэхэд саад болж буй эсэх.</p>	<p>Эвлэрүүлэн зуучлагчтай ярилцлага хийх.</p>	<p>ирүүлэх эрх хэмжээгүй нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд саад болох буюу практикт нийцэж буй эсэх.</p>
4	<p>18.5.Талууд эвлэрүүлэн зуучлалыг сонгосон, уг ажиллагаанд оролцсон байдал нь шүүхээс Иргэний хуулийн 79.1, 82.4-т заасны дагуу хөөн хэлэлцэх хугацааг сэргээх, эсхүл уг хугацааг тасалдсан гэж үзэх үндэслэл болно.</p> <p>18.6.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үед талуудын гаргасан аливаа тайлбар нь шүүхээр маргааныг хянан шийдвэрлэхэд нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэхгүй.</p>	<p>Практикт нийцэж байгаа эсэх. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад хөөн хэлэлцэх хугацаа тасалдсаныг тогтооход шаардлага хангахуйц байдлаар эвлэрүүлэн зуучлах ажиллагааны материал хадгалагдаж байгаа эсэх. Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн</p>	<p>Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль болон холбогдох бусад дүрэм журмуудад шинжилгээ хийх. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч болон эвлэрүүлэн зуучлагчийн туслах, бусад байгууллага дахь эвлэрүүлэн зуучлагч, хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийх.</p>	<p>Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны баримт материалын хадгалалт, бүртгэл нь тухайн маргааны хөөн хэлэлцэх хугацаа тасалдсныг тогтоох боломжтой байгаа эсэх.</p>

		зуучлалд материалыг хадгалах, баримтжуулах тогтолцоо бүрдсэн эсэх.		
5	<p>20.1. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг 30 хоногт багтаан явуулах бөгөөд талуудын хүсэлтээр энэ хугацааг нэг удаа сунгаж болно.</p> <p>20.2. Энэ хуулийн 30.1-д заасны дагуу явуулах эвлэрүүлэн зуучлах ажиллагааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 71.1-д заасан хугацааны дотор явуулна.</p>	<p>Практикт нийцэж буй эсэх.</p> <p>Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулахад хуульд заасан 30 хоногийн хугацаа хангалттай эсэх.</p> <p>30 хоногийн хугацаанд талуудыг эвлэрүүлэх хэмжээний арга уулзалт зохион байгуулах, бусад арга хэмжээг хангалттай авч чадаж байгаа эсэх.</p>	<p>Эвлэрүүлэн зуучлагч, тус ажиллагаанд оролцдог өмгөөлөгч, үйлчлүүлсэн иргэдээс анкет судалгаа авах.</p> <p>Холбогдох хүмүүстэй ярилцлага хийх, эвлэрүүлэн зуучлалаар амжилттай шийдвэрлэгдсэн болон амжилтгүй болсон хэргүүдэд дүн шинжилгээ хийх.</p>	<p>30 хоногт багтаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулах нь маргааныг үр дүнтэй шийдвэрлэх хангалттай хугацаа мөн эсэх. Эвлэрүүлэн зуучлагч өөрийн санаачилгаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах хугацаа сунгах боломжгүй нь эвлэрэл амжилтгүй боловод нөлөөлж буй эсэх.</p>
6	<p>27.1. Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ үүрэг гүйцэтгэгч биелүүлээгүй бол нөгөө тал нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй.</p>	<p>Практикт нийцэж буй эсэх. Шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалаас бусад байгууллага дахь эвлэрүүлэн зуучлалаар</p>	<p>Өмгөөлөгчдийн холбоо, MXAYT- ийн дэргэдэх бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төвийн болон бусад байгууллалга дахь эвлэрүүлэн зуучлагчтай</p>	<p>Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг</p>

		маргааныг амжилттай шийдвэрлүүлж, эвлэрлийн гэрээ байгуулсан ч шүүхийн шийдвэрийн нэгэн адил үүргийн гүйцэтгэлийг албадан гүйцэтгэх боломжгүй нь практикт нийцэж буй эсэх.	ярилцлага хийх. Эвлэрүүлэн зуучлагч, өмгөөлөгч, шүүгч, үйлчлүүлсэн иргэдээс анкет судалгаа авах.	шүүгчийн захирамжаар баталгаажулахгүй, үүргийн гүйцэтгэлийг албадан гүйцэтгэх боломжгүй нь практикт нийцэж буй эсэх.
7	<p>30.1.Шүүхэд иргэний хэрэг маргаан үүсгэснээс хойш талууд хамтарч хүсэлт гаргасан, эсхүл шүүгч эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх нь зохистой гэж үзэж санал болгосныг талууд зөвшөөрсөн тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулж болно.</p> <p>30.3.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтад хүрээгүй дуусгавар болсон тохиолдолд шүүх хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэнэ.</p> <p>30.4.Нэхэмжлэлийн хэд хэдэн шаардлагад иргэний хэрэг үүсгэсэн тохиолдолд талууд бүх шаардлага, эсхүл аль нэг буюу хэд хэдэн шаардлагын талаар эвлэрүүлэн зуучлагчийн туслалцааг ашиглаж болно.</p>	Зорилгодоо хурсэн түвшин.	Эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэгдсэн иргэний эрх зүйн маргааны тоо баримтад дүн шинжилгээ хийх. Анкет судалгаа авах, ярилцлага хийх.	Иргэний эрх зүйн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хэрэгжилт хангалттай байгаа эсэх. Шүүхийн шатанд болон шүүхээс өмнөх шатанд хэрэг маргааныг эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр амжилттай шийдвэрлэж буй хэргийн тоо зорилгодоо хүрч байгаа эсэх.

	<p>30.5.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талууд эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр нэхэмжлэлийн зарим шаардлагын талаар хоорондоо эвлэрсэн тохиолдолд эвлэрлийг тухайн маргааныг эцэслэн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт тусгана.</p> <p>30.6.Иргэний хэрэг үүсгэснээс хойш явагдах эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хугацааг шүүгч тогтооно.</p>			
8	<p>31.1.Хөдөлмөрийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь ажил олгогч болон ажилтны хооронд гарсан хөдөлмөрийн ганцаарчилсан маргааны хүрээнд явагдана.</p> <p>31.2.Хөдөлмөрийн эрх зүйн маргааныг Хөдөлмөрийн тухай хуулийн 126.1-д заасан хөдөлмөрийн маргаан таслах комиссоор хянан шийдвэрлэсэн нь тухайн маргааныг Хөдөлмөрийн тухай хуулийн 127.1-д заасны дагуу шүүх хянан шийдвэрлэхдээ эвлэрүүлэн зуучлах ажиллагааг ашиглахад саад болохгүй.</p>	Зорилгод хүрсэн түвшин.	Эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэгдсэн хөдөлмөрийн ганцаарчилсан маргааны тоо баримтад дүн шинжилгээ хийх. Анкет судалгаа авах, ярилцлага хийх.	Хөдөлмөрийн ганцаарчилсан маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хэрэгжилт хангалттай байгаа эсэх. Шүүхийн шатанд болон шүүхээс өмнөх шатанд хэрэг маргааныг эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр амжилттай шийдвэрлэж буй хэргийн тоо зорилгодоо хүрч байгаа эсэх.
9	32.1.Энэ хуулийн 6.3-т заасан шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журмын дагуу явуулсан эвлэрүүлэн зуучлах	Зорилгод хүрсэн түвшин.	Эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэгдсэн иргэний эрх зүйн маргааны тоо	Гэр бүлийн эрх зүйн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны

<p>ажиллагаа амжилтгүй болсон нь шүүхэд иргэний хэрэг үүсгэнээс хойш гэр бүлийн холбогдолтой маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дахин явуулахаас татгалзах үндэслэл болохгүй.</p> <p>32.2.Шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.1-д заасан гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, эсхүл талуудын сонгосон эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжүүлнэ.</p> <p>32.3.Шүүхээс тогтоосон хугацаанд гэрлэгчид эвлэрээгүй бол шүүх гэрлэгчдийн хооронд үүссэн гэрлэлт цуцлахаас бусад тэтгэвэр, тэтгэлэг, тэтгэмж, дундын хөрөнгө хуваахтай холбогдсон маргаанд шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, эсхүл гэрлэгчдийн сонгосон эвлэрүүлэн зуучлагчийг оролцуулж болно.</p> <p>32.4.Гэрлэгчдийг эвлэрүүлэх ажиллагаанд сэтгэл зүйч болон төрөл, садан, найз нөхөд, хамтран ажиллагсдыг оролцуулж болно.</p>		<p>баримтад дүн шинжилгээ хийх. Анкет судалгаа авах, ярилцлага хийх.</p>	<p>хэрэгжилт хангалттай байгаа эсэх. Шүүхийн шатанд болон шүүхээс өмнөх шатанд хэрэг маргааныг эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр амжилттай шийдвэрлэж буй хэргийн тоо зорилгодоо хүрч байгаа эсэх</p>
----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--	--------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох болон судлагдсан байдал

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний аргачлалын 3.7-д заасны дагуу Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгааг гүйцэтгэхдээ дараах үндсэн аргуудыг ашиглав.

- Бэлэн байгаа мэдээллийг цуглуулахдаа тухайн хууль тогтоомжийг хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, тухайн сэдвээр гарсан мэргэжлийн ном,

товхимол, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эх сурвалжийг ашиглах;


- Холбогдох субъектээс судалгаа авах: тухайн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулж байгаа болон чиг үүргээрээ түүнтэй холбоотой төрийн байгууллага, албан хаагч, хуулийн хэрэгжилтэд өртөж байгаа иргэн, хуулийн этгээдээс мэдээлэл цуглуулахын тулд анкетын болон ярилцлагын аргыг ашиглах. Мөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар холбогдох байгууллагаас албан ёсоор тайлан, судалгаа, бусад мэдээлэл (тухайн байдлын чанарын үзүүлэлт)-ийг гаргуулж авсан.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

2.1. Судалгааны арга зүй, мэдээлэл цуглуулсан зохион байгуулалт


Судалгааг гүйцэтгэхдээ Захиалагчаас өгсөн Ажлын даалгаврын дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын Хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх аргачлал”-ыг баримталсан болохыг дээр дурдсан билээ. Ингэхдээ хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхэд шаардлагатай мэдээллийг цуглуулахдаа 1) Анкетын арга, 2) Ярилцлагын арга, 3) Баримт бичигт анализ хийх аргыг ашиглан судалгааны мэдээллийг цуглуулав.

Бүдүүч 1. Судалгааны ажлын арга зүйн зураглал




Судалгааны бэлтгэл үе шат

- Судалгааны хөтөлбөр боловруулах
- Судалгааны хэрэглэгдэхүүн боловсруулах
- Тайлангийн бүтэц гаргах
- Баримт бичгийн судалгаа хийх



Мэдээлэл цуглуулалтын үе шат

- IDI Ганцаарчилсан ярилцлага
- SURVEY Асуултын буюу тоон судалгаа
- Программд өгөгдлийг оруулах
- Өгөгдлийг боловсруулах
- Үр дүнг тооцох
- Явцын тайлан бэлтгэх



Тайлagnah үе шат

- Тоон судалгаанд дүн шинжилгээ хийх
- Чанарын судалгааг хэв загвар, бүлэглэл хийх, шигтээ, кейс
- Судалгааны хураангуй болон дэлгэрэнгүй тайлан бэлтгэх
- Хавсралт материалыуд
- Мэдээллийн дата бааз
- Эцсийн тайлан

Судалгааны мэдээлэл цуглуулах арга

Судалгааны мэдээлэл цуглуулах үндсэн арга нь асуумж судалгааны болон ярилцлагын арга байх бөгөөд үүний зэрэгцээ боломжит бүхий л эх сурвалжаас мэдээлэл цуглуулах зорилт тавьж ажиллаа. Ингэснээр олон талын байр суурь, санал бодол,

мэдээллүүдийг нэгтгэн дүгнэх бололцоотой болох ба судалгааны үр дүн илүү бодитой гарах болно.

Судалгаанд тоон ба чанарын судалгааны аргуудыг хэрэглэнэ. Ямар эх сурвалжаас ямар төрлийн мэдээлэл авахаас шалтгаалан нийгмийн судалгааны мэдээлэл цуглуулах тохиорох аргыг хэрэглэнэ. Анхдагч мэдээлэл цуглуулах дараах аргуудыг ашиглана. Үүнд:

- Асуумж судалгааны арга (анкет);
- Ярилцлагын арга (ганцаарчилсан);
- Статистик ба баримт бичиг судлах аргуудыг ашиглан мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийнэ.

Асуумж судалгааны арга (анкет): Анкетын арга нь олон нийтийн санаа бодол, хүсэл эрмэлзэл, хандлага, үнэлгээг тодорхойлоход хамгийн тохиромжтой мэдээлэл цуглуулах үндсэн арга билээ.

Анкетын судалгааны мэдээллийг PAPI буюу нүүр тулсан (Paper and Pen Interviewing) болон CAPI буюу цахим (Computer-assisted program interviewing) хэлбэрээр авах бөгөөд анкетын судалгааны явцад илэрсэн онцлог кейс бүхий, үнэ цэнэтэй мэдээлэл өгөх респонденттэй ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулсан.

Ганцаарчилсан ярилцлагын арга: Ганцаарчилсан ярилцлагын арга нь анкетын аргаар авсан мэдээллийн учир шалтгаан, мөн чанар, дотоод зүй тогтлыг илэрхийлэн гаргахад ихээхэн үр дүнтэй байдаг. Тиймээс энэхүү судалгаанд ганцаарчилсан ярилцлагын аргаар анкетын судалгааны мэдээллийг гүнзгийрүүлэн шалгах, учир шалтгааныг нь тодорхойлох мэдээллүүдийг цуглуулсан.

Баримт бичгийн шинжилгээний арга: Энэхүү судалгаанд холбогдох баримт бичгүүдийг дараах ангилалд оруулан шинжилгээ хийхээр төлөвлөсөн.

Анкет (Санал асуулга) түүвэрлэлт

Ажлын даалгаврын 2.1.6-д заасны дагуу 2020 оны 1 дүгээр сарын 20-ны өдрөөс 2 дугаар сарын 5-ны өдөр хүртэл нийт 21 аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, 8 суман дахь Сум дундын шүүх, 7 дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх болон тус шүүхүүд дэх Эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах, эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцдог өмгөөлөгч, хуульчдаас нийт 223 анкетын судалгааг авсан. Түүнчлэн дээрх аймгуудын иргэдээс нийт 169 санал асуулгыг авсан. Нийт Анкетын судалгаанд 169 иргэн, 223 Эвлэрүүлэн зуучлагч, Эвлэрүүлэн зуучлагчийн туслах, шүүгч, өмгөөлөгч, хуульч нар оролцсон байна. Үүнээс:

Хүснэгт 1. Анкетын судалгаанд оролцогчийн тоо, эрх зүйн байдал

№	Утга	Тоо
1	Шүүгч	79
2	Эвлэрүүлэн зуучлагч	40
3	Эвлэрүүлэн зуучлагчийн туслах	28
4	Өмгөөлөгч, хуульч	76

Ярилцлагын түүвэрлэлт

Ажлын даалгаврын 2.1.4, 2.3-т заасны дагуу одоогийн байдлаар б 6 эвлэрүүлэн зуучлагч, 6 шүүгч, өмгөөлөгч, MYXAYT-ын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх алба, Татварын ерөнхий газар, банк, санхүү, даатгалын салбарын холбогдох хүмүүстэй нүүр тулж ярилцах болон онлайнаар ярилцлага хийсэн.

Хүснэгт 2. Ярилцлага хийсэн хүн, ярилцлагын арга

№	Корреспондент	Арга	
1	Эвлэрүүлэн зуучлагч	Золзаяа Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч Мөнхсайхан Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч Мөнхтүвшин Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч Баттуяа Дорноговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч Алимаа Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх Төрөмголан Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч	Нүүр тулж ярилцсан Онлайнаар холбогдож ярилцсан
2	Шүүгч	Оюунтуяа Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Алтанцэцэг Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Оюударь Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Уртнасан Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн шүүгч Эрдэнэзуу Сүхбаатар аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Үйтүмэн Говь-Алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	Нүүр тулж ярилцсан Онлайнаар холбогдож ярилцсан

3	Өмгөөлөгч	3.Сүхбаатар Монгол өмгөөлөгч ХХН-ийн Нүүр тулж ярилцсан гүйцэтгэх захирал, партнер Л.Өлзийхүү Монголын Өмгөөлөгчдийн Холбоо, Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульч, өмгөөлөгч
4	Их сургууль	С.Болормаа МУИС ХЗС-ийн Хувийн эрх Нүүр тулж ярилцсан зүйн тэнхимийн дэд профессор, доктор
4	Татварын ерөнхий газар	Б.Баттогтох Хуулийн хэрэгжилтийг хангах Нүүр тулж ярилцсан газрын Татварын улсын байцаагч, хуулийн мэргэжилтэн
5	МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитр	М.Шинэбаяр Ерөнхий нарийн бичгийн Нүүр тулж ярилцсан дарга Н.Батдорж МҮХАҮТ-ийн дэргэдэх БМЭЗ төвийн эвлэрүүлэн зуучлагч
6	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх алба	Ч.Өнөрцэцэг Шийдвэр гүйцэтгэх албаны Нүүр тулж ярилцсан Мэргэжлийн удирдлагын хэлтсийн дарга, дэ хурандаа П.Хадбаатар Мэдээлэл, лавлагаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга, ахмад
7	Бодь даатгал, Багдбанк	P.Нямцэрэн Хуулийн хэлтсийн дарга Онлайнаар холбогдож ярилцсан

Баримт бичгийн анализ

2014 оноос эхлэн Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч ажиллаж эхэлснээс хойш 2019 он хүртэлх Шүүн таслах ажиллагааны тайлан болон холбогдох бусад эх сурвалжуудад дүн шинжилгээ хийсэн.

Хууль тогтоомж

- Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль;
- Иргэний хууль;
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль;
- Гэр бүлийн тухай хууль;
- Хөдөлмөрийн хууль;
- Арбитрын хууль;
- Шүүхийн тухай хууль;
- Шүүхийн захиргааны хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмуудад шинжилгээ хийсэн.

Судалгааны материал

- Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн мониторингийн судалгаа 2015 он;
- Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн онолын тайлбар;
- 2014-2019 он хүртэлх Шүүн таслах ажиллагааны дүн мэдээлэл;
- Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн тайлан 2013-2019 он;

2.2. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлт

График 1. Судалгаанд оролцогчдын эрх зүйн байдал




Судалгаанд нийт 392 хүн оролцсоноос 169 иргэн, 223 Эвлэрүүлэн зуучлагч, түүний туслах, өмгөөлөгч, хуульч байна.

Хүснэгт 3. Судалгаанд оролцогчдын эрх зүйн байдал, нас, туршилага, хүйс

ЭЗ, ЭЗ-ын туслах, Шүүгч, Өмгөөлөгч, Хуульч				Иргэн		
№	Ажилласан жил	Тоололт	Хувь	Нас	Тоололт	Хувь
1	1 хүртэл	29	13.2	19-35 настай	72	42.9
2	1-5 жил	88	40.2	35-45 настай	54	32.1
3	6-10 жил	53	24.2	46-55 настай	30	17.9
4	10-аас дээш жил	49	22.4	56-аас дээш настай	12	7.1
Нийт		219	100.0		168	100.0
Хүйс						
1	Эрэгтэй	75	33.9	Эрэгтэй	68	41.5
2	Эмэгтэй	146	66.1	Эмэгтэй	96	58.5

Судалгаанд оролцсон эвлэрүүлэн зуучлах, туслах, шүүгч, өмгөөлөгчдийн 13.2 хувь нь 1 хүртэл, 40.2 хувь нь 1-5 жил, 24.2 хувь нь 6-10 жил, 22.4 хувь нь 10-аас дээш жил тус тус өөрсдийн мэргэжлийн чиглэлээрээ ажилласан байна. Тэдний 33.9 хувь эрэгтэй 66.1 хувь нь эмэгтэй байна. Харин иргэдийн хувьд 42.9 хувь нь 19-35 настай, 32.1 хувь нь 35-45 настай, 17.9 хувь нь 46-55 настай, 7.1 хувь нь 56-аас дээш настай бол тэдний 41.5 хувь эрэгтэй, 58.5 хувь нь эмэгтэй байна.

График 2. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцсон туршлага /Эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах, шүүгч, өмгөөлөгч, хуульч/



Эвлэрүүлэн зуучлагч, туслах, шүүгч, өмгөөлөгч нарын эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд ажилласан байдлыг тандаж үзвэл судалгаанд оролцогчдын 18 хувь нь 1 жил хүртэл, 14 хувь нь 1-2 жил хүртэл, 24 хувь нь 3-4 жил, 44 хувь нь 5-аас дээш жил ажилласан байна. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлал үйл ажиллагаа явуулж эхлээд 6 жил болж байгаа гэж үзвэл харьцангуй туршлагатай хүмүүс энэ удаагийн судалгаанд оролцсон гэж үзэж болохоор байна.

Хүснэгт 4. Санал асуулгад оролцсон иргэдийн эвлэрүүлэн зуучлалаар шийдвүүлсэн маргааны төрөл

№	Утга	Тоололт	Хувь
1	Зээл, гэрээтэй холбоотой маргаан	115	67.9
2	Эд хөрөнгийн маргаан	9	5.4
3	Өв залгамжлалын маргаан	5	3.0
4	Бизнесийн маргаан	7	4.2
5	Гэрлэлт цуцлалт	23	13.7
6	Хүүхэд үрчлэх	0	0.0
7	Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн маргаан	0	0.0
8	Гэр бүлийн хүчирхийлэл	1	.6
9	Цалин хөлс шаардах	2	1.2
10	Ажлаас үндэслэлгүй халагдах	0	0.0
11	Сахилгын шийтгэл ногдуулах	0	0.0
12	Тэтгэвэр, тэтгэмж нэхэмжлэх	7	4.2

Иргэд шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хандаадаа ямар төрлийн маргаанаар ихэвчлэн ханддаг талаар тандаж үзвэл, тэдний дийлэнх нь буюу 67.9 хувь нь зээл болон бусад төрлийн гэрээтэй холбоотой маргаан байна. Дараа нь 13.7 хувь нь гэрлэл цуцлалт, 5.4 хувь нь эд хөрөнгийн маргаан, 4.2 хувь нь тэтгэвэр, тэтгэмж нэхэмжлэх, мөн 4.2 хувь нь бизнесийн маргаан, 1.2 хувь нь цалин хөлс шаардах маргаанууд байдаг бол ажлаас үндсэлэлгүй халагдах, сахилгын шийтгэл ногдуулах, хүүхэд үрчлэх, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн маргаан зэргээр тэр болгон эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хандаад байдаггүй байна.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

1. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааны хэрэгжилт

Сонгосон зүйл, заалт	Зүйл заалтын агуулга
7 дугаар зүйл. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч	<p>7.1. Анхан шатны шүүх дээр орон тооны болон орон тооны бус эвлэрүүлэн зуучлагч ажиллана.</p> <p>7.2. Энэ хуулийн 7.1-д заасан эвлэрүүлэн зуучлагчийн үйл ажиллагааны зохион байгуулалт, хүний нөөцийн удирдлагыг Шүүхийн ерөнхий зөвлөл болон тухайн шүүхийн тамгын газар хариуцаж, холбогдох төсвийг тухайн шүүхийн төсвөөс гаргана.</p>

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиар Монгол Улсад шүүх дэх эвлэрүүлэн зуучлал, төрийн болон төрийн бус байгууллага дахь эвлэрүүлэн зуучлал гэсэн холимог загвар хэрэгжихээр тогтоосон.³ Үүний дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл (цаашид “ШЕЗ” гэх) иргэний хэргийн анхан шатны 38 шүүхэд ажиллах 44 эвлэрүүлэн зуучлагийг сонгон бүртгэж, шүүхийн тамгын газрын даргын тушаалаар томилжээ.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 3.3-т “Эвлэрүүлэн зуучлалыг шүүхэд иргэний хэрэг, арбитрт маргаан үүсгэнээс хойш хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэж болно”, 6.2-т “Шүүх маргалдагч талуудад эвлэрүүлэн зуучлалын талаарх мэдээллийг бүрэн өгч, шүүхэд иргэний хэрэг үүсгэхээс өмнө болон хойно, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шат бүрд талуудыг эвлэрэх боломжоор хангаж, эвлэрүүлэн зуучлагчийн туслалцаа авах талаар сануулах үүрэгтэй” гэж заасны дагуу эвлэрүүлэн зуучлах ажиллагааг дараах үе шатуудад хэрэглэх боломжтой.

- Шууд эвлэрүүлэн зуучлагчид өргөдөл гаргах;
- Шүүхэд нэхэмжлэл гаргасан боловч иргэний хэрэг үүсгэхээс өмнө шүүхээс эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлсэн өргөдөл, маргаан;
- Иргэний хэрэг үүсгэсний дараа шүүхээс эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлсэн өргөдөл маргаан;

Өөрөөр хэлбэл талууд шүүхийн шатанд ч гэсэн эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх боломж бүрэн нээлттэй байхаас гадна шүүхээс талуудын маргааныг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлүүлэхээс санал болгох, зарим төрлийн хэрэг маргаанд заавал

³ Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн тайлан 2013-2019. 1 дэх тал

эвлэрүүлэн зуучлалаар орсны дараагаар нэхэмжлэлийг хүлээн авдаг. Тэгвэл дээрх үе шатууд дахь эвлэрүүлэн зуучлах маргааны тоо, маргааны төрлийг авч үзье.

Нийт эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлүүлсэн 51,474 иргэний эрх зүйн маргаан шийдвэрлэснээс 51,058 буюу 99 хувь нь шууд эвлэрүүлэн зуучлалд хандсан маргаан байгаа бол 463 хөдөлмөрийн ганцаарчилсан маргааны 435 маргаанд, гэр бүлийн эрх зүйн 18,552 маргааны 16,734 маргаан нь шууд эвлэрүүлэн зуучлалд хандаж өргөдөл гаргасан маргаан эзэлж байна.

Хүснэгт 5. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд шууд хандсан өргөдөл, маргааны төрлөөр (2014-2019 он)

№	2014-2019 он нийтдээ	Иргэний эрх зүйн маргаан	Хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан	Гэр бүлийн эрх зүйн маргаан	Нийт	
					маргаан	маргаан
1	Шийдвэрлэсэн	51085	435	16734	68254	
2	Эвлэрэл амжилттай болсон	45013	311	2263	47587	
3	Эзлэх хувь	88.1%	71.5%	13.5%	69.7	

Үүнээс үзэхэд эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэсэн нийт маргаанаас иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн эрх зүйн маргааны 99-өөс дээш хувь нь шууд эвлэрүүлэн зуучлалд ханддаг бол гэр бүлийн эрх зүйн маргааны шууд эвлэрүүлэн зуучлалд хандсан өргөдлийн тоо иргэний эрх зүйн болон хөдөлмөрийн эрх зүйн маргаантай харьцуулахад бага байна.

Хүснэгт 6. Иргэний хэрэг үүсгэхээс өмнө шүүхээс эвлэрүүлэн зуучлалд шилжүүлсэн өргөдөл, маргаан (2014-2019 он)

№	Үзүүлэлт	Иргэний эрх зүйн маргаан	Хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан	Гэр бүлийн эрх зүйн маргаан	Нийт	
					маргаан	маргаан
1	Шийдвэрлэсэн	74	0	69	143	
2	Эвлэрэл амжилттай болсон	67	0	7	74	
3	Эзлэх хувь	90.5%		10.1%	51.7%	

Харин шүүхээс иргэний хэрэг үүсгэхээс өмнө эвлэрүүлэн зуучлалд шилжүүлсэн өргөдлийн тоо 74, хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан байхгүй, гэр бүлийн эрх зүйн маргааны 69 өргөдөл байна.

Хүснэгт 7. Иргэний хэрэг үүсгэсний дараа шүүхээс эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлсэн өргөдөл, маргаан (2014-2019 он)

№	Үзүүлэлт	Иргэний эрх зүйн маргаан	Хөдөлмөрийн эрх зүйн маргаан	Гэр бүлийн эрх зүйн маргаан	Нийт
1	Шийдвэрлэсэн	315	28	1749	2092
2	Эвлэрэлт амжилттай болсон	113	12	287	412
3	Эзлэх хувь	35.9%	42.9%	16.4%	19.7%

Иргэний хэрэг үүсгэсний дараа шүүхээс эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлсэн өргөдөл, маргааны тоо иргэний эрх зүйн маргаан 315, хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан 28, гэр бүлийн эрх зүйн маргаан 1749 байгаа нь гэр бүлийн эрх зүйн маргаанд шүүгчээс талуудыг эвлэрүүлэх арга хэмжээ болгон эвлэрүүлэн зуучлагчид хэргийг шилжүүлэх явдал түгээмэл байна.

Гэсэн хэдий ч шүүх дэх Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хэрэгжсэн 6 жилийн нэгтгэсэн дунгээр авч үзвэл нийт 223,468 иргэний хэргээс 47,587 хэрэг буюу дунджаар нийт иргэний хэргийн 17.2 хувийг эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар амжилттай шийдвэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл энэ хэмжээгээр иргэний хэргийн шүүхийн ачааллыг багасгах, талууд харилцан тохиролцож маргааныг шийдвэрлүүлсэн ач холбогдолтой юм.

Хүснэгт 8. Иргэний хэрэгт эвлэрүүлэн зуучлах ажиллагааны эзэлж буй жин, ачаалал бууруулж буй хувь (2014-2019 он)

№	Он	Шийдвэрлэсэн иргэний хэрэг	Амжилттай шийдвэрлэсэн эвлэрүүлэн зуучлалын өргөдөл	Иргэний хэрэгт эзлэх жин
				эзлэх жин
1	2014 он	32181	2847	8.1%
2	2015 он	35493	7881	18.2%
3	2016 он	39773	8908	18.3%
4	2017 он	37271	10013	21.2%
5	2018 он	41363	8711	17.4%
6	2019 он	37387	9227	19.8%
	Нийт	223468	47587	17.2%

Иймд шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаа үр дүнтэй сайн явагдаж байгаа гэж дүгнэж байна. Түүнчлэн судалгааны багийн зүгээс өмнө дурдсанчлан нийт 223 мэргэжилтэн буюу 38 шүүх дэх нийт 44 эвлэрүүлэн зуучлагч, шүүгч, туслах, өмгөөлөгч, 169 иргэдээс авсан анкетын судалгаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд тулгарч буй саад бэрхшээл, хуулийн хэрэгжилтийн талаар хэрхэн үнэлснийг танилцуулья.

График 3. Эвлэрүүлэн зуучлалд хандаж буй маргааны төрөл /эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах, шүүгч, өмгөөлөгч, хуульчийн хариулт/




Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хандаж буй өргөдөл маргааныг төрлөөр ангилан үзвэл зээл болон бусад төрлийн гэрээтэй холбоотой маргаан, гэрлэлт цуцалтын маргаан дийлэнх буюу 70-90 гаруй хувийг эзэлж байна. Бусад төрлийн маргаанууд нь 20 хүрэхгүй хувийг эзэлдэг гэж маргалдагч талуудаас бусад оролцогчид үзжээ.

Хүснэгт 9. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилттай болон амжилтгүй шийдвэрлэгддэг хувь (маргааны төрлөөр) (шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах, өмгөөлөгч, хуульчийн хариулт)

№	Маргааны төрөл	Амжилттай	Амжилтгүй
1	Зээл, гэрээтэй холбоотой маргаан	96.8%	19.8%
2	Эд хөрөнгийн маргаан	21.4%	15.1%
3	Өв залгамжлалын маргаан	.9%	8.0%
4	Бизнесийн маргаан	13.2%	10.4%
5	Гэрлэлт цуцалт	25.5%	65.1%
6	Хүүхэд үрчлэх	2.3%	3.3%
7	Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн маргаан	10.5%	20.8%
8	Гэр бүлийн хүчирхийлэл	3.2%	15.1%
9	Цалин хөлс шаардах	8.6%	2.8%
10	Ажлаас үндэслэлгүй халагдах	5.0%	14.6%
11	Сахилгын шийтгэл ногдуулах	1.8%	7.1%
12	Тэтгэвэр, тэтгэмж нэхэмжлэх	3.6%	6.6%
13	Бусад	5.5%	2.8%

Хүснэгтэд байх маргааны төрлүүдийг амжилттай болон амжилтгүй шийдвэрлэгддэг төрлүүдийг тандаж үзвэл шүүхийн эвлэрүүлэн зуучлагч, туслах, шүүгч, өмгөөлөгч нар үзэхдээ зээл, гэрээтэй холбоотой маргаан дийлэнх нь эвлэрдэг бол гэрлэлт цуцалт, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн маргаан эвлэрэхгүй байх тохиолдол их гэж үзжээ.

График 4. Эвлэрэлт амжилттай болон амжилтгүй болоход нөлөөлж буй хүчин зүйлс (Эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах, шүүгч, өмгөөлөгчийн хариулт)




Эвлэрүүлэн зуучлагч, туслах, шүүгч, өмгөөлөгч нар эвлэрэл амжилттай болох шалтгааныг хамгийн түрүүнд эвлэрүүлэн зуучлагчийн ур чадвартай холбож үзэж байгаа бол дараа нь талуудын эвлэрэх хүсэл, маргааны агуулга, нэхэмжлэлийн үнийн дүн зэргийн дурьдсан бол амжилтгүй болох шалтгааны хамгийн эхэнд талуудын хүсэл зориг гэж үзсэн бол дараа нь уригдагч талыг албадан ирүүлэх боломжгүйтэй холбоотой, түүнчлэн гэр бүлийн маргааныг заавал эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлүүлэхээр заасан учир тэр нь амжилтгүй болж байгаа ажиллагаа болоод тоологдоод явдаг гэж үзжээ. Харин иргэдийн хувьд дараах байрь суурьтай байна. Үүнд:

График 5. Эвлэрэл амжилттай болон амжилтгүй болоход нөлөөлж буй хүчин зүйлс (иргэдийн хариулт)



Судалгаанд хамрагдсан иргэд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилттай болон амжилтгүй болдог шалтгааныг дурьдахдаа зуучлагчийн ур чадвар илүү нөлөөлж болон зуучлагчтай байх нь ойлголцоход хялбар нөгөө талаас зуучлагчтай тус тусдаа уулзах нь маргалдагч талтай эвлэрэхэд голлох нөлөө үзүүлдэг гэжээ. Харин амжилтгүй болох үндсэн шалтгаан нь хоёр талаас хүсэл сонирхолгүй байх мөн нөгөө талаас хүсэлгүй байх нь амжилтгүй байдаг гэсэн бол зуучлагчийн ур чадвараас шалтгаалж амжилтгүй болдог шалтгаан нь маш бага (2.4%) нөлөөтэй гэж үзжээ.

График 6. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг цаашид илүү үр дүнтэй ажиллуулах талаар дэвшүүлсэн санал /Шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах, өмгөөлөгч, хуульчийн хариулт/



Цаашид эвлэрүүлэн зуучлах ажиллагааг илүү үр дүнтэй, идэвхтэй явуулах тал дээр шүүгч, өмгөөлөгч, эвлэрүүлэн зуучлагч, туслах нар дээрх байр суурьтай байна. Хамгийн түрүүнд эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны талаарх иргэд олон нийтэд мэдээллийг түгээх дараа нь гэр бүлийн маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд мэргэжлийн шинжээч, сэтгэл зүйчийг оролцуулдаг байх, эвлэрүүлэн зуучлагч бэлтгэх сургалтын чанарыг дээшлүүлэх, давтан сургалтыг сайжруулах, эвлэрүүлэн зуучлагчийн цалин, хангамжийг нэмэгдүүлэх зэрэг үндсэн шалтгаануудыг дурьдаж өгчээ.

Түүнчлэн судалгааны оролцогчдын 43 орчим хувь нь эвлэрүүлэн зуучлагч бэлтгэх сургалтын чанарыг дээшлүүлэх, сайжруулах шаардлагатай гэснээс үзвэл өмнө дурдсанчлэн эвлэрүүлэн зуучлагч бэлтгэл сургалтын стандарт байхгүйгээс сургалтын хөтөлбөрийн чанарыг үнэлэх боломжгүй болохын зэрэгцээ сургалтын агуулга хангалтгүй байх талтай. Мөн өөр нэг анхаарал татсан асуудал нь судалгаанд оролцогчид эвлэрүүлэн зуучлагч нарын цалин хангамжийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзсэн байна.

2. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зарчим, үйл ажиллагааны үнэлгээ, сэтгэл ханамж

Сонгосон зүйл, заалт	Зүйл заалтын агуулга
5 дугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зорилго, үндсэн зарчим	5.2. Эвлэрүүлэн зуучлалыг дараах зарчимд үндэслэн явуулна: 5.2.1. талуудын сайн дурын үндсэн дээр хэрэгжих; 5.2.2. эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогчдын нууцыг хадгалах; 5.2.3. эвлэрүүлэн зуучлагч төвийг сахисан байр суурьтай байх; 5.2.4. эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд талууд тэгш эрхтэй оролцох.

Хүснэгт 10. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаар иргэдийн өгсөн үнэлгээ

№	Үйл ажиллагаа	Бүрэн санал нийлж байна	Санал нийлж байна	Дунд зэрэг	Санал нийлэхгүй байна	Огт санал нийлэхгүй байна
1	Оролцог талуудад адил тэгш хандсан	70.0%	25.0%	4.3%	.7%	0.0%
2	Эвлэрүүлэн зуучлагч нь миний санаа бодлыг шүүлгүйгээр сонсож, төвийг сахисан байр суурьтай байсан	51.8%	28.8%	3.6%	5.0%	10.8%
3	Эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны явцад өөрийн санал бодлоо илэрхийлэх, харилцан санал солилцох бүрэн боломжийг олгож байсан	70.2%	27.8%	2.0%	0.0%	0.0%
4	Эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй тайлбар мэдээлэл өгч байсан	73.7%	23.7%	2.6%	0.0%	0.0%
5	Эвлэрүүлэн зуучлагч тохиролцоонд хүргэхийн тулд шахалт үзүүлсэн гэж үзэж байна	21.3%	10.6%	4.3%	17.7%	46.1%
6	Эвлэрүүлэн зуучлагч асуудлыг бүрэн дүүрэн ойлгож байсан	63.0%	34.1%	2.2%	.7%	0.0%
7	Эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны дараа маргалдагч талтай харилцаа сайжирсан	43.3%	36.7%	12.0%	4.7%	3.3%
8	Эвлэрүүлэн зуучлагч өөрийн үзүүлсэн үйлчилгээнд тохирох шударга үнэ хөлс авсан	35.1%	21.6%	6.3%	6.3%	30.6%
9	Эвлэрүүлэн зуучлалтай холбогдон гарах бүх төрлийн зардал болон төлбөрийг урьдчилан сануулсан	51.7%	31.7%	9.2%	.8%	6.7%
10	Эвлэрүүлэн зуучлагч надтай хүндэтгэлтэй харьцаж байсан	66.9%	30.4%	2.0%	.7%	0.0%
11	Эвлэрүүлэн зуучлалын үеэр миний хуваалцсан мэдээллийг задруулахгүй гэдэгт итгэлтэй байна	66.7%	29.3%	4.0%	0.0%	0.0%

12	Надад үйлчилсэн эвлэрүүлэн зуучлагчийг бусдад ч гэсэн санал болгоомор байна	65.3%	29.9%	4.1%	.7%	0.0%
----	-----------------------------------------------------------------------------	-------	-------	------	-----	------

Судалгаанд оролцсон иргэдээс эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны явцын төрлүүдээр нэг бүрчлэн үнэлгээ авч үзвэл ерөнхийдөө эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны зарчмууд хангалттай сайн үнэлгээ авч байна. Харин эвлэрүүлэн зуучлагч өөрийн үзүүлсэн үйлчилгээнд тохирох шударга үнэ хөлс авдаг гэдэг дээр иргэд шүүмжлэлттэй хандаж байна. Мөн эвлэрүүлэн зуучлагч нь миний санаа бодлыг шүүлгүйгээр сонсож, төвийг сахисан байр суурьтай байсан зэрэг дээр хамгийн бага үнэлгээг авчээ.

Хүснэгт 11. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаан дахь зарчмын хэрэгжилт /шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах, өмгөөлөгч, хуульчийн хариулт/

№	Утга	Бүрэн хангальтай	Хангал ттай	Зарим талаар хангалттай	Хангал тгүй	Огт хангальгүй	Мэдэх гүй
1	Талуудын сайн дурын үндсэн дээр хэрэгжих	56.0%	28.5%	12.5%	2.0%	.5%	.5%
2	Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогчдын нууцыг хадгалах	58.5%	29.5%	6.0%	2.0%	1.0%	3.0%
3	Эвлэрүүлэн зуучлагч төвийг сахисан байр суурьтай байх	50.8%	35.2%	9.0%	2.5%	1.0%	1.5%
4	Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд талууд тэгш эрхтэй оролцох	52.7%	33.3%	10.4%	1.5%	1.0%	1.0%
5	Маргааныг эвийн журмаар зохицуулах	49.5%	39.6%	8.4%	.5%	1.0%	1.0%
6	Шүүхийн процесстой харьцуулахад шуурхай шийдвэрлэх	55.0%	33.5%	10.5%	0.0%	.5%	.5%
7	Шүүхийн процесстой харьцуулахад зардал бага гарах	58.9%	33.7%	5.0%	1.0%	.5%	1.0%

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны дээрх 7 төрлийн зарчмуудыг эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцдог эвлэрүүлэн зуучлагч, туслах, шүүгч, өмгөөлөгч нар үнэлэхдээ 84.5-92.6 хувиийн үзүүлэлтээр хангалттай түүнээс дээш үнэлсэн байна.

График 7. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтэд өгөх үнэлгээ /шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах, өмгөөлөгч, хуульчийн хариулт/



Судалгаанд хамрагдсан шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, туслах, өмгөөлөгч нар эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд 77 хувь нь сайн болон маш сайн, 20 хувь нь дунд, 2 хувь нь муу үнэлгээг өгсөн байна. Харин иргэдээс эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны сэтгэл ханамжийн түвшинг судалж үзвэл, тэдний 90 хувь нь мөн сэтгэл ханамжтай, 9 хувь нь дунд зэрэг, 1 хувь сэтгэл ханамжгүй байна гэж үзжээ. /График 8./

Үүнээс үзвэл эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь хууль эрх зүйн талаасаа ч тэр амьдралд үр өгөөжөө өгч байгаа талаас тэр маш үр өгөөжтэй байна.

График 8. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтэд өгөх үнэлгээ /иргэдийн хариулт/



3. Эвлэрүүлэн зуучлагчдийн зөвлөлийн үйл ажиллагаа

Сонгосон зүйл, заалт	Зүйл заалтын агуулга
----------------------	----------------------

11 дүгээр зүйл. Зөвлөлийн бүрэн эрх	11.1.2.эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх, давтан сургах сургалтын хөтөлбөрийг боловсруулах, сургалт зохион байгуулах; 11.1.3.эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулах, эрхийн гэрчилгээ олгох; 11.1.4.эвлэрүүлэн зуучлагчийг бүртгэх, нэrsийн жагсаалтыг олон нийтэд нээлттэй зарлах ажлыг зохион байгуулах; 11.1.5.эвлэрүүлэн зуучлагчийн эрхийг түдгэлзүүлэх, хасах, гэрчилгээг хүчингүй болгох, нэrsийн жагсаалтаас хасах;
------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Эвлэрүүлэн зуучлалыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд чанартай боловсон хүчнийг бэлтгэх хүний нөөцийн тухай асуудал юм. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууйин 11 дүгээр зүйлийн 11.1.2-т “Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл нь эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх, давтан сургах, сургалтын хөтөлбөрийг боловсруулах, сургалт зохион байгуулах”, 11.1.3-т “эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулах, эрхийн гэчилгээ олох” эрхтэй байхаар хуульчилсан. Хэдийгээр энэхүү заалт нь Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн бүрэн эрх гэж зохицуулсан ч илүү чиг үүргийн шинжтэй зохицуулалт юм. Тэгвэл дээрх зохицуулалтын хэрэгжилтийн талаар авч үзье.

Эвлэрүүлэн зуучлагчдын давтан сургалт нь жилд нэг удаа буюу 2014-2019 оны хооронд жилд нэг удаа буюу нийт 6 удаа зохион байгуулагдсан байна. Давтан сургалт нь шүүх дэх болон орон тооны бус эвлэрүүлэн зуучлагчдад хэрэг, маргааныг шийдвэрлэх процессын ажиллагааны эрх зүйн зохицуулалт болон эвлэрлийн гэрээг боловсруулахад анхаарах асуудал, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахад өзэмшвэл зохих шаардлагатай онолын мэдлэг, чадвар, сэтгэл зүй, харилцаа хандлагын талаар гүнзгийрүүлэн судлах зорилготой явагдсан байна.⁴

Түүнчлэн 2016, 2017 онд зохион байгуулсан эвлэрүүлэн зуучлагчдын давтан сургалтыг Монголын Хуульчдын холбооны “Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих” хороотой хамтран зохион байгуулж, тухайн сургалтын нэг өдрийг хуульчийн үргэлжилсэн сургалтын багц цагт тооцуулах арга хэмжээг авсан байна.⁵

Мөн эвлэрүүлэн зуучлагч бэлтгэх сургалтыг нийт 21 удаа, орон нутагт 15 удаа зохион байгуулж, Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль болон Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн 2013.8.9-ны 06 тоот тогтоолд заасан үндэслэл, журмын дагуу 6 удаа эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулах ажиллагаа явуулж, сонгон шалгаруулалтад тэнцсэн нийт 882 оролцогчид эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах гэрчилгээ олгосон байна. Мөн 882 эвлэрүүлэн зуучлагчийг бүртгэн олон нийтэд нээлттэй зарлах ажиллагааг тогтмол явуулж байгаа талаар тайланд дурдсан боловч орон тооны бус эвлэрүүлэн зуучлагчийг ажиллах боломж хаалттай байгаа талаар судалгаанд оролцогчид хэлж байв.

Цаашид эвлэрүүлэн зуучлах ажиллагааны чанарыг дээшлүүлэхэд эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх сургалт болон давтан сургалт нэн чухал бөгөөд тухайлан сургалтын

⁴ Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн тайлан 2013-2019 он. 11 дэх тал

⁵ мөн тэнд

стандартыг бий болгох замаар сургалтын хөтөлбөрийг стандартад нийцүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Улмаар эвлэрүүлэн зуучлагчийг мэргэшүүлэхэд илүү анхааран холбогдох боловсролын байгууллага болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудтай хамтран ажиллахаас гадна сургагч багш нарыг шинээр бэлтгэх зэрэг зайлшгүй хийхгдэх ажиллагаанд хөрөнгө, санхүүгийн асуудлыг төсөвт тусгах шаардлагатай.

Тухайлбал Шүүхийн захиргааны тухай хуульд ШЕЗ-ийн чиг үүрэг, бүрэн эрхийг тодорхойлохдоо тус хуулийн 7.1.10-д "Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны зохион байгуулалтыг хангах" гэснээс өөр зохицуулалт байхгүйгээс шалтгаалан шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаатай холбоотой арга зүй, мэдээлэл нэгтгэх, судалгаа, санхүү, аж ахуй, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх ажиллагаанд шүүхийн захиргааны байгууллага чиг үүргээ хангалттай сайн биелүүдэггүй байдал гарч байна.⁶

Шигтгээ 1. Шүүгчтэй хийсэн ярилцлагаас

... Орон тооны бус эвлэрүүлэн зуучлагч ажиллах боломж хаалттай байна. Төрийн бус байгууллага дээр эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдахгүй байна. Шүүх дэх орон тооны эвлэрүүлэн зуучлагчдын тоог нэмэгдүүлэх, эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэгдэх хэргийн төрлийг олшируулах шаардлагатай.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль хэрэгжснээс хойш эвлэрүүлэн зуучлагч албан үүргээ хэрэгжүүлэхдээ эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үндсэн зарчим, ёс зүйн дүрмийг зөрсөн 6 гомдол гарсан бөгөөд Зөвлөлийн 2013.8.7-ны өдрийн 03 тоот тогтоолоор батлагдсан Эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн зөрчлийг шалгах үйл ажиллагааны журамд заасны дагуу тухайн гомдлуудыг шалгаж, шийдвэрлэсэн байна.

Тэдгээр гомдлыг шалгах явцад эвлэрүүлэн зуучлагчийн гаргасан зөрчил нь мэргэжлийн буюу эвлэрүүлэн зуучлах ажиллагаатай холбоотой эсхүл тухайн ажиллагаатай хамааралгүй буюу хөдөлмөрийн сахилга, ахуйн үйлдэлтэй холбоотой эсэхийг ялгаж зааглахгүйгээр ёс зүйн дүрэм зөрчсөн гэдэг үндэслэлээр зөрчил гаргагчийн эрхийг түдгэлзүүлэх, хасах, гэрчилгээг хүчингүй болгох, нэrsийн жагсаалтаас хасах боломжгүй байдал удаа дараа гарсан байна. Дээрх байдлыг үндэслэн "Эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн зөрчлийг шалгах үйл ажиллагааны дүрэм"-д нэмэлт өөрчлөлт оруулжээ.

Түүнчлэн эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх, давтан сургах сургалтаас гадна хууль зүйн их, дээд сургуулиудад Шүүхийн бус аргаар маргаан шийдвэрлэх эрх зүй сэдэвт сонгон судлах хичээл сургалтын хөтөлбөрт багтаж, амжилттай хэрэгжиж байна. Тухайлбал Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуульд оюутнууд 4-р курсээс эхлэн тус хичээлийг сонгон судлах боломжтой бөгөөд жил бүр хангалттай тооны оюутнууд сонгон судалдаг бөгөөд эвлэрүүлэн зуучлалын сургалт их, дээд сургуулиудад амжилттай хэрэгжиж байна.

Шигтгээ 2. Их сургуулийн багштай хийсэн ярилцлагаас

⁶ мөн тэнд. 20-р тал.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль батлагдсанаар хууль зүйн их дээд сургуулиудад энэ талаар хичээл орох шаардлагатай болсон. ADR буюу "шүүхийн бус аргаар маргаан шийдвэрлэх" гэсэн өргөн нэртэйгээр зөвхөн эвлэрүүлэн зуучлал гэлгүйгээр арбитрын мөн хамааруулж хичээл орохоор болсон бөгөөд бусад улсад энэ хичээл хэрхэн зааж байгааг судалж үзсэн. Энэ хичээлийг сонгон хичээл орохоор болсон. Ингээд эвлэрүүлэн зуучлалын хичээлд хэрэглэх гарын авлагыг тодорхой хүмүүстэй хамтран гаргасан. Энэ хичээл 2 кредит буюу 24 цагийн лекц, 16 цагийн семинар ордог. МУИС-ийн ХЗС дээр энэ хичээлийг 3 дахь жилдээ орж байна. Энэ хичээлийг оюутнууд жил болгон сонгож үзэж байгаа. Дунджаар нэг удаа 20 орчим оюутан сонгодог. Энэ хичээл нь эвлэрүүлэн зуучлал шүүхийн процессийн харьцуулахад ямар давуу талтай болох, эвлэрүүлэн зуучлагч болохын тулд юуг мэдсэн байх ёстой, ямар ур чадвартай байх, эвлэрлийн гэрээ байгуулахад юуг анхаарах ёстой гэх зэрэг агуулгаас бүрддэг. Энэ хичээлийг Отгонтэнгэр зэрэг бусад хуулийн сургуулиудад заадаг болсон.

Мөн Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны дүрэм, журам, стандартыг батлан мөрдүүлэх чиг үүрэгтэй байна. Энэ хүрээнд Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлөөс 2013 оноос хойш 2 дүрэм, 4 журам, 1 стандарт болон холбогдох тогтоолыг гаргасан нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль саадгүй хэрэгжих гол үндсийг бүрдүүлсэн гэж үзэж байна.

Үчир нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль нь эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр эвлэрүүлэх шүүхийн бус аргын хэрэглэх эрх зүйн үндсийг бий болгосон бөгөөд харьцангуй хураангуй буюу зарим ажиллагааны талаар процессын зхицуулалт байхгүй зэргээс Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлөөс гаргасан "Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны тухай" журам нь эрх зүйн хэм хэмжээ тогтоо зэрэг асуудлыг үүсгэж байна. Эөрөөр хэлбэл цаашид Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн процесс ажиллагааны зохицуулалтыг илүү дэлгэрэнгүй байдлаар хуульчлахгүй бол эвлэрүүлэн зуучлааар маргааныг шийдвэрлэх процессын асуудлыг үндсэндээ үйл ажиллагааны журмаар зохицуулж байгаа гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

4. Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлагчийн үйл ажиллагааны хэрэгжилт

Сонгосон зүйл, заалт	Зүйл заалтын агуулга
8 дугаар зүйл.Төрийн болон төрийн бус байгууллага дахь эвлэрүүлэн зуучлагч	8.1.Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу тухайн салбарын эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэх эвлэрүүлэн зуучлагчийг ажиллуулж болно.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу тухайн салбарын эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэх эвлэрүүлэн зуучлагчийг ажиллуулж болно” гэж заасан. Өөрөөр хэлбэл, энэхүү зохицуулалт нь Монгол Улсад шүүх дэх эвлэрүүлэн зуучлал болон шүүхээс гадуурх буюу бусад байгууллагад эвлэрүүлэн зуучлагч ажиллаж болох нөхцөлийг бүрдүүлсэн зохицуулалт гэж хэлж болно.


Тус зохицуулалтын зорилго нь эвлэрүүлэн зуучлалаар иргэний эрх зүйн маргаан, гэр бүлийн эрх зүйн маргаан, хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг шийдвэрлэхээр заасан ч тус маргаанууд нь дотроо маш олон төрлийн маргааныг агуулдаг тул тэдгээр олон төрлийн маргааныг илүү мэргэжлийн байгууллага хийгээд мэргэжлийн этгээд эвлэрүүлэн зуучлагчийн үүрэг гүйцэтгэж шийдвэрлэх нь оновчтой гэж үздэгтэй холбоотой. Иймд тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтын хэрэгжилтийг авч үзье.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль 2013 онд батлагдаж 2014 оноос эхлэн албан ёсоор шүүх дэх эвлэрүүлэн зуучлал ажиллаж эхэлснээр Монгол Улсын хэмжээнд иргэний хэргийн анхан шатны 38 шүүхэд эвлэрүүлэн зуучлах төвийг байгуулсан.

Үүнээс гадна шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаас гадуур буюу 2014 онд Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэд Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төв, 2015 онд Улаанбаатар хотын Худалдааны танхимын дэргэдэх Эвлэрүүлэн зуучлах төв, 2017 онд Монголын Олон Улсын ба Үндэсний Спортын Арбитрын холбооны дэргэдэх Эвлэрүүлэн зуучлах төв гэсэн 3 байгууллагын дэргэд эвлэрүүлэн зуучлах төв байгуулагдсан байна.

2006 оны 5 дугаар сарын 5-ны өдөр ЖАЙКА-гийн эрх зүйн шинэтгэл, туслалцаа төслийн хүрээнд Монголын өмгөөлөгчдийн холбооны дэргэд “Иргэний хэрэг, маргааныг эвлэрүүлэн зуучлах LGL төв” байгуулагджээ. 2007 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн Монголын өмгөөлөгчдийн холбооны удирдах зөвлөлийн хурлаар “Эрх зүйн туслалцаа үзүүлэх, маргааныг эвлэрүүлэн зуучлах LGL төвийн дүрэм”-ийг баталсан байна. Үүний дараагаар уг төвийг 2008 оны 9-р сарын 26-ний өдрийн Монголын өмгөөлөгчдийн холбооны удирдах зөвлөлийн хурлаар Эрх зүйн туслалцаа үзүүлэх төв, Иргэний хэрэг маргааныг эвлэрүүлэн зуучлах LGL төв гэсэн хоёр тусдаа бие даасан төв болгон өөрчилж, дүрмийг шинэчлэн баталсан байна.

График 9. Шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалаас өөр төрлийн эвлэрүүлэн зуучлагч байдгийг мэдэх эсэх талаар иргээдийн өгсөн хариулт




Санал асуулгын дүнгээс үзэхэд судалгаанд оролцсон 169 иргэнээс төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалтай холбоотой асуултад хариулсан байна. Үүнээс нийт 126 иргэн буюу 78.3 хувь нь шүүхээс өөр байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын талаар мэдэхгүй гэсэн хариулт өгсөн бол 26 иргэн буюу 16.1 хувь нь энэ талаар сонсож байсан, 9 иргэн буюу 5.6 хувь нь мэднэ, үйлчлүүлж байсан гэсэн хариултыг өгсөн.

Үүнээс дүгнэж үзвэл судалгаанд оролцогчдийн бараг 80 орчим хувь нь иргэд, олон нийтийн дунд шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалаас өөр байгууллагад эвлэрүүлэн зуучлал байдаг гэдгийг огт мэдэхгүй байгаа нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл дээр дурдсан 4 байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төвүүд нь үйл ажиллагаагаа олон нийтэд таниулах талаар арга хэмжээ авдаггүй, үндсэндээ тогтмол үйл ажиллагаа явуулдаггүй гэж дүгнэж болно.

Иймд иргэд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаарх мэдээллийг хаанаас авдаг талаар тандаж үзвэл, тэдний 66.7 хувь нь шүүхийн байгууллагаас, 24.2 хувь нь телевиз, радио сонин, сэтгүүл г.м. хэвлэл мэдээллээс, 17 хувь нь нийгмийн сүлжээ буюу цахим орчноос, 14.4 хувь нь найз нөхөд, хамаатан садангаасаа голлон энэ төрлийн мэдээллийг авдаг гэсэн нь тухайн эвлэрүүлэн зуучлах төвүүд үйл ажиллагаа идэвхигүйгээс олон нийтэд мэдээлэл түгээхэд чиглэсэн арга хэмээ авдаггүйгээс шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлах байгууллагын талаарх мэдээллийг авах боломж хязгаарлагдмал байгаа нь харагдаж байна. /График 10/

График 10. Эвлэрүүлэн зуучлалын талаар иргэдийн мэдээлэл авдаг суваг



Судалгааны явцад ч дээрх эвлэрүүлэн зуучлах төвүүдийн талаар мэдээлэл байхгүй, тогтвортой үйл ажиллагаа явуулдаггүй болох нь ажиглагдсан. Харин нийт оролцогчдын 67 орчим хувь нь эвлэрүүлэн зуучлалын талаарх мэдээллийг шүүхийн байгууллагаас авдаг гэж хариулсан нь шүүхээс эвлэрүүлэн зуучлах ажиллагааг бодитоор олон нийтэд сурталчилан таниулах ажлыг гүйцэтгэж байна гэж дүгнэж болно.

Шигтгээ 3. Их сургуулийн багштай хийсэн ярилцлагаас

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилт сайн байгаа, гэхдээ уг хуулийн 8-р зүйлд заасан төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбооны дэргэдэх

Эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээтэй холбоотой асуудал шийдэгдээгүй байна. Үүнийг шүүхээс хянаж баталгаажуулах боломж байхгүй. Энэ тогтолцоог цаашид хэрхэн хөгжүүлэх нь бодох ёстой асуудлын нэг юм.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаар иргэд болон хэргийн оролцогч наарт мэдлэг олгох, түүний ач холбогдлыг тайлбарлах, сурталчлах ажлыг хийх хэрэгтэй байна. Ингэж зөв ойлгуулж байж сая эвлэрүүлэн зуучлах ажиллагаа үр дүнтэй явагдах үндэс бүрдэнэ.

Хүснэгт 12. Шүүхээс гадуур төрийн болон төрийн бус байгууллагын дэргэд эвлэрүүлэн зуучлагч ажиллах зохицуулалт үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх

№	Эрхэлдэг ажил	Тийм	Зарим талаар	Үгүй
			учир дутагдалтай	
1	Шүүгч	30.0%	18.6%	51.4%
2	Эвлэрүүлэн зуучлагч	13.9%	27.8%	58.3%
3	Эвлэрүүлэн зуучлагчийн туслах	46.2%	30.8%	23.1%
4		22.1%	41.2%	36.8%
	Өмгөөлөгч, хуульч			
	Нийт	26.5%	29.5%	44.0%

Мөн судалгаанд хамрагдсан 223 шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, өмгөлөөгч, эвлэрүүлэн зуучлагчийн туслахаас Төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын хэрэгжилт ямар байгаа талаарх асуултад 44 хувь нь хангалтгүй, 29.5 хувь нь хангалтгүй буюу зарим талаар учир дутагдалтай, 26.5 хувь хангалттай хэрэгжиж байна гэсэн хариулт өгсөн. Энэхүү баримтаас үзэхэд эвлэрүүлэн зуучлалын талаар хамгийн сайн мэдээлэлтэй буюу уг хуулийг хэрэгжүүлэхэд хамгийн чухал үүрэг гүйцэтгэж буй субъектүүдийн дунд ч шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хангалтгүй гэж дүгнэж байгааг харж болохоор байна. Өөрөөр хэлбэл нийт судалгаанд оролцогчдын бараг тал орчим буюу 44 хувь нь огт хангалтгүй гэж дүгнэснээс үзвэл дээр дурдсан иргэдийн санал асуулгын дүгнэлт болох дийлэнх нь энэ талаар мэдэхгүй гэсэн дүгнэлт батлагдаж байна.

Түүнчлэн судалгаанд оролцогчдыг мэргэжлийн хувьд авч үзвэл шүүгч 51.4 хувь, эвлэрүүлэн зуучлагч 58 хувь үзвэл шүүхээс бусад байгууллага дахь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хангалтгүй гэж дүгнэсэн бол өмгөөлөгчдийн 41.2 хувь зарим талаар учир дутагдалтай гэж дүгнэсэн.

Иймд иргэд болон бусад мэргэжлийн этгээдүүдийн дунд явуулсан судалгаагаар Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт буюу төрийн болон төрийн бус байгууллагын дэргэд эвлэрүүлэн зуучлагч ажиллах зохицуулалтын хэрэгжилт тийлын хангалтгүй байна гэж дүгнэж байна.

Тэгвэл ийнхүү хангалтгүй байгаа шалтгааныг авч үзвэл хэд хэдэн шалтгааныг тодорхойлж болно. Үүнд:

- Олон нийтийн дунд шүүхээс бусад байгууллага дахь эвлэрүүлэн зуучлах төвийн талаарх мэдээлэл байхгүй;

- Тус эвлэрүүлэн зуучлах төвүүд нь үйл ажиллагаа явуулдаггүй;
- Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахад шаардлагатай хатуу болон зөөлөн дэд бүтцийн асуудлыг бүрэн шийдвэрлээгүй (дотоод дүрэм журам тодорхойгүй, хаана байрладаг, эвлэрүүлэн зуучлагчийн мэдээлэл байхгүй зэрэг);
- Эрх зүйн зохицуулалтаас хамаарах зэрэг болно.

Үүнээс 4-р хэсэг буюу Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт хангалттай хэрэгжихгүй байгаа нь яагаад хуулийн зохицуулалтаас хамаарч байгааг тусгайллан авч үзье.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ үүрэг гүйцэтгэгч биелүүлээгүй бол негеэ тал нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй” гэж заасан. Харин 27.2-т “Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг тухайн шатны шүүгч баталгаажуулж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74.2, 74.6 дахь хэсэг, 75 дугаар зүйлд заасан журмын дагуу захирамж гаргана” гэж ялгамжтайгаар зохицуулсан.

Өөрөөр хэлбэл Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 7 дугаар зүйл нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлал, 8 дугаар зүйл нь шүүхээс бусад төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалыг тодорхойлж байгаа. Үүнээс үзвэл шүүхийн дэх эвлэрүүлэн зуучлааар дамжин маргаанаа шийдвэрлэбэл талуудын байгуулсан Эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулж, шүүхийн шийдвэрийн нэгэн адил заавал биелэгдэх шинжтэй болдогт гол ялгаа нь байна.

Тухайлбал өмнө дурдсанчлан судалгаанд хамрагдсан өмгөөлөгчдийн 40 гаруй хувь нь учир дутагдалтай гэсэн нь нэг талаар бизнесийн маргаан, аливаа теник, технологи, гэр бүл зэрэг нарийн онцлогтой хэргүүдийг тухайн чиглэлийн мэргэшсэн этгээдээр шийдвэрлүүлэх хүсэлтэй байдаг ч тухайн эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан Эвлэрлийн гэрээ нь заавал биелэгдэх албадлагын шинжгүй, зөвхөн Иргэний хуульд заасан бусад төрлийн гэрээтэй адил үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах аргаар хангагдана.

Өөрөөр хэлбэл талууд хэдий эвлэрч, Эвлэрлийн гэрээ байгуулсан ч үүрэг гүйцэтгэгч тал үүргээ сайн дураар гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч тал дахин шүүхэд хандах замаар үүргээ гүйцэтгэхийг шаардах эрхээ хэрэгжүүлнэ. Негеэ талаар энэхүү үйл явц нь эвлэрүүлэн зуучлалын үр дүнг үгүйсгэх, дараа дараагийн тохиолдолд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэхээс татгалзах үндэслэл болдог.

Шигтгээ 4. MYXAYT-ийн БЭЗМЭЗТ-ийн эвлэрүүлэн зуучлагтай хийсэн ярилцлагаас

... 2014 онд Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимиын дэргэдэх Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төв /БМЭЗ/ нь эдийн засаг бизнестэй холбоотой маргаанд мэргэжлийн түвшинд хурдан шуурхай эвлэрүүлэн зуучлал явуулахаар

байгуулагдсан. Мөн Дархан-Уул аймагт мөн салбараа байгуулсан. 2014 оноос 2016 он хүртэл идэвхтэй үйл ажиллагаа явуулсан бөгөөд 15 гаруй хэрэгт эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилттай явагдсан. Эндээс миний мэдэхийн амжилттай эвлэрүүлэн зуучлал явагдсан хэрэг дээр төлбөр төлөгч нь эвлэрлийн гэрээгээ биелүүлээгүй улмаас 5 хэрэг дээр дахин шүүхэд хандах тохиолдол гарсан. Энэ бол Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төвд тулгарсан хамгийн том асуудал болсон. Үүнийг шийдвэрлэх зорилгоор эвлэрлийн гэрээг нотариатын мэдэгдэх хуудас, арбитраар баталгаажуулах арга замыг эрэлхийлсэн боловч зардал өндөр гэх асуудал гарч ирсэн. Энэ нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хямд төсөр гэсэнтэй зөрчилдөхөөр байсан.

Ийнхүү эвлэрүүлэн зуучлалын үр дүнд байгуулагдсан эвлэрлийн гэрээг албадан гүйцэтгэх боломжгүй байгаа нь тулгамдсан асуудал болсон бөгөөд энэ нь эргээд бизнесийн маргааныг хурдан шуурхай шийдвэрлэх гэхээсээ илүүтэй удаашруулах шинжтэй болж ирсэн тул 2016 оноос хойш сүүлийн 3 жил эвлэрүүлэн зуучлах ажиллагааг бизнес эрхлэгчид санал болгох, сурталчлахаас татгалзаж, эвлэрлийн гэрээг албадан гүйцэтгэх боломжгүй хүндрэл үүсч болзошгүй тухай бизнес эрхлэгчдэд тайлбарлаж, анхааруулдаг болсноор уг төвд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах хүсэлт ирэхээ больсон.

Харин шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын давуу тал нь эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээ нь Иргэний хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74¹.4-т зааснаар “Эвлэрлийн гэрээ нь Иргэний хуульд нийцсэн, гуравдагч этгээдийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хөндөөгүй байна” гэсэн шаардлагыг хангасан тохиолдолд шүүгчийн захирамжаар баталгаажиж, үүрэг гүйцэтгэгч тал үүргээ сайн дураар гүйцэтгэхгүй байсан ч 74¹.8-д “Эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шүүгчийн захирамж энэ хуулийн 75 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна. Энэ захирамжийг талууд сайн дураар биелүүлээгүй бол шүүхийн шийдвэрийн нэг адил албадан гүйцэтгэнэ” гэсний дагуу албадан гүйцэтгэх журмаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах боломжтой.

Иймд өмгөөлөгч, хуульчтай ярилцлага хийх явцад гол хөндөж байсан асуудал нь нэгэнт гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулдаггүй тул шүүх дэх эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэхийг илүүд үздэгээ хэлж байв.

Шигтгээ 5. Өмгөөлөгчтэй хийсэн ярилцлагаас

... Төрийн бус байгууллага дахь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хөгжихгүй байгаа шалтгаан нь эвлэрэл гэрээгээр баталгаажихаас цаашгүй байгаатай холбоотой. Өнөө цаг үед хүмүүс гэрээгээ яаг дагаж мөрдөгддөг ёс суртахуун бага байгаа тул албадлагаар арга механизм байхгүй бол хүч нөлөөгүй байна. Тиймээс эвлэрүүлэн зуучлах ажиллагааг үр нөлөөтэй болгохын тулд эвлэрлийн гэрээг албадлагын механизмыг зөвшөөрөхтэй зэрэгцээд төрийн бус байгууллага дахь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үүрэг хариуцлагыг

нэмэгдүүлэх, буруу зөрүү зүйл хийхээс сэргийлэх хэрэгтэй. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаа болоод байгаа тул арай өөр газар хийгдлээ гээд болохгүй гэх юм байхгүй.

Түүнчлэн эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулдаггүй тул MYXAYT-ийн дэргэдэх Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төвийн зүгээс үйлчлүүлэгч нарт эвлэрүүлэн зуучлах ажиллагааг санал болгохгүйгээр шүүх, арбитрыг санал болгодог болсон байна. Эдгээр асуудлаас шалтгаалан Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага /IDLO/-осс тус эвлэрүүлэн зуучлалд олгож байсан 2 дахь шатны санхүүжилтэй зогсоосон. Одоогоор уг төвийн эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа зогсонги байдалтай болсон байна. Дархан-Уул аймаг дахь салбарын эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны талаар мэдээлэл иргэдэд нилээдгүй танигдаж, хүмүүс сонирхож байсан боловч мөн эвлэрлийн гэрээг албадан гүйцэтгэх боломжгүй шалтгаанаар үйл ажиллагаа нь зогсонги байдалтай байна.

Үг төв Эвэлрүүлэн зуучлагчдийн зөвлөлөөс зохион байгуулдаг эвлэрүүлэн зуучлагчийн сургалтад хамрагдан эрхийн гэрчилгээ авсан 18 эвлэрүүлэн зуучлагчтай бөгөөд үүнээс 14 нь MYXAYT-ын захиалгаар Европын Сэргээн босголтын банкны дэмжлэгтэйгээр Yr дүнтэй эвлэрүүлэн зуучлах төв /CEDR/-ийн мэргэшсэн багш нарын удирдлаган дор сургаж, олон улсад эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа явуулах эрх бүхий, магадлан итгэмжлэгдсэн эвлэрүүлэн зуучлагчид байдаг.

Нөгөө талаар MYXAYT-ын дэргэдэх Монголын Олон улсын арбитрын 2017-2019 онд шийдвэрлэсэн хэрэг маргаанд дүн шинжилгээ хийсэн. Монголын Олон Улсын Арбитраас нийт 86 хэрэг маргааныг шийдвэрлэнээс 15 буюу нийт хэргийн 17%-д нь талууд санал нэгдэж, эвлэрснээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгосон бол 2018 оны хувьд Монголын Олон Улсын Арбитр дээр нийт 77 хэрэг маргааныг шийдвэрлэнээс 13-т нь талууд эвлэрүүлэн зуучлах үйлчилгээг сонгосон байна. Энэ нь уг онд шийдвэрлэсэн маргааны 16,8%-ийг эзэлж байх бөгөөд өмнөх оныхтой ижил байна. 2019 онд нийт 53 хэрэг, маргааныг нээлттэй хуралдаанаар шийдвэрлэж, талууд эвлэрснээр дуусгавар болсон нь нийт маргааны 26,4%-ийг эзэлж байх буюу нийт 14 хэрэг байна.⁷

Өөрөөр хэлбэл Арбитраар хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх явцад ч талууд эвлэрч маргаанаа шийдвэрлүүлж байгаа хувь иргэний хэргийн шүүхэд эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэж буй маргааны хувиас илүү байгаа нь бизнесийн маргаанд талуудын эвлэрлийн хувьд өндөр байдгыг харуулж байна. Иймд цаашид төрийн бус болон мэргэжлийн байгууллага дахь эвлэрүүлэн зуучлах тогтолцоог хөгжүүлэх, олон нийтэд сурталчилан таниулах хэрэгцээ шаардлага байгааг харж болохоор байна.

Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төв нь Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам, Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төвийн зардал тооцох журам гэсэн журмын хүрээнд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулдаг. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зардал нь 100 мянга төгрөгөөс өхөн дэгээр. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаатай харьцуулахад хамаагүй өндөр байдаг гэж байв.

⁷ Монголын Олон улсын Арбитраас авсан хэрэг шийдвэрлэлтийн тоон мэдээлэл. 2017-2019 он.

Харин Өмгөөлөгчдийн холбооны дэргэдэх LGL төвийн дүрмээр нийт 9 зүйлийн хүрээнд үйл ажиллагааны үндсэн чиглэл, үйл ажиллагааны үндсэн зарчим, төвийн санхүүжилт, бүтэц зохион байгуулалт, удирдах зөвлөл, зуучлагч болох эрх, шалгуур, эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны журам, тайлагналтын талаар зохицуулсан байна. Зуучлалыг зарчмын хувьд 1 зуучлагч хариуцан явуулна. Зуучлагчийг төвийн удирдах зөвлөл сонгон шалгаруулж МӨХ-ны ерөнхийлөгч томилдог байжээ. Уг төв 11 эвлэрүүлэн зуучлагч ажиллаж байжээ.

Зуучлагч нь тогтоосон дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулж, шийдвэрлэсэн, эс шийдвэрлэсэн маргааны үр дүнгийн талаар төвд бичгээр тайлагнана. Мэдээллийн сандаа дараах баримт материалыг бүртгэдэг. Үүнд:

- Зуучлагчийн бүртгэл;
- Эвлэрүүлэн зуучлалын хэргийн бүртгэл;
- Эвлэрүүлэн зуучлалын хэрэгтэй холбоотой баримт материал;
- Төлбөр тооцоотой холбоотой баримт;

Зуучлалын хураамж нь бүртгэл, баталгаажилт гэсэн зардлуудаас бүрдэнэ. Бүртгэлийн хураамжийн хэмжээ 10.000 төгрөгөөс дээш байх ба маргааны үнийн дүнгээс шалтгаалж тохиролцно. Зуучлах ажиллагааны зорилго биелэгдсэн бол үнийн дүнгээр дараах байдлаар хураамж авдаг.

- 1,000,000 төгрөг хүртэл 10-20 хувь;
- 1,000,001-10.000.000 төгрөг хүртэл 10 хувь;
- 10,000,001 төгрөгөөс дээш 6 хувь +220,000 төгрөг;

Тус эвлэрүүлэн зуучлах төв зээл, худалдах, худалдан авах гэрээний маргаан, үл хөдлөх эд хөрөнгийн маргаан, барилгатай холбоотой маргаан, хөдөлмөрийн маргаан, хувьцаа эзэмшигчдийн маргаан, визтэй холбоотой маргаан, нөхөн төлбөрийн маргаан, гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлэжээ.

2014 оноос эхлэн шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын тогтолцоо хэрэгжиж эхэлснээр уг төвийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсон байна. Эвлэрүүлэн зуучлахаар хандсан иргэдэд шүүх дэх эвлэрүүлэн зуучлалыг санал болгодог болжээ. Учир нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлалтай харьцуулахад тус төвийн эвлэрүүлэн зуучлалын зардал өндөр, эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулах боломжгүй гэсэн шалтгаануудаас хамаарлтай байна. Өөрөөр хэлбэл тус төв нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлалтай өрсөлдөх боломжгүй байдалтай байна.


Хүснэгт 13. Төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх (шуухээс бусад) эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд байгуулагдах эвлэрлийн гэрээг шүүгч баталгаажуулж шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах боломж

№	Эрхэлдэг ажил	Дэмжинэ	Дэмжихгүй
1	Шүүгч	53.9%	46.1%
2	Эвлэрүүлэн зуучлагч	54.1%	45.9%
3	Эвлэрүүлэн зуучлагчийн туслах	77.8%	22.2%

4		75.7%	24.3%
Өмгөөлөгч, хуульч			
Нийт		64.5%	35.5%

Тэгвэл Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх нэг арга нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын нэгэн адил эвлэрлийн гэрээг шүүгч хянан баталгаажуулах боломжтой болгох явдал юм. Энэ талаар судалгаанд оролцогч шүүгч, эвлэрүүлэн зуучлагч зэрэг 200 хүний санал асуулгаас үзвэл нийт оролцогчдийн 64.5 хувь эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулахыг дэмжсэн бол 35.5 хувь нь дэмжихгүй гэдгээ илэрхийлжээ. Энэхүү санал асуулгаас сонирхол татахуйц хэсэг нь шүүгчийн захирамжаар баталгаажуулахыг дэмжихгүй гэж шүүгч, эвлэрүүлэн зуучлагч нарын 45-аас дээш хувь нь хариулсан нь магадгүй тэдний цаашдын ажил үүргийн хуваарилалт, ачаалалтай холбоотой байхыг үгүйсгэхгүй юм.

График 11. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаас гадуур эвлэрүүлэн зуучлагч ажиллах зохицуулалт үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх /Шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах, өмгөөлөгч, хуульчийн хариулт/



Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд заасан төрийн болон төрийн бус байгууллагын дэргэд (шүүхээс гадуур) эвлэрүүлэн зуучлагч ажиллах зохицуулалт үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхд шүүгч, өмгөөлөгч, эвлэрүүлэн зуучлагч, түүний туслах нар хариулахдаа $\frac{3}{4}$ нь хэрэгжиж чадахгүй байна гэж хариулжээ. Харин тэд нар хэрэгжиж чадахгүй байгаа шалтгааныг дурьдахдаа дараах байдлаар үзэж байна. /График 12./ Тэдний үзэж байгаагаар $\frac{1}{2}$ буюу 51 хувь нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчийн нэгэн адил эвлэрлийн гэрээг албадан гүйцэтгэх боломжгүй, 40.1 хувь нь олон нийтийн мэдлэг, мэдээлэл дутуу (эрх зүйн ухамсар), 38.1 хувь нь шүүхээс бусад эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа эрхлэгч өөрөө тогтвортой үйл ажиллагаа эрхэлдээгүй нь хөгжихгүй байх шалтгаан байна гэж тус тус үзжээ.

График 12. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаас гадуур эвлэрүүлэн зуучлагч ажиллах зохицуулалт хэрэгжижгүй байгаа шалтгаан /Шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах, өмгөөлөгч, хуульчийн хариулт/



Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчдын олонх нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаас бусад байгууллага дахь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хүрээнд байгуулсан эвлэрлийн гэрээг албадан гүйцэтгэх боломжгүй нь бусад байгууллага дахь эвлэрүүлэн зуучлал амжилттай хэрэгжихгүй байгаа гэж үзжээ. Энэ нь талуудын хувьд эвлэрлийн гэрээ байгуулсан ч гэрээнд итгэх итгэл багатай буюу заавал албадлагын арга хэмжээ хэрэглэх боломжтой болсноор гэрээ хэрэгжинэ гэж үздэг хандлагатай шууд холбоотой болов уу.

Түүнчлэн судалгаанд оролцогчид үргэлжлүүлээд эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд зайлшгүй өөрчлөх болон нэмэх шаардлагатай саналыг дараах байдлаар гаргасан байна. Үүнд:

- Хувийн буюу төрийн бус байгууллага болон олон нийтэд тулгуурласан эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг дэмжих;
- талуудыг дуудан авчирах, асуудлаар зуучлагчийн эрх хэмжээг нэмэх, 30 хоногтоо хэдэн удаа уулзалт зохиох доод хязгаарыг тогтоох. Зуучлагч бараг 30 хоног нь дуусах үеэр уулзалт зарладаг тохиолдол практикт их гардаг тэгээд сунгасан 30 хоногтоо эвлэрдэг;.
- ажиллагааны үе шатуудыг хуульчлах буюу процесс тодорхой болгох;
- зуучлагчын эрх хэмжээ нэмэгдүүлэх;
- талуудын эвлэрэх нөхцөлийг хязгаарлахгүй байх;
- хариуцагчийг шүүхийн зөвшөөрлөөр албадан ирүүлэх;
- эрүүгийн, захиргааны хэргүүдийг төрөлд оруулах;
- талуудыг эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд дуудан ирүүлэх талаар ядаж 1 удаа албадах эрх олгох;
- эвлэрүүлэн зуучлалын хугацааг уртасгах. Ялангуяа гэр бүлийн эрх зүйн маргааны хувьд;
- шүүхийг үл хүндэтгэсэн байдал гаргасан дуудсан хугацаанд ирээгүй бол эвлэрүүлэн зуучлагч өөрөө шүүгчид хүсэлт гарган албадан ирүүлэх;
- улсын тэмдэгтийн хураамжийг нэмэгдүүлэх;
- өмгөөлөл эвлэрүүлэн зуучлалд оролцох эрх хэмжээг нэмэгдүүлж, эрх зүйн орчинг сайжруулах;
- хуулийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тбб-ын дэргэд эвлэрүүлэн зуучлал ажиллах нөхцөлийг боловсронгуй болгох;

... зэрэг саналуудыг гаргасан байна. Иргэдээс шүүхээс бусад төрлийн эвлэрүүлэн зуучлагаар маргаанаа шийдвэрлүүлэхээр хандах талаар тодруулбал дараах байдлаар хариулсан байна.

График 13. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагаас гадуур эвлэрүүлэн зуучлагчаар хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхээр хандах эсэх /иргэдийн хариулт/



Судалгаанд хамрагдсан иргэдийн 30 хувь нь зардалын хувьд шүүх мөн арбитраас хямд байвал хандана гэсэн бол 43 хувь нь шүүхийн дэргэд байхад дахин өөр газар байх шаардлагагүй гэж үзээд хандахгүй гэжээ. Харин 16 хувь нь маргааны төрлөөр мэргэшиж дагнасан бол хандана, 8 хувь нь одоогийн хуулиар шүүгчийн захирамжаар баталгаажуулахгүй тул хандахгүй, эрсдэлтэй гэж үзэх хэсэг байна.

Иймд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн зохицуулалт зорилгод хүрэх түвшин шалгуур үзүүлэлтийг хангахгүй байна.

Тиймээс төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэд эвлэрүүлэн зуучлагчтай байх зохицуулалтын хэрэгжүүлэлтийг сайжруулах, хэрэг маргааны төрлөөр дагнан мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчтай байх зорилгод хүрэхийн тулд олон нийтийн дундах мэдээллийг сайжруулах, төрийн бус байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлагчдын үйл ажиллагааг тогтвортжуулах, тус эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулдаг болгох шаардлагатай гэж дүгнэж байна.

Нөгөө талаар шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлагаас бусад байгууллага дахь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хэрэгжихгүй байгаа асуудал нь тухайн эвлэрүүлэн зуучлах төвүүд нь байнгын санхүүжилт байхгүйгээс тогтвортой үйл ажиллагаа явуулах боломжгүй байдагтай холбоотой. Өөрөөр хэлбэл эвлэрүүлэн зуучлах төвүүд нь тогтмол үйл ажиллагаа явуулахын тулд эвлэрүүлэн зуучлагч нарын эвлэрүүлэн зуучлал явуулах ажлын байр зэргээс эхлээд тогтмол цалин, хөлстэй байх зэргийг шаарддаг. Гэтэл эдгээр санхүүжилтийн

асуудлыг шийдвэрлэж чадахгүйгээс чадварлаг, мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагч ажиллахгүй байх, үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчилан таниулахгүй байх, улмаар цаашид эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахгүй байх хүртэл үр дагаварт хүргэж байна.

Харин Сангийн яам, Татварын ерөнхий газар зэрэг төрийн байгууллагын түвшинд эвлэрүүлэн зуучлалыг төдийлөн ашигладаггүй байна. Түүнчлэн Эрүүл мэндийн яам, Боловсролын яам зэрэг төрийн байгууллагуудын хувьд эвлэрүүлэн зуучлалаар үйлчлүүлсэн, маргаанаа шийдвэрлүүлсэн талаарх мэдээлэл байхгүй байгаа нь төрийн байгууллагуудын хувьд эвлэрүүлэн зуучлалыг ашиглах тохиолдол бага байгааг дүгнэж болно.

Нөгөө талаар Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан, гэр бүлийн эрх зүйн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахаар заасан нь хувийн эрх зүйн харицлаанд үүсч буй тодорхой асуудалд хамаарахаар байгаа нь нийтийн эрх зүйн харилцаанд оролцогч төрийн байгууллагын онцлогтой холбоотой юм. Өөрөөр хэлбэл төрийг төлөөлж албаны эрхээ хэрэгжүүлж буй албан тушаалтан маргааны нөгөө талтай эвлэрэн хэлэлцэж асуудлыг шийдвэрлэх нь зохисгүй гэж үзэх хандлага давамгай байдагтай холбоотой.

Шигтгээ 6. Татварын улсын байцаагчтай хийсэн ярилцлагаас

Эвлэрүүлэн зуучлал ажиллагаагаар хоёр тал харилцан буулт хийх замаар ээлэрэлд хүрэх учраас татварын салбарын онцлогоос хамааралтай буюу татвар бол улсын төсөөвт төлөх мөнгөн хөрөнгө учраас татварын маргаан дээр хоёр тал харилцан буулт хийнэ гэдэг нь өөрөө нэг талаас төсөөвт төлөгдөх мөнгөн хөрөнгө багасна гэсэн уг, нөгөө талаас хуульд зааснаар торгууль, алданги оногдуулж байгаа учир татварын байцаагч торгууль, алданги бууруулах боломжгүй. Харин хувийн эрх зүйн маргаан дээр эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдах боломжтой. Эвэлрүүлэн зуучлал татварын эрх зүйн онцлогтой бол таарахгүй болов уу. Ер нь Захиргааны ерөнхий хуульд заасан сонгох боломжийн хүрээнд эвлэрүүлэн зуучлал хэрэгжих боломжийг үгүйсгэхгүй боловч одоогоор хэрэгжүүлсэн зүйлгүй байна.

Нөгөө талаар судалгааны багийн зүгээс төрийн байгууллагууд эвлэрүүлэн зуучлагчтай байх шаардлагатай талаарх судалгааг хийх явцад хэд хэдэн байгууллагад маргаан таслах чиг үүрэг бүхий бүтэц байгааг судлан үзсэн болно. Тухайлбал Санхүүгийн зохицуулах дэргэдэх Маргаан таслах зөвлөл гэх бүтэц ажиллаж байна.

Тус маргаан таслах зөвлөл нь 2015 онд СЗХ-ын тогтоолоор батлагдсан Маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар зохицуулах бөгөөд энэхүү зөвлөл нь үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн зохицуулалтад хамаарах зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, харилцагч хооронл үүссэн аливаа маргааныг хянан шийдвэрлэх, иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх,

зөвлөлөөс гарсан аливаа шийдвэрийг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх зэрэг чиг үүрэгтэй байна.⁸

Мөн Хөдөлмөрийн маргаан таслах комисс, Татварын маргаан таслах зөвлөл зэрэг нэгэнт төрийн байгууллагуудад тогтсон бүтцийг ашиглах замаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах боломжийг судлан үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

Түүнчлэн судалгааны хүрээнд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдээс банк болон даатгалын компанийн холбогдох албан тушаалтантай уулзаж ярилцлага хийхэд банк, даатгалын компанийн хувьд маргаан гарсан тохиолдолд нэн тэргүүнд эвлэрүүлэн зуучлалыг сонгон үйлчлүүлж байна. Гэвч санхүүгийн байгууллагын хувьд эвлэрүүлэн зуучлалд гол тулгарч буй асуудлыг эвлэрүүлэн зуучлагчийн мэргэшсэн байдалтай холбоотой гэж үзсэн. Өөрөөр хэлбэл эвлэрүүлэн зуучлагчийн мэдлэг, ур чадвар хангалтгүй байдгаас талуудыг эвлэрүүлэхгүй байх тохиолдол гардаг байна.

Шигтгээ 7. Банкны хуулийн хэлтсийн захирагтай хийсэн ярилцлагаас

Манай компани нь банк, даатгалын салбарын үйл ажиллагаа явуулдаг. Өөрөөр хэлбэл эдгээр санхүүгийн салбар нь хамгийн их өр, зээл, төлбөрийн маргаан гардаг онцлогтой салбар юм. Иймд бидний хувьд зээлдэгч үүргээ гүйцэтгэхгүй байх тохиолдолд өмнө нь ихээхэн цаг, хугацаа, зардал гаргаж шүүхээр явдаг байсан бол сүүлийн үед байнга эвлэрүүлэн зуучлалд хандах болсон. Гэсэн ч эвлэрүүлэн зуучлагчийн ур чадвар, мэргэшсэн байдал туйлын хангалтгүй байна. Уг нь эвлэрүүлэн зуучлагч талуудыг эвлэрүүлэх, түүнд дэмжин туслах чиг үүрэгтэй баймаар. Гэтэл шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч нар гэрээ шивээд шүүхэд шилжүүлэх чиг үүрэгтэй юм шиг л ханддаг. Манайх жилдээ 50 гаруй хэрэг дээр эвлэрүүлэн зуучлалд хандаж асуудлаа шийдвэрлүүлдэг. Дийлэнх нь гэрээний үүргээ гүйцэтгэдэггүй учир шүүгчийн захирамжаа гаргуулаад шийдвэр гүйцэтгэлд ханддаг. Уг нь миний бодлоор мэргэжлийн холбоодод нь мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчийг нь ажиллуулаад, тухайн гэрээг нь шүүгчийн захирамжаар баталгаажуулдаг болчихвол энэ асуудал шийдэгдчихмээр санагдаад байдаг.

Мөн судалгааны хүрээнд банк, санхүүгийн хоёр компанийн албан тушаалтантай уулзаж ярилцлага хийхэд тухайн 2 компанийн чанаргүй зээл, авлага тодорхой хэмжээнд хуимтлагдсан байна. Ялангуяа сүүлийн банкин дахь чанаргүй зээлийн актив нэмэгдэж байгаа үүний нэг нотолгоо гэж хэлж болно.

Банкуудын хувьд эвлэрүүлэн зуучлалд хандаж маргаанаа шийдвэрлүүлэхдээ аль болох үүрэг гүйцэтгэгч талын төлбөрийн чадварыг харгалзан үзэж уян хатан байдлаар ханддаг байна. Өөрөөр хэлбэл төлбөрийг тодорхой хугацаанд хуваан төлөх график гаргах замаар эвлэрэх тохиолдол цөөнгүй гэдгийг онцолж байв. Үүнээс үзэхэд банк, санхүүгийн байгууллагуудын хувьд эвлэрүүлэн зуучлалаар маргаанаа шийдвэрлүүлэх нь зардал, цаг хугацааны хувьд хэмнэлттэйгээс гадна эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар

⁸ СЗХ-ны Маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагааны журам 3 дугаар зүйл. <http://www.frc.mn/resource/frc/uploads/news/files/Sait%20deer%20tavih%20huvilbar.pdf>

баталгаажуулж, сайн дураар үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд дахин маргаан үүсгэхгүйгээр албадан шийдвэр гүйцэтгэлийн журмаар үүргийн гүйцэтгэлийн хангуулах боломжтой тул эвлэрүүлэн зуучлалаар идэвхитэй үйлчлүүлэх болсон байна.

Нэгөө талаар манай улсад маш олон тооны банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хувь хүний дампуурлыг хуулиар зөвшөөрөөгүй байдаг онцлогтой. Энэ нь өр зээлийн асуудалд орсон хувь хүний хувьд ч өр зээлийн асуудлыг цэгцлэх шаардлага үүсдэг. Гэтэл нэг үүрэг гүйцэтгэгчтэй, олон тооны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байх тохиолдолд тэдгээрийг хамтад нь эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэдэг байх боломжийг судлан үзэх нь зүйтэй байна.

Хэрэв энэхүү тогтолцоог нэвтрүүлж чадвал санхүүгийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын хувьд ч томоохон ахиц дэвшил болох талтай. Учир нь манай улсын хувьд шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхэд цаг хугацаа ихээр шаарддаг, анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхээр маргаанаа шийдвэрлүүлэх болгонд хуульд заасан хэмжээгээр тэмдэгтийн хураамж төлдөг зэргээс шалтгаалан банк, санхүүгийн байгууллагад зардлын ачаалал үүсгэдэг. Иймд зээл, төлбөртэй холбоотой маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулдаг мэргэжлийн эвлэрүүлэн зуучлагч байх хэрэгцээ шаардлага байгаа гэж дүгнэж байна.

5. Иргэний хэрэгт эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх

Сонгосон зүйл, заалт	Зүйл заалтын агуулга
30 дугаар зүйл.Иргэний хэрэгт эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх	30.1.Шүүхэд иргэний хэрэг маргаан үүсгэнээс хойш талууд хамтарч хүсэлт гаргасан, эсхүл шүүгч эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх нь зохицой гэж үзэж санал болгосныг талууд зөвшөөрсөн тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулж болно.

2014 оноос эхлэн Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч ажиллаж эхэлснээс хойш 2019 он хүртэлх Шүүн таслах ажиллагааны тайлан болон холбогдох бусад эх сурвалжуудад дүн шинжилгээ хийж үзэхэд 2014 онд нийт 32,181 хэрэг Иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн бол түүнээс 2,847 иргэний хэргийг Эвлэрүүлэн зуучлалаар амжилттай шийдвэрлэсэн. Энэ нь нийт шийдвэрлэгдсэн иргэний хэргийн 8.1 хувийг эзэлж байсан бол энэ үзүүлэлт жил ирэх тусам нэмэгдсэн эерэг үзүүлэлттэй байна. Тухайлбал, 2015 онд 35,493 иргэний хэрэг шийдвэрлэгдснээс 7881 хэргийг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэсэн нь нийт хэргийн 18.2 хувь, 2016 онд 39,773 иргэний хэргээс 8,909 хэрэг буюу 18.3 хувь, 2017 онд 37,271 иргэний хэргээс 10,013 буюу 21.2 хувь, 2018 онд 41,363 иргэний хэргээс 8,711 хэрэг буюу 17.4 хувь, 2019 онд 37,387 иргэний хэргээс 9,227 хэрэг буюу 19.8 хувийг тус тус эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар амжилттай шийдвэрлэсэн байна.

Энэ нь шүүх дэх Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хэрэгжсэн 6 жилийн нэгтгэсэн дүнгээр авч үзвэл нийт 223,468 иргэний хэргээс 47,587 хэрэг буюу дунджаар нийт иргэний хэргийн 17.2 хувийг эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар амжилттай шийдвэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл, энэ хэмжээгээр иргэний хэргийн шүүхийн ачааллыг багасгах, талууд харилцан тохиролцож маргааныг шийдвэрлүүлсэн ач холбогдолтой юм.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан болон гэр бүлийн харилцаанаас үссэн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэнэ” гэж заасны дагуу эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилттай болсон хэргийг хуульд заасан хэрэг, маргааны төрлөөр нь ангилан авч үзэв. Ингэхэд нийт 2014-2019 оны хооронд иргэний эрх зүйн маргаан 51,085, Хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан 435, Гэр бүлийн эрх зүйн маргаан 16,734 байна. Үүнээс иргэний эрх зүйн маргааны 45,013 буюу 88.1 хувь, хөдөлмөрийн ганцаарчилсан маргааны 311 буюу 71.5 хувь, гэр бүлийн эрх зүйн маргаанд 2,263 буюу 13.5 хувьд эвлэрэл амжилттай болсон байна. Өөрөөр хэлбэл, эвлэрүүлэн зуучлалаар амжилттай шийдвэрлэгдэж буй маргааны 88 гаруй хувь нь иргэний эрх зүйн маргаан байгааг харж болно.

Хүснэгт 14. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэсэн маргааны төрлөөр (2014-2019 он)

№	2014-2019 он нийтдээ	Иргэний эрх зүйн маргаан	Хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан	Гэр бүлийн эрх зүйн маргаан
1	Шийдвэрлэсэн	51085	435	16734
2	Эвлэрэл амжилттай болсон	45013	311	2263
3	Эзлэх хувь	88.1%	71.5%	13.5%

Нөгөө талаар иргэний эрх зүйн маргаан гэдэг нь хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан, гэр бүлийн эрх зүйн маргаанаас цар хүрээний хувьд харьцангуй өргөн бөгөөд хамгийн түгээмэл тохиолддог маргаан байдаг тул дээрх тоон үзүүлэлт нь зүй ёсны гэж үзэж болно. Тухайлбал иргэний эрх зүйн маргаанд бүхий л төрлийн гэрээний эрх зүйн маргаан, гэрээний бус үүрэгтэй холбоотой гэм хор, үндэслэлгүй хөрөнгөжих, өмчийн эрх зүйн маргаанууд хамаарна. Энэ утгаараа иргэний эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэхэд хөдөлмөрийн болон гэр бүлийн эрх зүйн маргааныг шийдвэрлэхээс илүү хялбар байх тохиолдол элбэг.

Түүнчлэн эдгээр иргэний эрх зүйн маргааны дотор дийлэнх маргаан нь бага үнийн дүнтэй, олон дахин давтагдаг шинж бүхий үйлчилгээ үзүүлсний төлбөр нэхэмжлэх маргаан байдаг. Жишээ нь Мобиком, Цахилгаан холбоо зэрэг хэдэн зуун мянгаар тоологдох хэрэглэгчдээс тодорхой хэсэг нь төлбөрөө төлөхгүй, төлбөр төлөх хугацаа хожимдуулсан зэрэг гэрээний үүргийн зөрчил гаргахад эвлэрүүлэн зуучлалд хандах замаар түргэн, шуурхай шийдүүлдэг онцлогтой тул иргэний эрх зүйн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үзүүлж буй ач холбогдол туйлын өндөр байна.

Хүснэгт 15. Санал асуулгад оролцсон иргэдийн шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлүүлсэн маргааны төрөл, эрх зүйн байдал (хувиар)

№	Утга	Өргөдөл гаргагч	Уригдагч	Бусад
1	Зээл, гэрээтэй холбоотой маргаан	63.8%	76.1%	83.3% 16.7%
2	Эд хөрөнгийн маргаан	6.0%	2.2%	
3	Өв залгамжлалын маргаан	3.4%	2.2%	
4	Бизнесийн маргаан	4.3%	4.3%	
5	Гэрлэлт цуцгалт	15.5%	10.9%	
6	Хүүхэд үрчлэх			
7	Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн маргаан			
8	Гэр бүлийн хүчирхийлэл	.9%		
9	Цалин хэлс шаардах	1.7%		
10	Ажлаас үндэслэлгүй халагдах			
11	Сахилгын шийтгэл ногдуулах			
12	Тэтгэвэр, тэтгэмж нэхэмжлэх	4.3%	4.3%	

Мөн энэхүү судалгааны хүрээнд эвлэрүүлэн зуучлалаар үйлчлүүлсэн иргэдээс авсан судалгаанаас үзэхэд 67.9 хувь нь зээл болон аливаа гэрээнээс үүдэлтэй маргаан, 10 орчим хувийг эд хөрөнгө, бизнесийн маргаан зэрэг бусад төрлийн иргэний эрх зүйн маргааны байна. Өөрөөр хэлбэл дээрх 2014-2019 оны хооронд нийт эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэсэн маргаанд эзлэх иргэний эрх зүйн маргааны хувь, судалгаанд оролцогчдын эвлэрүүлэн зуучлалд оролцсон маргааны тоо зэргээс нийт эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэгдэж буй маргааны 80-аас дээш хувь нь иргэний эрх зүйн маргаанд хамаардаг гэж дүгнэж болохоор байна. Бусад төрлийн маргааны тухайд дараагийн хэсгүүдэд дэлгэрүүлэн авч үзэх болно.

Иймд иргэний эрх зүйн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үзүүлж буй нөлөө туйлын өндөр бөгөөд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн зохицуулалт зорилгод хүрэх түвшин шалгуур үзүүлэлтэд нийцэж байна.

Хүснэгт 16. Эвлэрүүлэн зуучлах тогтолцоо бий болсноор шүүхийн ажлын ачаалалд нөлөөлсөн эсэх

№	Эрхэлдэг ажил	Ачаалал багассан	Ачаалалд нөлөө үзүүлээгүй	Ачаалал нэмэгдсэн	Мэдэхгүй
1	Шүүгч	89.9%	10.1%		
2	Эвлэрүүлэн зуучлагч	100.0%			
3	Эвлэрүүлэн зуучлагчийн туслах	96.4%		3.6%	
4	Өмгөөлөгч, хуульч	88.9%	2.8%	1.4%	6.9%

Нийт	92.2%	4.6%	.5%	2.7%
-------------	-------	------	-----	------

Мөн дээрх хүснэгтээс үзэхэд нийт судалгаанд оролцсон 223 шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, өмгөөлөгчдийн 92.2 хувь нь эвлэрүүлэн зуучлах тогтолцоо бий болсноор шүүхийн ажлын ачаалал багассан гэж дүгнэсэн нь иргэний эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлааар шийдвэрлэх нь чухал ач холбогдолтой болохыг харуулж байна.

6. Хөдөлмөрийн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх

Сонгосон зүйл, заалт	Зүйл заалтын агуулга
31 дүгээр зүйл.Хөдөлмөрийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа	31.1.Хөдөлмөрийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь ажил олгогч болон ажилтны хооронд гарсан хөдөлмөрийн ганцаарчилсан маргааны хүрээнд явагдана.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан болон гэр бүлийн харилцаанаас үссэн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэнэ” гэж заасны дагуу эвлэрүүлэн зуучлааар шийдвэрлэх маргааны нэг төрөл нь хөдөлмөрийн эрх зүйн маргаан юм. Хөдөлмөрийн эрх зүйн маргааныг хөдөлмөрийн ганцаарчилсан болон хөдөлмөрийн хамтын маргаан гэж ялган авч үздэг. Харин эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь хөдөлмөрийн хамтын маргаанд хэрэгжихгүй бөгөөд хөдөлмөрийн ганцаарчилсан маргаанд ашиглаж болно.

Тэгвэл 2014-2019 оны хооронд эвлэрүүлэн зуучлааар шийдвэрлэгдсэн маргааныг авч үзвэл иргэний эрх зүйн маргаан 51,085, Хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан 435, Гэр бүлийн эрх зүйн маргаан 16,734 байна. Үүнээс иргэний эрх зүйн маргааны 45,013 буюу 88.1 хувь, хөдөлмөрийн ганцаарчилсан маргааны 311 буюу 71.5 хувь, гэр бүлийн эрх зүйн маргаанд 2,263 буюу 13.5 хувьд эвлэрэл амжилттай болсон байна.

Хөдөлмөрийн эрх зүйн маргаан нь иргэний эрх зүйн маргаан болон гэр бүлийн эрх зүйн маргаантай харьцуулахад харьцангуй цөөн тоотой боловч нийт эвлэрүүлэн зуучлалд хандсан маргааны 71.5 хувь буюу 311 хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан амжилттай шийдвэрлэгдсэн.

Иймд хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаар шийдвэрлэх нь үр дүнтэй бөгөөд зорилгод хүрэх түвшин хангасан байна гэж дүгнэж байна.

7. Гэр бүлийн эрх зүйн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх

Сонгосон зүйл, заалт	Зүйл заалтын агуулга
-----------------------------	----------------------

2 дугаар зүйл. Гэр бүлийн холбогдолтой маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа	32.4.Гэрлэгчдийг эвлэрүүлэх ажиллагаанд сэтгэл зүйч болон төрөл, садан, найз нөхөд, хамтран ажиллагсдыг оролцуулж болно.
--------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------

Дээрх хэсгүүдэд иргэний эрх зүйн маргаан болон хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг эвлэрүүлэн зуучлааар шийдвэрлэж үр дүнгийн талаар авч үзсэн бол энэ хэсэгт гэр бүлийн эрх зүйн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хэрхэн хэрэгжиж байгаа талаар авч үзье.

Монгол Улсын хэмжээнд иргэний хэргийн шүүх анхан шатны журмаар жилд дунджаар 40 орчим мянган хэрэг шийдвэрлэдэг. Тодруулбал, 2014 онд нийт шийдвэрлэсэн 33,996 хэргээс 4,207 буюу 12.4 хувь, 2015 онд нийт шийдвэрлэсэн 40,674 хэргээс 4,539 буюу 11.2 хувь, 2016 онд 4,674 буюу 10.1 хувь, 2017 онд 45,233 хэргээс 4,566 буюу 10.1 хувь, 2018 онд 48,155 хэргээс 4,763 буюу 9.9 хувийг гэр бүлийн холбогдолтой иргэний хэрэг, маргаан эзэлж байна. Үүнээс үзвэл Монгол Улсын хэмжээнд гэр бүлийн эрх зүйн маргаан Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баагүй хувийг эзэлж байгаа нь харагдах бөгөөд маргааны тоо ч жил бүр өссөн дүнтэй харагдаж байна.⁹

Гэр бүлийн эрх зүйн маргааны дийлэнх нь гэрлэлт цуцлах тухай маргаан байдаг. Гэрлэлт цуцалттай холбоотой маргаан урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хийгдсэний дараа шүүхээр хянан шийдвэрлэгдэнэ. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын гэр бүлийн маргааныг амжилттай шийдвэрлэсэн хувь 2015 онд 12 хувь, 2016 онд 12 хувь, 2017 онд 14.1 хувь, 2018 оны байдлаар 16 хувь байгаа нь бусад иргэний эрх зүйн маргааны эвлэрэл 88 хувьтай харьцуулахад маш бага үзүүлэлт юм. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны 20 гаруй хувийг гэр бүлийн маргаан /2707-3318 маргаан/ эзэлж¹⁰ байгаа боловч гэр бүлийн маргааны эвлэрэл дөнгөж 10 гаруй хувьтай байгаа нь дээрх тоон мэдээнээс харагдаж байна.

Учир нь одоогийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд гэр бүлийн маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд сэтгэл зүйч, шинжээч зэрэг мэргэжлийн хүмүүсийн оролцоо байхгүй бөгөөд эвлэрүүлэн зуучлагч нар ч энэ төрлийн мэдлэг, ур чадварыг бүрэн эзэмшээгүй, дагнан мэргэшээгүй, гэр бүлийн маргааныг амжилттай эвлэрүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн хууль эрх зүйн болон шаардлагатай зөөлөн дэд бүтцийн тогтолцоо нь бүрдээгүйтэй холбоотой гэж дүгнэж болно.

Гэр бүлийн маргаан нь ихэнхдээ талуудын сэтгэл хөдлөлийн зөрчилтэй холбогдогоороо бусад иргэний эрх зүйн маргаанаас онцлогтой. Гэтэл манай өнөөгийн эрх зүйн орчин, маргаан шийдвэрлэх процедур энэ онцлогийг харгалзан үзэхгүйгээр шүүхээс

⁹ Иргэний хэргийн шүүн таслах ажиллагааны дүн мэдээ, ШЕЗ. 2014-2019 оны хоорондох мэдээллийг судлан үзэв.

¹⁰ 2015 онд нийт шийдвэрлэсэн өргөдлийн 3318 буюу 24.6 хувь, 2016 онд нийт шийдвэрлэсэн 12589 өргөдлийн 2707 буюу 21 хувь нь гэр бүлийн эрх зүйн маргаан байна.

ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг баримталж, дээр дурдсан сэтгэл хөдлөлийн зөрчлийн онцлогт тохируулан маргааныг шийдвэрлэж чадахгүй байна.

Энэ нь шүүгч, эвлэрүүлэн зуучлагч нар маргаан шийдвэрлэхэд шаардлагатай сэтгэл зүй, социологи, сурган хүмүүжүүлэх ухааны ахисан түвшний мэдлэг, чадвар дутмагтай холбоотойгоос гадна энэ төрлийн мэргэжилтнүүд шүүхэд байдаггүй. Мөн гэр бүлийн маргаан шийдвэрлэх, эвлэрүүлэн зуучлахад шинжээчдийн оролцоо үр нөлөөгүй байна. Манай улсад мэргэшсэн шинжээчийн хүний нөөц, түүнийг шүүхийн ажиллагаанд оролцуулах тодорхой механизм байхгүй байна. Эл байдлууд болон шүүхийн хэт ачаалал, шүүхийн байрны хүрэлцээ муу зэргээс шүүх “гэр бүлийг эвлэрүүлэх” “хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах” зарчмыг бодитоор хэрэгжүүлж чадахгүй байна. Үүнээс үүдээд асуудлыг үүсгэж буй дараах шалтгаан, нөхцөлүүд байна. Үүнд:

Манай улсад гэр бүл судлалын чиглэлээр хийгдсэн судалгаа бүтээлийн дийлэнх нь гэр бүлийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж буй нийгмийн хүчин зүйлийг тодруулахад чиглэж байна. Тухайлбал, Шинжлэх ухааны академиас 2010 онд хийсэн “Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал” суурь судалгаанд ойрын 5-10 жилд өрх гэр бүлийн харилцааны асуудал улам нарийсан төвөгтэй болж, шийдвэрлэх асуудлууд дэвшин гарч ирэх хандлага ажиглагдаж буйг дурджээ¹¹. Мөн Үндэсний статистикийн хорооноос 2010 оны Хүн ам, орон сууцны улсын тооллогын үр дүнгээр “Өрх, гэр бүлийн байдал, гэрлэлт” сэдэвчилсэн судалгаа хийсэн ба ажилгүйдэл, архидалт, амьжиргааны доройтол нь гэр бүлийн доторх харилцаанд таагүй нөлөөлж, гэр бүл салахад нөлөөлсөөр буйг тэмдэглэжээ¹².

Шигтгээ 8. Шүүгчтэй хийсэн ярилцлагаас

... Гэр бүл салалт бол цэвэр нийгэм, эдийн засгийн үзэгдэл. Суурь асуудлыг нь шийдвэрхүйгээр гэр бүлийн дагнасан шүүх байгууллаа гээд эцсийн шатанд статистик өрөөсөө буурахгүй. Дагнаад багасна, хариуцлага тооцоод байвал багасна гэж бодох өрөөсгөл. Харин сургалт сурталчилгаа явуулах, гэрлэлтийн гэрээг сайтар зохицуулах шаардлагатай. Гэр бүл болвол та ийм үүрэг хүлээнэ хуваарыт өмч, дундын өмчийг тайлбарлах хэрэгтэй. Гэр бүлийн хууль зүйн харилцааг эхнээс нь таниулах, сургуулийн программд оруулах хэрэгтэй. Хамгийн түрүүнд хийх зүйл бол хуулиа мэддэг иргэнтэй болох хэрэгтэй байна. Харин гэр бүлийн шүүхтэй болсноор илүү шүүх чадавхжиж, хүүхдийн эрх ашигийг хамгаалсан зөв шийдвэр гарахад ач холбогдолтой.

2018 онд хийгдсэн “Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөний судалгаа”-наас харахад шилжин ирэгсдийн олонх нь ажилд орох, амьдралаа сайжруулах, боловсрол эзэмших, эрүүл мэндийн чанартай олон төрлийн үйлчилгээ авах зорилготой шилжин ирдэг байна¹³. Гэр бүлээрээ шилжилт хөдөлгөөнд орсон боловч нийслэлд ажлын байр олдохгүй

¹¹ ШУА-ийн ФСХ, УБИС. Монголын гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, Улаанбаатар: 2010.

¹² Үндэсний статистикийн хороо. Өрх, гэр бүлийн байдал, гэрлэлт сэдэвт судалгааны тайлан, Улаанбаатар: 2010.

¹³ НЗДТ, ШХА “Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөний судалгаа”, 2018

байх, албан бус суурьшлын бүсэд амьдрах, сургууль, цэцэрлэгийн үйлчилгээ авч чадахгүй байх зэрэг асуудал тулгарсан хэвээр байх ба энэ нь гэр бүл цуцлах болон гэр бүлээ тусгаарлах нөхцөл байдалд хүргэж болзошгүй байна.

Шигтгээ 9. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчтай хийсэн ярилцлагаас

... Гэр бүлийн маргаан маш их орж ирдэг. Нутаг дээвсгэр, хүн амын тоо, амьжиргааны түвшинээс хамаараад захын дүүргүүдээр хөдөө орон нутгаас шилжиж ирсэн хүмүүс зах зээл, эдийн засгийн хямралаас болоод гэр бүл салалт нэлээн болж байна гэж боддог. Эвлэрүүлэн зуучлагч, сэтгэл зүйч, шүүгч нь ороход болно. Орон нутагт эвлэрүүлэн зуучлагчийн нэг л орон тоо байгаа, гэр бүлийн маргаан харьцангуй бага, орж ирсэн ч эвлэрэх магадлал өндөр, бие биенээ сайн таньдаг. Дүүргээсээ бас шалтгаалж байна. Олон жил тусдаа амьдарчихсан, өөр хүнтэй гэр бүл болчихсон, хуучин баталгаагаа салгаагүй хүмүүс их орж ирдэг. Бид нар эвлэрүүлэх гэхээр боломж байдаггүй. Орж ирж байгаа хэргүүдийн тал нь ийм нөхцөл байдалтай.

Дотоод шилжих хөдөлгөөнөөс үүдсэн гэрлэлт цуцлалтаас гадна хөдөлмөрийн үнэлэмж, цалин хөлс бага, хүн амын амьжиргаа, орлогын түвшин доогуур, ажилгүйдэл зэргээс шалтгаалан гадагшаа шилжих хөдөлгөөн өссөөр байна. Өнөөдөр гадаадад оршин суугаа монголчуудын тоо 134.0 мянгаас хэдийн хол давжээ.¹⁴ Үүнээс улбаалан гэрлэгчид удаан хугацаанд тусдаа амьдрах, эхнэр нөхрийн хэн нэг нь өөр хүнтэй болох зэргээр гэрлэлт цуцлалтад нөлөөлдөг байна.

Монгол Улсын Засгийн газраас 2006 оны 5 сарын 5-нд 18-аас доош насны бүх хүүхдэд сар бүр мөнгөн тэтгэмж олгох, шинээр төрсөн (2006 оны 7 сар) болон шинээр гэрлэгчдэд мөнгөн тэтгэмж олгох шийдвэр гаргасан. 2006 оны 6 сарын 2-нд хүүхдэд өгөх мөнгийг сарын 3000 төгрөг, шинээр гэрлэгсдэд 500,000 төгрөг, шинээр төрсөн хүүхдэд 100,000 төгрөг тус тус олгох болсон. Энэхүү бодлого нь төрөлт болон гэрлэлтээ бүртгүүлэх байдалд зөргээр нөлөөлсөн боловч хуурамч гэрлэлт бий болж, хиймлээр гэрлэлтийн тоог өсгөсөн гэж судалгаанд хамрагдсан эвлэрүүлэн зуучлагчид онцолж байв.

Шигтгээ 10. Эвлэрүүлэн зуучлагчтай хийсэн ярилцлагаас

... Гэр бүлийн маргаан маш их орж ирдэг. Нутаг дээвсгэр, хүн амын тоо, амьжиргааны түвшинээс хамаараад захын дүүргүүдээр болон хөдөө орон нутгаас шилжиж ирсэн хүмүүс зах зээл, эдийн засгийн хямралаас шалтгаалж гэр бүл салалт нэлээн болж байна гэж боддог. Түүнчлэн 500 мянган төгрөгний хуурамч гэрлэлт явсаар л байна. Гэр бүлийн маргаантай асуудал шүүхээс орохоос өмнө заавал эвлэрүүлэн зуучлалаар орж байгаа боловч эзлэрэл бага байна.

Монгол Улсад гэр бүлийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх үндсэн хоёр тогтолцоо байна. Нэгдүгээрт, иргэн өөрийн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, хамгаалуулахаар

¹⁴ УСХ, (2011) Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын нэгдсэн дүн, Улаанбаатар

шүүхэд хандах эрхийн хүрээнд гэр бүлийн эрх зүйн маргааныг иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэдэг. Хоёрдугаарт, 2013 оноос хэрэгжиж эхэлсэн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн З дугаар зүйлийн 3.1-т зааснаар эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэж гэр бүлийн эрх зүйн маргааныг шийдвэрлэх боломжтой байна.

Шигтгээ 11. Шүүгчтэй хийсэн ярилцлагаас

... Нэг гэр бүл эрүүл сайн байна гэдэг маань өөрөө нийгэмд эерэг нөлөө үзүүлнэ. Зөв төлөвшилтэй, зөв хүмүүжилтэй иргэн бол Монгол Улсын хөгжлийг тодорхойлох хүчин зүйл мөн. Энэ нь гэр бүлийн бүрэн бүтэн байдлаас эхлэлтэй. Мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагч, шүүгч ажиллаад ирэхээр оролцогчдын эрх зүйн ухамсар дээшилнэ, эерэг үр нөлөө маш их байгаа. Эдийн засгийн ач холбогдол гэх юм бол шууд бус утгаараа эдийн засгийн үр нөлөө байгаа байх. Эд хөрөнгийн маргаан дээр ипотекийн асуудал байна. Эдийн засгийн ач холбогдол нь цаад утгаараа байгаа. Гэр бүл цуцлахгүй бол адаглаад нэг нь нөгөөдөө тэтгэлэг төлөхгүй, эд хөрөнгөө булаацалдаж, дахиж гэр бүл зохиохгүй гээд эдийн засагт үр нөлөө гарна...

...Нэг гэр бүл ч гэсэн тоогтвортой байна гэдэг ар гэрийн амьдрал ахуй, хүүхдүүдийн эрх ашиг хөндөгдөх хамгийн чухал асуудал. Эвлэрүүлэх арга механизм нь дагнасан шүүх үү? эсхүл тэр арга замдаа юу? Минийхээр эвлэрүүлэх арга замдаа байна гэж харж байгаа учраас эвлэрүүлэх арга замдаа анхаарвал боломжийн юм байна гэж байна. Тэгээл эерэг үр дүн гарна.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.4-т зааснаас бусад гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагааны нэг гэж үзнэ” гэж зааснаар гэрлэлт цуцлалттай холбоотой маргаан заавал эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэгдсэний дараа шүүхэд иргэний хэрэг үүсгэдэг болсон. Тухайлбал 2018 онд шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд 2,995 гэр бүлийн эрх зүйн маргааны өргөдөл ирсэн бөгөөд үүнээс 412 өргөдөл буюу 13.6 хувьд нь эвлэрэлт амжилттай явагдсан, 2019 онд 3020 гэр бүлийн эрх зүйн маргааны өргөдөл ирсэн бөгөөд үүнээс 377 өргөдөл буюу 12.4 хувьд нь эвлэрэлт амжилттай явагдсан, буюу талууд гэрлэлтээ цуцлуулахгүй эвлэрсэн бол 2,643 өргөдөл буюу 87.6 хувьд нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй явагдсан байна.

Гэр бүлийн маргааны эвлэрэл иргэний эрх зүйн бусад төрлийн маргаантай харьцуулахад яагаад бага байгаа шалтгаан нь гэр бүлийн маргаан, гэрлэлт цуцлуулах шийдвэр гаргалтын онцлогтой холбоотой. Гэр бүлийн дотоод нууцлагдмал зөрчлийг илрүүлэн, зөрчилдөгч талуудын хүсэл сонирхол, сэтгэл зүйг нээн харилцаж, нэг чиглэлд харуулах, гэр бүлийн бүх гишүүдийн эрх ашигт нийцсэн шийдэлд хүргэх асуудал бол маргалдагч талууд болон эвлэрүүлэн зуучлагчийн аль алины хүчин чармайлтаас шалтгаалах хүнд хэцүү өгөгдөл юм. Ийм учраас тус онцлогт нийцүүлэн шийдвэрлэх процесс дутмагаас гэр бүлийн маргаанд эвлэрүүлэн зуучлагчийн хүчин чармайлт ихэнхдээ үр дүнгүй болж байна. Түүнчлэн гэр бүлийн эрх зүйн хэрэг маргаанд Эвлэрүүлэн зуучлалын тухай

хуульд заасан талуудыг эвлэрүүлэх эрх зүйн зохицуулалт, арга хэрэгсэл дутмаг байгаатай холбоотой байж болох юм.

Шигтгээ 12. Шүүгчтэй хийсэн ярилцлагаас

... Шүүх дээр ороод ирэхээр нь эвлэрүүлэх хугацаа өгөөд захирамжид заасан ажиллагааг хийнэ. Одоо шууд хурлын танхимаас гараад эвлэрүүлэн зуучлагчтай уулзалт хийх уулзалтаяа товло. Эвлэрүүлэн зуучлагчаасаа сэтгэл зүйчтэй хийх уулзах цагаа товлуулж аваад яв, эвлэрүүлэн зуучлагчийн ир гэсэн цагт ирэхгүй бол арга хэмжээ авна гэж хэлээд гаргахаар ирж уулзсан байдаг. Заавал ямар нэгэн албадлага хэрэг болоод байдаг. Бүр үгүй гээд тас буруу хараад суусан хүмүүс ч эвлэрсэн. Давах дээр хүчингүй болсон хэрэг бүгд эвлэрүүлэх арга хэмжээг дахиад нэг явуулсангүй гээд буцаадаг. Шүүх эвлэрүүлэх бүхий л арга хэмжээг авах байтал чи бүхий л арга хэмжээг аваагүй байна гэдэг...

Судалгааны дүнгээс үзэхэд гэр бүлийн маргаанд эвлэрүүлэн зуучлал явуулахад хамгийн хүндрэлтэй байдаг бөгөөд энэ нь эвлэрүүлэн зуучлагч хэргийн нэг талтай ганцаарчилан уулзахыг хориглодог, гэрлэгчид дийлэнхдээ асуудал эцсийн шатанд орсны дараагаар эвлэрүүлэн зуучлал ханддагтай холбоотой байна. Тухайлбал гадаад орнуудын жишээнээс үзэхэд эвлэрүүлэн зуучлалын хэргийн онцлогоос хамаарч эвлэрүүлэн зуучлагчийг мэргэшүүлэн ажиллуулдаг байна. Япон улсын хувьд Гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэхэд мэргэжлийн сэтгэл зүйч оролцуулах, шаардлагатай бол эмчилгээ хийлгэсний дараагаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа үргэлжлүүлэн явуулдаг.

Харин манай улсын хувьд эвлэрүүлэн зуучлагчийг хэрэг маргааны төрлөөр дагнан мэргэшүүлдэггүй тул нарийн төвөгтэй хэрэг маргааныг шийдвэрлэхэд хүндрэл учирдаг тухай ганцаарчилсан ярилцлагын үеэр эвлэрүүлэн зуучлагч нар хэлж байв. 2015 онд хийсэн Эвлэрүүлэн зуучлалын ажиллагааны мониторингийн тайланд эвлэрүүлэн зуучлагчийг дагнан мэргэшүүлэх, сэтгэл судлалын чиглэлээр сургалтанд хамруулах шаардлагай гэж дүгнэж байсан бөгөөд өнөөдөр ч энэ асуудал хэвээр байгаа нь энэ талаар дорвитой арга хэмжээ аваагүй гэж дүгнэж болохоор байна.

Шигтгээ 13. Эвлэрүүлэн зуучлагчтай хийсэн ярилцлагаас

... Гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлэхэд бэрхшээлтэй байна. Тухайлбал нэгэнтэй эвлэрэхгүй нь тодорхой буюу хамтран амьдрагчтай болсон, цаашлаад хүүхэд болсон маргаан байгаа хэрэг дээр эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах нь үр ашиггүй байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой маргааныг шүүх шууд хүлээн авах боломжтой ч шүүхийн зүгээс хүчирхийлэл нотлогдсон тохиолдолд хүлээн авна гээд эвлэрүүлэн зуучлал буцаагаад байдаг. Гэвч хүчирхийлэл нь олон төрөл сэтгэл санаа, эдийн засгийн гээд тэр шууд нотлох баримт байдаггүй тохиолдолд гарч байна. Энэ практик бодит байдалд нийцэхгүй, иргэдийг дахин дахин улсын тэмдэгтийн хураамж төлүүлж чирэгдүүлэх асуудал гардаг.

Иймд гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх зохицуулалт зарим талаараа практик, бодит байдалд нийцэхгүй байгаа бөгөөд зорилгод хүрэх түвшин хангалтгүй гэж дүгнэж байна.

3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

1. Эвлэрүүлэн зуучлагчид тавигдах шаардлага

9 дүгээр зүйл. Эвлэрүүлэн зуучлагчид тавигдах шаардлага	9.1. Энэ хуулийн 7, 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчид дараах шаардлага тавигдана: 9.1.1. эрх зүйн бүрэн чадамжтай байх; 9.1.2. дээд боловсролтой байх; 9.1.3. эвлэрүүлэн зуучлагчийн сургалтад хамрагдан эрхийн гэрчилгээ авсан байх; 9.1.4. эрх бүхий байгууллагын эвлэрүүлэн зуучлагчийн нэrsийн жагсаалтад бүртгэгдсэн байх; 9.1.5. ял шийтгэлгүй байх.
--------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд эвлэрүүлэн зуучлагчид тавигдах шаардлагыг хуульчилсан байх бөгөөд үүнд эвлэрүүлэн зуучлагч нь эрх зүйн бүрэн чадамжтай байх, дээд боловсролтой байх, эвлэрүүлэн зуучлагчийн сургалтад хамрагдан эрхийн гэрчилгээ авсан байх, ял шийтгэлгүй байх гэсэн ерөнхий шаардлагуудыг тусгаж өгсөн байна.

Хэдийгээр эвлэрүүлэн зуучлагч нь иргэний эрх зүй, хөдөлмөрийн эрх зүй, гэр бүлийн эрх зүйн хэрэг маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулах боловч гэр бүлийн эрх зүйн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах нь нөгөө хоёр маргаанаас илүүтэй ур чадвар шаардах, талуудын болон хүүхдийн сэтгэл зүйн асуудлыг нарийн ойлгож мэдэх, судалгаа, дүн шинжилгээ хийх нарийн чадварыг шаардаж байна.

Шигтгээ 14. Шүүгчтэй хийсэн ярилцлагаас

... Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа манай улсад анх бий болохдоо шүүхийн ачааллыг бууруулах зорилготой гэж гарч ирж байсан. Гэхдээ шүүгч нарын санасан хэмжээнд хүрэхгүй байна. Эвлэрүүлэн зуучлагчаар ажиллаж байгаа хүмүүс хуульч биш хүмүүс буюу хэрэг маргааны талаар анхан шатны мэдлэггүй, талуудын гаргаж өгсөн баримтад эрх зүйн дүгнэлт өгөх боломжгүй хүмүүс талууд эвлэрлийн гэрээ байгуулахад оролцож буй нь янз бүрийн буруу үр дүнтэй авчрах эвлэрлийн гэрээ байгуулчих вий гэсэн эмзэглэл шүүгч нарт байна.

Тухайлбал өөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндэслэл болохоор хуурмаг, хууль зөрчсөн, гуравдагч этгээдийн ашиг сонирхол хөндсөн эвлэрлийн гэрээг эвлэрүүлэн зуучлагч нар нь өөрсдөө дүгнэх боломж муутай, шүүгч нарт нотлох баримт нь байхгүй

түл мэдэх боломжгүй байна. Иймд эвлэрүүлэн зуучлагч нар хуулийн цагаан толгой заалгасан хүмүүс баймаар санагддаг.

Хөдөлмөрийн эрх зүйн маргаан болон иргэний эрх зүйн маргаанд талууд өөрсдөө асуудлаа шийдэх, асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах чадвартай байдаг бол гэр бүлийн эрх зүйн маргаанд талууд өөрсдөө асуудлыг шийдэх, харилцан ярилцах нь хүндрэлтэй юм. Иймд эвлэрүүлэн зуучлагч маань гэр бүлийн харилцаагаар мэргэшсэн байх шаардлагатай тулгарч байгаа бөгөөд гэр бүлийн маргааны эвлэрүүлэн зуучлагчыг энэ төрлөөр нь дагнан мэргэшүүлэх хэрэгтэй ба гэр бүлийн эрх зүйн маргааныг шийдвэрлэх эвлэрүүлэн зуучлагчид тавигдах шаардлагыг эвлэрүүлэн зуучлагчид тавигдах нийтлэг шаардлагаас тусад нь хуульчлах боломжтой байна.

Шигтгээ 15. Шүүгчтэй хийсэн ярилцлагаас

... Нэгт, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хугацааг нь уртасгах, сэтгэл зүйч ажиллуулах, Хоёрт, хариуцлагыг өндөрсгэх, гэрлэлтийг цуцлах юм бол хүлээлгээдэг мөнгөн торгууль байх хэрэгтэй харагддаг. Гэрлэлт цуцалтыг бууруулна гэдэг бол хэцүү. Орж байгаа улсууд маань 10 жил тусдаа амьдарч, өөр гэр бүл зохиосон улсууд байна. Зөвхөн тэр цаасан дээр байгаа юмаа цуцлуулахаар орж ирж байна. Тэр тохиолдолд яалтажгүй цуцална. Дагналаа гээд гэрлэлт буурах нь юу л бол. Эвлэрүүлэн зуучлалаар гэр бүлийн маргаан зайлшгүй орох учир гэр бүлийн маргаантай асуудлын хоног хугацааг сунгавал үр дүн гарч магадгүй.

2. Эвлэрүүлэн зуучлагчийн эрх, үүрэг

14 дүгээр зүйл.Эвлэрүүлэн зуучлагчийн эрх, үүрэг	14.1. Эвлэрүүлэн зуучлагч дараах эрх эдэлнэ: 14.1.4. эвлэрүүлэн зуучлалд идэвхтэй оролцохыг талуудаас шаардах, талуудыг ганцаарчилсан болон хамтарсан уулзалтад дуудан ирүүлэх;
---------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------


Эвлэрүүлэн зуучлагчид тулгарч буй дараагийн гол бэрхшээл нь уригдах талыг дуудаад ирдэггүй явдал байна. Эвлэрүүлэн зуучлагчдын зүгээс Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль хэт зөөлөн учир талуудыг дуудан ирүүлэх ажиллагааг боловсронгуй болгохгүй бол эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд уригдагч тал ирэхгүйгээр ажиллагаа дуусгавар болох тохиолдол их гарч байгаа гэж судалгаанд оролцсон шүүгч, эвлэрүүлэн зуучлагчийн дийлэнх нь хэлж байв. Мөн уригдагч талыг ирүүлэх тал дээр зуучлагчийн ур чадварыг дээшлүүлэх, арга техник эзэмшигүүлэх шаардлагатайг хэлж байлаа.

График 14. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад бэрхшээл тулгарсан эсэх /иргэдийн хариулт/



Судалгаанд оролцсон иргэдээс эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад ямар нэгэн хүндрэл бэрхшээл тулгарсан эсэхэд тэдний 4 хувь нь тийм, 96 хувь нь ямар нэгэн хүндрэл тулгараагүй гэж хариулжээ. Харин хүндрэл бэрхшээл байна гэж үзвэл юу байгаа талаар тодруулбал дараах байдлаар хариулсан байна.

График 15. Эвлэрүүн зуучлах ажиллагаанд тулгардаг хүндрэл бэрхшээл /иргэдийн хариулт/



Эвлэрүүлэн зуучлах ажиллаганы хүндрэл бэрхшээл нь ер нь нөгөө тал буюу уригдагч талын идэвхгүй байдал байна гэж судалгаанд оролцсон хүмүүсийн 75 хувь нь буюу $\frac{3}{4}$ нь үзжээ. Харин шүүхийн талаас шүүгч, өмгөөлөгч, эвлэрүүлэн зуучлагч, туслах нар дараах байдлаар харж байна. Үүнд:

График 16. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд тулгардаг хүндрэл бэрхшээл /Шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах, өмгөөлөгч, хуульчийн хариулт/



Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд тулгамдаж буй хүндрэл бэрхшээлийг шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, туслах, өмгөөлөгч нар үзэхдээ мөн маргалдагч талуудын нөгөө талыг гэж үзсэн байна. Үүнийг эвлэрүүлэн зуучлагчийн эрх хэмжээтэй холбож авч үзжээ. Үүний дараагаар үйлчлүүлэгчийн харьцаа, эрх зүйн мэдлэг дутуу байдал, цалин хангамж бага, материаллаг орчин нөхцөл тааруу зэрэг шалтгаанууд дэс дараагаараа орсон байна.

Туайлбал судалгаанд оролцсон иргэдийн 71.1 хувь нь эвлэрүүлэн зуулчах ажиллагаанд тулгардаг гол бэрхшээл нь уригдагч тал ирэхгүй байх тохиолдолд эвлэрүүлэн зуучлагчид талуудыг дуудан ирүүлэх тал дээрх эрх хэмжээ байхгүй гэсэн байна. Өөрөөр хэлбэл шүүхийн шатанд хариуцагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралд ирэхгүй бол албадан ирүүлэх, эсхүл хариуцагчийг эзгүйд хэргийг шийдвэрлэх боломжтой байдаг бол эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зарчимд заавал талууд хоёр тал сайн дурын үндсэн дээр оролцдог учир эвлэрүүлэн зуучлагчид албадан ирүүлэх арга хэмжээ авах эрх олгогдоогүй байдаг.

Шигтгээ 16. Эвлэрүүлэн зуучлагчтай хийсэн ярилцлагаас

... Талуудыг албадан ирүүлэх зохицуулалт шаардлагатай байна. Хаягийн дагуу мэдэгдэх хуудас явуулахад тэр хаяг дээр амьдардаггүй, бүртгэлгүй байх, нүүж явсан тохиолдол гардаг. Энэ тохиолдолд өргөдлийн хүлээн авахаас татгалздаг. Талуудыг байнга утсаар дууддаг учраас албаны утасны төлбөр төлөгдөөгүй гээд хаагдах тохиолдолд өөрсдийн утсаар дууддаг. Утасны мөнгө урьд өгдөг байснаа хассан тул утасны мөнгө өгвөл сайн байна.

Нөгөө талаар нэгэнт албадан ирүүлэх боломжгүйг мэдсэн уригдагч тал санаатайгаар уулзалтад ирэхгүй байх зэргээр эвлэрүүлэн зуучлах ажиллагааг удаашруулж, өргөдөл гаргагчийн шүүхэд хандах хугацааг хойшилуулах арга болгон ашиглаж байхыг үгүйсгэхгүй. Энэ нь цаашид эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд сөргөөр нөлөөлөх хандлагыг бий болгох эрсдэлтэй байна.

Шигтгээ 17. Эвлэрүүлэн зуучлагчтай хийсэн ярилцлагаас

... Манай үнэлгээ эвлэрлийн гэрээ байгуулсан бол амжилттай, өөр бусад үндэслэлээр дуусгавар болсон, өргөдлийг хүлээн авахаас татгалзсан бол амжилтгүй гэсэн 2 үнэлгээтэй байдаг. Тухайлбал иргэний маргаан дээр өргөдлийн дагуу уригдах талыг дуудахад уригдах тал завгүй тул очиж амжихгүй тул шууд төлбөрийг барагдуулах тохиолдол гардаг бөгөөд энэ тохиолдолд өргөдөл гаргагч өргөдлөө татан авдаг бөгөөд энэ нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсонд хамаардаг. Мөн хаяг тодорхойгүй гэдэг асуудал гардаг, хорооны засаг даргын тодорхойлолтоор бүртгэлтэй боловч оршин суудаггүй, эсвэл оршин суудаггүй гэсэн бол харьяаллын дагуу өргөдөл гаргаагүй гээд хүлээн авахаас татгалздаг энэ мөн амжилтгүй болсон хамаардаг.

Гэвч нөгөө талаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь талуудын сайн дурын үндсэн дээр явагддаг буюу ямар нэгэн албадлагын арга хэмжээ байдаггүйгээрээ онцлогтой. Хэрэв эвлэрүүлэн зуучлагчид талуудыг албадан ирүүлэх арга хэмжээ авах эрхийг олгосон тохиолдолд энэхүү зарчимтай зөрчилдөх, эвлэрүүлэн зуучлалын үндсэн шинжийг алдагдуулах эрсдэлтэй.

Шигтгээ 18. Шүүгчтэй хийсэн ярилцлагаас

... Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны уригдаж талыг дуудаад хаягтаа байхгүй бол эвлэрүүлэн зуучлах ажиллаа явуулах боломжгүй боллоо гээд буцаагаад байна. Тэгэхээр шүүхээр албадан ирүүлэх, шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах, шүүхээр дамжуулан хаягийн лавлагаа гаргуулж аваад тэр хаягаар нь дуудах гэх мэт боломжийг бүрдүүлэх хэрэгтэй.

Хэдийгээр Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д “Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зуучлагч Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 77 дугаар зүйлд заасан журмын дагуу талууд болон холбогдох этгээдийг шүүхийн мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлнэ” гэж заасан ч мэдэгдэх хуудсыг хүлээн аваад ирэхгүй байсан ч ямар нэгэн арга хэмжээ авах зохицуулалтгүй.

Харин эвлэрүүлэн зуучлалын маргааны төрлөөс хамаарч тодорхой хязгаарлагдмал хүрээнд, талуудын хаяг тогтоох, албадан дуудан ирүүлэх арга хэмжээг авах боломжтой байхыг үгүйсгэхгүй. Тухайлбал Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.4-т зааснаас бусад гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагааны нэг гэж үзнэ”, 6.5-д “Энэ хуулийн 6.3, 6.4-т заасан журмыг зөрчиж нэхэмжлэл гаргасан бол шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65.1.3-т заасны дагуу уг нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана” гэсний дагуу гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааныг эхлээд заавал эвлэрүүлэн зуучлалаар орсны дараагаар шүүхэд хандах эрх нээгддэг.

Гэтэл гэрлэгчдийн хэн нэгний сэтгэл санааны дарамтад байх, нэгэнт эвлэрэх боломжгүй байгаа хүмүүсийн хувьд аль нэг тал нь ирэхгүй байх зэргээр эвлэрүүлэн зуучлах хуульд заасан хуагцаа өнгөрснөөр 28 дугаар зүйлийн 28.1.1-д “аль нэг тал нь эвлэрүүлэн


зуучлах ажиллагаанд оролцоогүй бол эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дуусгавар болно” гэсний дагуу дуусгавар болдог. Энэ тохиолдолд эвлэрүүлэн зуучлагчид хугацаа алдахгүйн үүднээс ирэхгүй байгаа талыг дуудан ирүүлэх албадлагын арга хэмжээ авах эрхийг олгох боломжтой.

3. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах хугацаа

20 дугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах хугацаа	20.1. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг 30 хоногт багтаан явуулах бөгөөд талуудын хүсэлтээр энэ хугацааг нэг удаа сунгаж болно.
---------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “эвлэрүүлэн зуучлах ажиллагааг 30 хоногт багтаан явуулах бөгөөд талуудын хүсэлтээр энэ хугацааг нэг удаа сунгаж болно” гэж заасан байдаг. Энэ нь шүүхтэй харьцуулахад аль болох хэргийг хурдан хугацаанд амжилттай шийдвэрлэх зорилготой бөгөөд энэ нь талуудын хувьд ч цаг хугацаа, зардлын хувьд хэмнэлттэй ашигтай байдаг.

График 17. Маргааны шийдвэрлэж буй дундаж хугацаа (маргааны төрлөөр)



Тухайлбал, нийт судалгаанд оролцогчдоос авсан асуулгын хүрээнд нийт эвлэрүүлэн зуучлалд хандсан маргааны 38.7 хувийг 10 хүртэл хоног, 30.1 хувь нь 11-20 хоног, 22.1 хувь нь 21-30 хоногт шийдвэрлэдэг гэсэн байна. Үүнээс үзэхэд маргааны 90-ээс дээш хувийг хуульд заасан хугацаа буюу 30 хоногт багтаан шийдвэрлэдэг болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, маргааныг шийдвэрлэж буй хугацаа нь шүүхтэй харьцуулахад харьцангуй

богино хугацаанд шийдвэрлэж байгаагаараа ач холбогдолтой бөгөөд хуульд заасан хугацаа ч маргааныг шийдвэрлэх зохистой хугацаа гэж дүгнэж байна.

Нэхэмжлэл, өргөдлийг маргааны төрлөөр ангилж үзээд хуулийн хугацаанд шийдвэрлэж буй байдлыг тандаж үзвэл гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн маргаан, өв залгамжлалын маргаан, бизнесийн маргаан зэрэг нь хугацаа их шаарддагдаг бол зээл, гэрээтэй холбоотой маргаан, тэтгэвэр тэтгэмж, нэхэмжлэх маргаан, эд хөрөнгийн маргаан зэрэг нь бага хугацаа шаарддагдаг байна.

Хүснэгт 17. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаар маргааныг шийдвэрлэхдээ хийсэн уулзалтын тоо (иргэдийн хариулт)

№	Утга	Өргөдөл гаргагч	Уригдагч	Бусад
1	Анхны уулзалтаар шийдсэн	63.50%	71.10%	83.30%
2	2 уулзалт хийсэн	24.30%	24.40%	16.70%
3	3-4 удаа уулзсан	9.60%	2.20%	
4	4-өөс дээс уулзсан	1.70%	2.20%	

Тухайлбал эвлэрүүлэн зуучлалаар маргаанаа шийдвэрлүүлсэн иргэдийн 66.3 хувь нь анхны уулзалтаар, 24.1 хувь нь 2 удаагийн уулзалтаар шийдвэрлэсэн байх ба энэ нь 30 хоногийн хугацаанд хангалттай багтаж шийдвэрлэх боломжтой байна. Гэхдээ үүнд анхаарах ёстой зүйл байгаа нь эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэж буй бүхий л төрлийн маргаанд адилхан хугацаа тавьсан нь хэргийн агуулга, цар хүрээнээс хамаараад хугацаандаа амжихгүй байх тохиолдол байдаг.

Шигтгээ 19. Эвлэрүүлэн зуучлагчтай хийсэн ярилцлагаас

... Гэр бүлийн маргаан дээр хуульд заасан хугацаа богино байх тохиолдол гардаг. Иргэний эрх зүйн маргаан дунджаар 7-14 хоногийн дотор шийдэгдэж байна.

Үчир нь гэр бүлийн маргаанд эвлэрүүлэн зуучлал нь мөн л 30 хоногийн хугацаатай хийгдэнэ. Гэтэл гэр бүлийн маргааны хувьд 30 хоногийн хугацаа нь богино байх бөгөөд эвлэрүүлэн зуучлалд талуудыг албадан ирүүлэх зэрэг албадлагын арга хэмжээ авах эрх байхгүй учраас энэ хугацаанд талуудыг дуудаж уулзах, эвлэрүүлэх ажиллагаа хийх нь төдийлөн үр дүнд хүрдэггүй байна.

Түүнлчэн хуульд заасны дагуу талуудын хүсэлтийн дагуу нэг удаа 30 хоногоор сунгах боломжтой байдаг ч гэрлэлт цүцлах маргаанд талуудын хэн аль нь хүсэлт гаргах тохиолдол туйлын цөөхөн учир хуульд заасан 30 хоногийн хугацааг хэрэг маргааны төрлөөс хамааран гэр бүлийн эрх зүйн маргаанд ялгамжтай тогтоох нь гэр бүлийн маргаан дахь эвлэрлийн хувь өсөх боломжтой.

Шигтгээ 20. Эвлэрүүлэн зуучлагчтай хийсэн ярилцлагаас

... Эвлэрүүлэн зуучлалын хугацаа 30 хоног, талууд хүсэлт гаргах юм бол дахиад 30 хоногоор 1 удаа сунгах боломж байдаг. Гэр бүлийн маргаантай залуучууд ямар шалтгаанаар ирж байна вэ? гэхээр гэрлэлтээ цуцлуулах зорилготой өргөдөл бариад ирдэг. Өмнө нь гэрлэлтээ цуцлуулах асуудлаа хоорондоо өрөөсөө ярьдаггүй, хуримтлуулж хуримтлуулж байгаад нэг өдөр өрөөсөө салъя гээд өргөдлөө өгдөг. 30 хоногийн хугацаа бага байдаг, сунгах боломжтой ч талуудын аль аль нь хүсэлт гаргадаггүй, хүсэлтгүй бол зуучлагч сунгах боломжгүй, хоёрдугаарт утасруу нь залгана, өргөдөл дурдсан хаягаар нь мэдэгдэх хуудас явуулдаг, албадан авчрах боломж байдаггүй. Хоног хугацаа өнгөрөөд байдаг, хуулийн хугацааны дунд нь ирдэг ирээд анхны уулзалтаараа өргөдөлтэй танилцаад, ярьж байгаа асуудлыг эсэргүүцээд, хоорондоо маргалддаг. Сэтгэл зүйчид хандуулдаг, уулзана гэж явж байгаад 7 хоног өнгөрчихдөг. Хоёрдахь уулзалт болох гээд явж байтал хуулийн хугацаа нь тулчихдаг, дуусгавар болдог. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 28.1.2 уулзалт удаа дараа болсон боловч үр дунд хүрээгүй, цаашид үр дунд хүрэхгүй нь тодорхой учраас, хоёрт хугацаа дуусч байгаа учраас гээд ингээд дуусгавар болчихдог...

4. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаан дахь хөөн хэлэлцэх хугацаа

18 дугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны нийтлэг үндэслэл	18.5. Талууд эвлэрүүлэн зуучлалыг сонгосон, уг ажиллагаанд оролцсон байдал нь шүүхээс Иргэний хуулийн 79.1, 82.4-т заасны дагуу хөөн хэлэлцэх хугацааг сэргээх, эсхүл уг хугацааг тасалдсан гэж үзэх үндэслэл болно.
------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд заасны дагуу эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцоход хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа тасалдах зохицуулалттай. Гэхдээ энд тулгарах гол зүйл нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явц дахь хэргийн материалын хадгалалт, баримтжуулалт, бүртгэлийн асуудал хөндөгддөг. Өөрөөр хэлбэл, аль хугацаанаас эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тасалдсан гэдгийг тогтооход өргөдөл гаргагч тал өргөдлөө гаргасан, эсхүл уригдагч тал эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хүрэцэн ирснээр үү гэдгийг тогтоох шаардлагатай. Үүний тулд шүүх дэх эвлэрүүлэн зуучлал болон бусад байгууллага дахь эвлэрүүлэн зуучлах төвүүд нь эвлэрүүлэн зуучлалын бүртгэл, хөдөлгөөний тогтолцоог бүрдүүлсэн байх шаардлагатай. Тиймээс Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийн хэрэгжилтийг эвлэрүүлэн зуучлал дахь баримт, материалын бүртгэл, хадгалалт ямар байгаа талаас нь үнэлэсэн болно.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д “Эвлэрүүлэн зуучлагч буюу түүний даалгавраар эвлэрүүлэн зуучлах ажилтан ажиллагаа бүрийн тэмдэглэлийг цаг тухайд нь хөтөлнө”, 25.2 “Тэмдэглэлийг Монгол хэлээр хөтлөх бөгөөд түүнд уулзалтыг хэзээ, хаана хийсэн, эхэлсэн, дууссан цаг, эвлэрүүлэн зуучлагч болон уулзалтад оролцсон талуудын овог, нэр, хаяг, талуудын асуулт, хариулт, тайлбар, санал нэгдсэн байдал, шийдэл, дараагийн ажиллагааны арга, хэлбэр, товыг тэмдэглэнэ”, 25.3 “Тэмдэглэлд эвлэрүүлэн зуучлагч болон талууд гарын үсэг зурна” гэж заасан. Өөрөөр

хэлбэл хуульд заасны дагуу эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хэзээ, хаана явагдсан, ямар хугацаанд үргэлжилсэн талаарх мэдээлэл бүрэн байх ёстой.

Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын тухайд ШЕЗ болон Германы ОУХАН-ийн төслийн хүрээнд 2015 оны 10 дугаар сараас эхлэн Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны бүртгэлийн нэгдсэн системийг нэвтрүүлжээ.

Тус бүртгэлийн нэгдсэн систем нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үндсэн зарчмуудад тулгуурласан бөгөөд тухайн ажиллагааны нийт процесс буюу өргөдөл хүлээн авахаас эхлэн эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулах хүртэл ажиллагаа хамаарахаас гадна ир бүрэн хайлтын систем, хугацааны хяналт, статистик, тайлан мэдээ гаргах ажлыг боловсронгуй болгосон, мэдээллийг олон дахин оруулах шаардлагагүй буюу мэдээллийн давхардал, зөрчлийг арилгасан, хэрэглээний хувьд хялбар, график дизайны хувьд дэвшилттэй зэрэг олон давуу талтай цогц систем юм.

Уг бүртгэлийн системийг хэрэглэснээр эвлэрүүлэн зуучлагч, захирагааны ажилтан өөрийн үйл ажиллагааны урсгалыг системээр дамжуулан удирдах, хяналт тавихын зэрэгцээ улсын хэмжээнд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны мэдээллийн нэгдсэн санг бурдүүлж, эвлэрүүлэн зуучлагчдын ажлыг хөнгөвчлөх, эвлэрүүлэн зуучлах мэдээллийн сангаас мэдээлэл авах, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны нэгдсэн мэдээг шуурхай, үнэн зөв гаргахад өндөр ач холбогдолтой болсон.

Иймд шүүх дэх эвлэрүүлэн зуучлалтай холбоотой баримт материалын хадгалалт, бүртгэл зэрэг нь ямар нэгэн цаг хугацааны давхардал, алдаа үүсэхээргүй байгаа нь тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь заалтын хэрэгжилтэд ямар нэгэн саад байхгүй гэж дүгнэв.

Гагцхүү шүүхээс гадуурх төрийн бус байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төвүүдэд ийм төрлийн нэгдсэн мэдээллийн сан үүсээгүй бөгөөд шийдвэрлэсэн хэргийн материалыг хэрхэн хадгалах, бүртгэх талаар тодорхой мэдээлэл байхгүй байна. Үүнээс Улаанбаатар хотын худалдааны танхимиын Эвлэрүүлэн зуучлалын журмын 12 дугаар зүйлийн 12.1-д “Эвлэрүүлэн зуучлагч буюу түүний даалгавраар эвлэрүүлэн зуучлах ажилтан ажиллагаа бүрийн тэмдэглэлийг цаг тухайд нь хөтөлнө”, 12.2 “Тэмдэглэл хөтлөх, хадгалах, хамгаалахтай холбоотой харилцааг Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна” гэснээс өөрөөр тодорхой зохицуулаагүй байна.

ДӨРӨВ. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО

4.1. Шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо

БНМАУ-ын Бага хурлын 1990 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 23 дугаар тогтоолоор Дээд шүүхийн гүйцэтгэж байсан шүүхийн зохион байгуулалтыг удирдах ажлыг тогтоол гүйцэтгэлийн асуудлын хамт Хууль зүйн яаманд шилжүүлж, орон нутагт хууль зүйн хэлтэс чиг үүргийг гүйцэтгэж байсан ба 1993 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 15 дугаар тогтоолоор шүүхэд чиг үүргийг буцаан шилжүүлжээ.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тухай” хууль 1994 оны 5 дугаар сарын 01-ний өдөр батлагдсанаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны анхны бие даасан эрх зүйн зохицуулалт бий болж, 1996 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулиар Шийдвэр гүйцэтгэлийн хэлтэс Хорих байгууллагын удирдах газрыг нэгтгэж, Засгийн газрын 1996 оны 298 дугаар тогтоолоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрыг байгуулжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага, иргэний, захиргааны, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх алба /цаашид “шийдвэр гүйцэтгэх алба” гэх/, цагдан хорих шүүхийн шийдвэр, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх алба /цаашид “хорих ял эдлүүлэх алба” гэх/, хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг гүйцэтгэх алба /цаашид “хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба” гэх/, хорих байгууллага, аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс /цаашид “шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс” гэх/-ээс бүрдэнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага буюу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар нь Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэг агентлаг, Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа байгууллага болно.

Бүдүүвч 2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх өрөхий газрын бүтэц



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын харьяа алба нь хариуцсан чиг үүргийн хүрээнд хорих байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийг нэгдсэн болон мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаагаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын даргын өмнө хариуцан тайлagnана. Шийдвэр гүйцэтгэх алба нь иргэний, захиргааны, зөрчлийн хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг хариуцдаг байгууллага болно. Тус алба нь дараах чиг үүргийг гүйцэдгэдэг. Үүнд:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих;
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар нэгдсэн тоо бүртгэл хөтлөх;
- Гүйцэтгэх баримт бичгийн цахим сан бүрдүүлэх, лавлагаа мэдээлэл олгох;
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх гомдлыг шийдвэрлэх;
- Шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулах үйл ажиллагаанд хяналт тавих;

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь нутаг дэвсгэрийн болон тусгайлсан чиг үүргийн зарчмаар зохион байгуулгадана.

Бүдүүвч 3. Шийдвэр гүйцэтгэх албаны бүтэц

ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБА
Ерөнхий шийдвэр гүйцэтгэгч

**Мэргэжлийн
удирдлагын хэлтэс**

**Мэдээлэл, лавлагаа,
дүн шинжилгээний
хэлтэс**

**Нийслэлийн шүүхийн
шийдвэр гүйцэтгэх
газар**

**Банк, хадгаламж зээлийн
хоршоодын төлбөр
барагдуулах ажлын алба**

**Орон нутаг дахь Шүүхийн
шийдвэр гүйцэтгэх газар,
хэлтэс**

Шийдвэр гүйцэтгэх алба нь Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Орон нутаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албанаас бүрддэг.

Шийдвэр гүйцэтгэгч нь ерөнхий шийдвэр гүйцэтгэгч, ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчээс бүрдэнэ. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын алба хаагчаар Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан шаардлага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тогтоосон журам, эрүүл мэнд, бие бялдар, боловсрол, мэргэжил, мэргэшил, ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан, арван найман насанд хүрсэн, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байгаагүй Монгол Улсын иргэнийг авч ажиллуулна.

2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг тойргийн журмаар гүйцэтгэх болсон. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах анхан шатны нэгж нь тогтоосон тойрог байна. Тойргийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын даргын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

ТОЙРГИЙН ТОО ТОГТООСОН ШИЙДВЭР						
№	ШШГГазар, хэлтсийн нэрс	Тойргийн дугаар	ХЗДХС-ын 2002.5.23-ны өдрийн №118 тушаал	ХЗДХС-ын 2009.10.05-ны өдрийн №199 тушаал	ХЗДХС-ын 2011.3.29-ний өдрийн №59 тушаал	ХЗСайдын 2013.01.07-ны өдрийн A/01 тоот тушаал

1	Архангай	1-5	5						5
2	Баянөлгий	6-9	4						4
3	Булган	10-13	4						4
4	Баянхонгор	14-17	4						4
5	Говьалтай	18-20	3					1	4
6	Говьсүмбэр	21-22	2						2
7	Дорноговь	23-27, 172	5	1					6
8	Зам-Үүд								0
9	Дорнод	28-32, 173	5	1					6
10	Дундговь	33-36	4						4
11	Дархан-Уул	37-44	8					2	10
12	Завхан	45-49	5						5
13	Тосонцэнгэл							1	1
14	Орхон	50-59	10						10
15	Өвөрхангай	60-66	7						7
16	Хархорин								0
17	Өмнөговь	67-70	4					1	5
18	Сэлэнгэ	71-80	10						10
19	Хөтөл								0
20	Мандал							1	1
21	Сүхбаатар	81-83	3						3
22	Төв	84-91	8						8

23	Увс	92-96	5						5
24	Ховд	97-101	5					1	6
25	Хөвсгөл	102-107,174	6	1					7
26	Хэнтий	108-112	5					1	6
27	НШГА	116-171, 175-190	55	4	15	1		12	87
28	Налайх	113-115						1	1
29	Багануур	116-118							0
30	БХЗХТБАА	191-211					21	9	30
НИЙТ ТОЙРГИЙН ТОО			167	7	15	1	21	30	241

Нэг тойротг нэг шийдвэр гүйцэтгэгч ажиллана. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг 241 шийдвэр гүйцэтгэгч хэрэгжүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих ажлыг 37 ахлах гүйцэтгэгч гүйцэтгэж ажиллаж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд, Сангийн сайдын хамтран баталсан 2017 оны тушаалаар нэг шийдвэр гүйцэтгэгчид оногдох дундаж гүйцэтгэх баримт бичгийн ачаалал 120-180 гүйцэтгэх баримт бичиг оногдохоор ажлын ачаалал тогтоогдсон.

Хүснэгт 18. Шийдвэр гүйцэтгэгчид ногдох гүйцэтгэх баримт бичиг (2017-2019.10 сар)

№	Он	Тогтоосон тойргийн тоо	Гүйцэтгэх хуудасны дундаж тоо	Үүнээс		
				Орон нутаг	НШШГГ	БХЗХТБАА
1	2017 он	211	256	214	299	333
2	2018 он	211	257	212	303	336
3	2019 оны 10 сар	237	235	200	270	280

Шийдвэр гүйцэтгэгч нь тогтоож өгсөн нормоос бараг 2 дахин илүү ачаалалтай ажилладаг байна.

4.2. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 5-р зүйлийн 5.1 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна” гэж заасны дагуу хуулийн хүчин

төгөлдөр шүүхийн шийдвэр болон шүүхээр баталгаажуулсан бусад байгууллага, албан тушаалтны шийдвэр байдаг. Энэ талаар ШШГтХ-ийн 6-р зүйлийн 6.2 дахь хэсэгт иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар дэлгэрүүлж заасныг авч үзье.

№	ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА ҮНДЭСЛЭЛ		
	Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр		Бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэр
1	Иргэний хэргийн болон эрүүгийн хэргийн хамт шийдвэрлэсэн иргэний нэхэмжлэлийн талаархи шүүхийн шийдвэр (ШШГтХ §6.2.1.)		Цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал (ШШГтХ §6.2.4.)
2	Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж (ШШГтХ §6.2.2.)		Нотариатчийн мэдэгдэх хуудас (ШШГтХ §6.2.4.)
3	Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бол гадаад улсын шүүх, олон улсын шүүх, арбитрын шийдвэр (ШШГтХ §6.2.3.)		Арбитрын шийдвэр (ШШГтХ §6.2.4.)
4	Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамж (ШШГтХ §6.2.6.)		Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр (ШШГтХ §6.2.5.)

ИХШХШтХ-ийн 183-р зүйлийн 183.1 дэх хэсэгт "Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл шүүхийн шийдвэр болон шүүхээр баталгаажуулсан Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр, цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, эвлэрийн гэрээг баталгаажуулсан шүүгчийн захирамж, арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, улсын байцаагчийн төлбөр тогтоосон акт, тэдгээрийн үндсэн дээр олгогдсон гүйцэтгэх хуудас байна" гэж зааснаас 2017 оны ШШГтХ-иар улсын байцаагчийн төлбөр тогтоосон актыг иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэлээс хассан байна.

Түүнчлэн ШШГтХ-ийн 118-р зүйлийн 10 дахь хэсэгт заасан иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг нөхөн төлүүлэх тухай ахлах шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэр нь иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэлд хамаарна.

Мөн ШШГтХ-ийн 71-р зүйлийн 18 дахь хэсэгт заасан албадан дуудлага худалдаагаар эрх шилжүүлсэн тухай дуудлага худалдааны эрхлэн хөтлөгчийн шийдвэр буюу өмчлөх эрх шилжүүлсэн тухай тогтоолыг гүйцэтгэх баримт бичгийн нэгэн адил албадан гүйцэтгэнэ.

4.3. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны төрөл

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь төлбөр гаргуулах, эд хөрөнгийн бус шаардлага хангуулах гэсэн 2 төрөлтэй байна.

Бүдүүвч 4. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны төрөл

Төлбөр гаргуулах

- Төлбөр төлөгч-иргэнээс төлбөр гаргуулах
- Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн хөрөнгөөс төлбөр гаргуулах

Эд хөрөнгийн бус шаардлага хангуулах

- Тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл тодорхой ажиллагаа гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгасан шийдвэрийг гүйцэтгэх
- Орон байр, барилгаас нүүлгэн гаргах, байр, агуулах сав, газар чөлөөлөх, барилга байгууламжийг нураах тухай шийдвэрийг гүйцэтгэх
- Төлбөр авагчийг байр, барилга байгууламжид нүүлгэн оруулах тухай шийдвэрийг албадан гүйцэтгэх
- Хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид шилжүүлэх, тэдгээртэй уулзуулах тухай шүүхийн шийдвэрийг биелүүлэх
- Үндэслэлгүйгээр ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн, өөр ажилд шилжүүлсэн ажилтныг эгүүлэн тогтоох тухай шийдвэрийг гүйцэтгэх

Монгол Улсад албадан гүйцэтгэх ажиллагаанаас тусдаа барьцааны эрхийг хэрэгжүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бие даасан төрөл байдаггүй. Барьцааны эрх бүхий этгээд ердийн журмаар буюу албадан гүйцэтгэх ажиллагаагаар дамжуулан эрхээ хангуулдаг байна.

4.4. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

1. Гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авах, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх

Гүйцэтгэх баримт бичиг нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл болох шийдвэр эх хувиараа, шийдвэрийг албадан гүйцэтгэх тухай шүүгчийн захирамж, гүйцэтгэх хуудаснаас бүрдэнэ.

Ахлах шийдвэр гүйцэтгэгч нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18, 20 дугаар зүйлд заасан шаардлага хангасан гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх тогтоол гарган тойргийн шийдвэр гүйцэтгэгчид хуваарилна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18-р зүйлд албадан гүйцэтгэх ажиллагаа эхлүүлэх хөөн хэлэлцэх хугацааг зааж өгсөн байдал.

№	Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл	Хөөн хэлэлцэх хугацаа

1	-иргэний хэргийн болон эрүүгийн хэргийн хамт шийдвэрлэсэн иргэний нэхэмжлэлийн талаархи шүүхийн шийдвэр; -хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж;	4 жил
2	-Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бол гадаад улсын шүүх, олон улсын шүүх, арбитрын шийдвэр;	3 жил
3	-шүүхээр баталгаажуулсан цэргийн анги, байгууллагын захирагч /дарга-/ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, нотариатчийн мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэр; -шүүхээр баталгаажуулсан гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр;	3 жил
4	-шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамж.	2 жил

Төлбөр авагч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хугацааг хэтрүүлсэн нь тогтоогдвол хэтрүүлсэн хугацааг сэргээлгэх хүсэлтээ холбогдох нотлох баримтын хамт шүүхэд гаргаж болох бөгөөд шүүгч уг хугацааг хэтэрснээс хойш 3 жилийн дотор нөхөн сэргээж болно. Харин тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой, эсхүл төлбөр төлөгчид тодорхой хугацааны туршид давтамжтай төлбөр төлөх болон бусад үүрэг хүлээлгэсэн хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үүрэг хүлээлгэсэн бүхий л хугацааны туршид албадан гүйцэтгэж болно.

Төлбөр төлөгч гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагаиг биелүүлэхээс зайлсхийсэн, оргон зайлсан бол энэ хугацаа тасалдана.

Шийдвэр гүйцэтгэгч нь хүлээн авсан гүйцэтгэх баримт бичгийг тойргийн анхан шатны нэгдсэн бүртгэлд бүртгэн, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлаас чөлөөлөгдөх гүйцэтгэх баримт бичиг байгаа эсэхийг хянаж, гүйцэтгэх баримт бичгийг албадан гүйцэтгэхтэй холбоотой хуульд заасан зардал төлөхийг төлбөр авагчид мэдэгдэнэ.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2018 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн тушаалын хавсралтаар батлагдсан “Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тодорхойлох, зохицуулах, төлбөр авагчид буцаан олгох журам”-ын 3.1-д “Шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэснээс хойш 7 хоногийн дотор төлбөр авагчтай зардал тооцон гаргуулах тухай” гэрээ байгуулж, уг гэрээг 2 хувь үйлдэн, 1 хувийг төлбөр авагчид, үлдэх хувийг гүйцэтгэлийн хувийн хэрэгт хавсаргана” гэж заасан тул төлбөр авагчид гэрээ байгуулах үндэслэл, шаардлага, зардлын зарцуулалтын тайлантай танилцах гаргуулсан зардлыг төлбөр төлөгчөөс нөхөн гаргуулж, түүнд олгох эрх зүйг зохицуулалтыг тайлбарлаж зардлын гэрээ байгуулна.

2. Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ авах, хөрөнгийн мэдээлэл цуглуулах

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч, төлбөр авагч, бусад этгээдийг мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлж, тайлбар авах, холбогдох баримт бичиг гаргуулан авах, эсхүл гаргасан шийдвэр болон түүнийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх

хариуцлагын талаар танилцуулна. Мөн төлбөр төлөхийг шаардах эсхүл тодорхой үйл ажиллагаа гүйцэтгэх, гүйцэтгэхгүй байхыг төлбөр төлөгч, төлбөр авагч бусад этгээдэд даалгах, төлбөр төлөгч, түүний цалин хөлс, бусад орлогоос суутгал хийхээр мэдэгдэх хуудас хүргүүлнэ.

Мэдэгдэх хуудсаар хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар бүлгийн 15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болон 15.27 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд, бусад оролцогч этгээдэд зөрчлийн шийтгэл оногдуулах саналыг ахлах шийдвэр гүйцэтгэгчид гаргана. Ахлах шийдвэр гүйцэтгэгч нь зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, мэдээллийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна.

Гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг тогтоосон хугацаанд төлбөр төлөгч биелүүлэхээс зайлсхийж өмчлөл, эзэмшилд бүртгэлтэй эсхүл шүүхийн шийдвэрт заасан хөрөнгийг бусдад шилжүүлэх, харилцах данс дахь мөнгөн хөрөнгөө татан авах үйлдлийг гаргаж, шийдвэрийн биелэлтийг хангруулах арга хэмжээг удаашруулдаг тул гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авсан даруйд хөрөнгөнд явуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал харгалзахгүйгээр иргэний шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг баталгаажуулах албадлагын арга хэмжээг шийдвэр гүйцэтгэгч хэрэгжүүлнэ.

Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ

Талууд, бусад хүн, хуулийн этгээдийн төлөөллийг дуудан ирүүлэх
Баримт бичиг, лавлагаа, тодорхойлолт гаргуулан авах
Төлбөр төлөгчийн хөрөнгийн тухай мэдүүлэг гаргуулан авах
Санхүүгийн болон бусад баримт бичигт үзлэг хийх
Тодорхой үүрэг хүлээлгэх, мэдээлэл хүргүүлэх
Төлбөр төлөгчийн хөрөнгийн эзэмшиж, ашиглаж байгаа этгээдийн барилга байгууламж, агуулах сав, эзэмшил газарт нэвтрэн орох, үзлэг хийх
Төлбөр төлөгчийн бие, бэлэн мөнгө, бусад хөрөнгөд үзлэг хий, тэдгээрийг битүүмжлэх, барьцаалах, хураан авах, хадгалуулах, хамгаалулахаар хүлээлгэн өгөх
Битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан эд зүйл, хөрөнгийг үнэлэх, уг ажиллагаанд шинжээч оролцуулах
Эд хөрөнгө, түүний эрхийн бүртгэлийн талаар улсын бүртгэлийн байгууллагад хандах, лавлагаа тодорхойлолт гаргуулах, эрхийг түдгэлзүүлэх
Банк, эрх бүхий хуулийн этгээд дэх мөнгөн хадгаламж, харилцах дансан дахь хөрөнгөөс суутгал хийх, дансны зарлагын гүйлгээг хаах, данс эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох, гүйлгээнд хяналт тавих
Үл хөдлөх төлбөр авагчийн удирдлагад шилжүүлэх
Худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөрт тооцон суутгаж төлбөр авагчид шилжүүлэх, уг зорилгоор албадан чөлөөлөх

Мөн түүнчлэн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авсан даруйд төлбөр төлөгч, түүний хөрөнгийн мэдээллийг цуглуулах, тогтоогдсон хөрөнгийн эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3. Хөрөнгө албадан худалдан борлуулах, хөрөнгө санал болгох

Төлбөрт гаргуулсан хөрөнгийг хураан авч, үнэлгээ тогтоосноос хойш 2 сарын дотор, хэрэв төлбөр төлөгчийн өөрийн хөрөнгөө бие даан худалдан борлуулах саналыг хүлээн авч, шийдвэрлэсэн бол 3 сарын дотор худалдан борлуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулна.

Хөдлөх эд хөрөнгөд үнэ хаялцуулах дуудлага худалдаа явуулна, үл хөдлөх эд хөрөнгө эд хөрөнгөд албадан дуудлага худалдаа явуулна. Хөдлөх эд хөрөнгийг худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдээр дамжуулан худалдан борлуулж болно. Төлбөр төлөгчид өөрийн хөрөнгөө худалдан борлуулах хугацаа олгож болно.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад дараах үндэслэлээр төлбөрт гаргуулсан хөрөнгийг төлбөр авагчид санал болгоно.

- Хөрөнгийн үнэлгээ тогтоосон шийдвэрийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор төлбөрт тооцон авах хүсэлтийг төлбөр авагч гаргасан
- Төлбөр төлөгчид олгосон өөрийн хөрөнгөө бие даан худалдан борлуулах хугацаанд хөрөнгийг борлуулахгүй бол
- Дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй хөрөнгийг иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг хасч төлбөрт сутган авахыг төлбөр авагчид санал болгох
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.5-д заасны дагуу иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгахаас өмнө талууд эвлэрэх эрхтэй ба уг эрхийн хүрээнд хөрөнгийг төлбөрт тооцох талуудын эвлэрлийг үндэслэн хөрөнгө шилжүүлж болно.

4. Төлбөр гаргуулсан мөнгөн хөрөнгө хуваарилах, төлбөр авагчийн шаардлага хангах

Төлбөр гаргуулсан эд хөрөнгийн үнэлгээ тогтоосноос хойш хэд хэдэн төлбөр авагчаас хөрөнгийн төлбөрт тооцон авах санал гаргасан тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийн шаардлага хангах дарааллыг баримтлахгүй ба тухайн хөрөнгийг худалдан борлуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, дуудлага худалдааны орлогыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 74.32-д заасны дагуу хуваарилж, үлдэгдэл орлогын мөнгийг мөн хуулийн 112.32-д заасан дарааллыг үндэслэн гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангана.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад гүйцэтгэх баримт бичиг ирсэн дарааллыг цахим сангийн нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн хугацаагаар тооцно. Гүйцэтгэх баримт бичгийн цахим сангийн бүртгэл, анхан шатны бүртгэл нь зөрүүгүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 112.1-д заасан "... нэг гүйцэтгэх баримт бичгээр шаардлага хангах"-д хэд хэдэн төлбөр авагч нэг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн ажиллагаагаар төлбөрийн шаардлага тогтоолгосон тохиолдолд төлбөрт гаргуулсан хөрөнгө, мөнгийг хувь тэнцүүлэн олгох дарааллыг баримтална. Жишээлбэл,

иргэний хэргийн улмаас хохирсон хэд хэдэн төлбөр авагч байгаа тохиолдолд тухайн иргэний хэргийн улмаас хохирсон хэд хэдэн төлбөр авагч байгаа тохиолдолд тухайн иргэний хэргийн төлбөр авагч нэг бүрийн авах төлбөрийн хэмжээгээр хувь тэнцүүлэн олгох дарааллаар гүйцэтгэх баримт бичгийн шаардлага хангагдана.

4.5. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа өнөөгийн нөхцөл байдал


Иргэний шийдвэр гүйцэтгэвэл зохих хэргийн тоо жил бүр өссөн үзүүлэлттэй байна. Тухайн жил дэх шийдвэр гүйцэтгэвэл зохих хэргийн шийдвэр гүйцэтгэлийн биелэлтийн хувь дунджаар 50 орчим хувьтай байдаг байна.

Хүснэгт 19. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны 2014-2019 оны мэдээ

№	Онууд	Шүүхээс шинээр ирсэн	Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн	Үүнээс талууд эвлэрсэн
1	2014 ОН	Гүйцэтгэх хуудасны тоо	Мэдээлэл байхгүй	19,507.0	13,068.0
		Мөнгөн дүн	Мэдээлэл байхгүй	840,536,988.6	333,061,612.9
2	2015 ОН	Гүйцэтгэх хуудасны тоо	24,608.0	30,869.0	16,347.0
		Мөнгөн дүн	509,535,272.5	848,973,885.2	168,230,853.0
3	2016 ОН	Гүйцэтгэх хуудасны тоо	23,367.0	35,908.0	17,721.0
		Мөнгөн дүн	631,975,986.7	1,218,647,885.5	149,670,798.7
4	2017 ОН	Гүйцэтгэх хуудасны тоо	22,569.0	39,405.0	19,648.0
		Мөнгөн дүн	519,025,566.4	1,448,379,834.0	294,940,057.2
5	2018 ОН	Гүйцэтгэх хуудасны тоо	21,707.0	38,579.0	20,054.0
		Мөнгөн дүн	751,409,970.8	1,848,896,314.6	504,376,269.1
6	2019 ОН	Гүйцэтгэх хуудасны тоо	22,104.0	40,998.0	18,859.0
		Мөнгөн дүн	636,517,933.8	1,908,797,364.2	640,227,780.0
					17,317,469.4

Тухайлбал 2019 оны хувьд нийт 40,998 шийдвэр гүйцэтгэвэл зохих хэргээс 18,859 хэрэг шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаагаар дамжин биелэгдсэнээс 1863 хэрэг дээр талууд эвлэрсэн байна.

График 18. Нийт шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эзлэх хувь (2019)




2015-2019 оныг хамруулсан статистикийг үзвэл шүүхээс жилд дунджаар 21584 гүйцэтгэх баримт бичиг хүлээн авсны 19019 буюу 88.1 хувь нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа эзэлж байна. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар дамжин байгуулагдан, шүүгчийн захирамжаар баталгаажсан эвлэрлийн гэрээг албадан гүйцэтгүүлэхээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандах явдал харьцангуй бага буюу нийт иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны 2%-ийг гадаад улсын шүүхийн шийдвэр, арбитрын шийдвэртэй нийлээд эзэлж байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан шүүхэд маргаан үүсгэх тохиолдолд хуульд заасны дагуу анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхээр наад зах нь 120 хоногийн хугацаанд иргэний хэрэг хянагдах, холбогдох шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх нөхцөлийг үүсдэг байна.

2019 онд төлбөр төлөгчөөс 234, төлбөр авагчаас 26, гуравдагч этгээдээс 40 нийт 300 нэхэмжлэл шүүхэд гаргасан байна.

График 19. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой маргааныг шүүхээр шийдвэрлэсэн байдал (2019)



Үүнээс нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон, буцаасан 149 хэрэг, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүйд тооцогдсон 35 хэрэг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа 117 хэрэг байна.

Энэ нь төлбөр авагч, төлбөр төлөгч, гуравдагч этгээдийн зүгээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эсрэг шүүхэд нэхэмжлэл гаргах тохиолдол цөөнгүй байгааг харуулж байгаа бөгөөд энэ төрлийн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах боломжтой юм.

ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

5.1. ДҮГНЭЛТ

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг судалсан байдалдаа үндэслэн бүхэлд нь дүгнэж үзвэл өнөөг хүртэл энэ хууль амжилттай хэрэгжиж ирсэн байна. Ийнхүү амжилттай хэрэгжихэд тесөв, санхүү, зохион байгуулалтын хүрээнд зохих этгээдүүд дэмжлэг үзүүлж ирсэн нь ихээхэн үүрэг гүйцэтгэсэн ба цаашид хууль үр нөлөөтэй хэрэгжихэд эвлэрүүлэн зуучлалын асуудлыг бүхэлд нь хариуцаж ирсэн Шүүхийн ерөнхий зөвлөл тухайллан анхаарч үзэх, цаашид өнөөг хүртэл үзүүлж ирсэн дэмжлэгээ бууруулахгүй байх, боломжтой хүрээнд илүү анхаарал тавих нь зайлшгүй чухал, хэрэгтэй нөхцөл болоод байна.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр нөлөөний судалгааг зорилгод хүрсэн түвшин, практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд судлалаа. Иймд тухайн сонгон авсан шалгуур үзүүлэлт тус бүрээр Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэв.

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд

1. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын талаар.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль 2013 онд батлагдан, 2014 оноос иргэний хэргийн анхан шатны 38 шүүхэд нийт 44 эвлэрүүлэн зуучлагчийг ажиллуулснаас хойш даруй 6 жилийн хугацаа өнгөрөөд байна. Эдгээр хугацаанд нийт 223,468 иргэний хэргээс 47,587 хэрэг буюу дунджаар нийт иргэний хэргийн 17.2 хувийг эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар амжилттай шийдвэрлэсэн нь иргэний хэргийн шүүхийн ачааллыг тэр хувиар багасгаж буй ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл, энэ нь иргэний хэргийн шүүхийн ачаалал ойролцоогоор 20 шахам хувиар багассан үзүүлэлт бөгөөд эвлэрүүлэн зуучлалын тухай хууль хэрэгжснээр дараах эерэг үр дагаврыг үүсгэж байна.

- Шүүхээр шийдвэрлэгдэх хэрэг маргааны тоо багассанаар шүүгчийн ачаалал буурах бөгөөд нэг шүүгчид ногдох хэргийн тоо мөн тодорхой хувиар багасч байна. Үүнийг дагалдаад шүүгч өөрийн мэдлэг боловсролдоо анхаарах, ур чадвараа дээшлүүлэх боломж нэмэгдэхийн зэрэгцээ шийдвэрлэж буй хэргийн чанар сайжрах боломжийг нэмэгдүүлж байж болох юм. Түүнчлэн эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар дамжин байгуулагдсан эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шүүгчийн захирамжийг албадан гүйцэтгүүлэхээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандах тохиолдол маш бага хувьтай байгаа нь эвлэрүүлэн зуучлалын ач холбогдол шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд хүртэл илэрч буйг харуулна. Шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлж буй талууд эвлэрүүлэн зуучлалд хандсанаар шүүхтэй харьцуулахад богино хугацаанд, өөрсдийн хүсэл зоригт нийцсэн байдлаар эвлэрлийн гэрээ байгуулах замаар хэргээ шийдвэрлүүлж байна. Нөгөө талаар тэмдэгтийн хураамжийн хэмжээ нь шүүхтэй харьцуулахад туйлын бага байгаа нь иргэн, хуулийн этгээдэд ногдох санхүүгийн ачаалал, шууд зардлыг хэмнэх, цаг хугацаа бага зарцуулах зэргээр шууд бус зардлыг бууруулахад ихээхэн хувь нэмрийг оруулж байна. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулдаг нь тухайн маргаанаар дахин шүүхэд хандахгүй, гэрээний үүргийн гүйцэтгэлийг биелүүлээгүй тохиолдолд шүүхийн шийдвэрийн нэгэн адил албадан гүйцэтгэх боломжтойгоороо гэрээний үүрэг бодитоор биелэгдэх боломжийг бүрдүүлж байна.

2. Эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх сургалт болон дүрэм, журмын талаар.

Эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх сургалтын хувьд Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлөөс жил бүр нэг удаа эвлэрүүлэн зуучлагчийн давтан сургалтыг тогтмол явуулж байгаа нь эвлэрүүлэн зуучлагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх ач холбогдолтой гэж дүгнэж байна. Түүнчлэн тус Зөвлөлөөс нийт 882 эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэсэн бөгөөд эвлэрүүлэн зуучлагчтай холбоотой гомдлыг цаг тухайд нь хянан шийдвэрлэсэн байна.

Цаашид эвлэрүүлэн зуучлах ажиллагааны чанарыг дээшлүүлэхэд эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх сургалт болон давтан сургалт нэн чухал бөгөөд тухайллан сургалтын стандартыг бий болгох замаар сургалтын хөтөлбөрийг стандартад нийцүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Улмаар эвлэрүүлэн зуучлагчийг мэргэшүүлэхэд илүү анхааран холбогдох боловсролын байгууллага болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудтай хамтран ажиллахаас гадна сургагч багш нарыг шинээр бэлтгэх зэрэг зайлшгүй хийхгдэх ажиллагаанд хөрөнгө, санхүүгийн асуудлыг төсөвт тусгах шаардлагатай.

Эвлэрүүлэн зуучлалын ажиллагааны өнөөг хүртэл хүрсэн амжилтыг бууруулахгүй, бататгахад хөрөнгө, санхүүгийн дэмжлэг ихээхэн хэрэгтэй байнаб

Мөн Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журмыг батлан мөрдүүлж байгаа нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль саадгүй хэрэгжих гол үндсийг бүрдүүлсэн гэж үзэж байна.

Гэвч Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль нь эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр эвлэрүүлэх шүүхийн бус аргыг хэрэглэх эрх зүйн үндсийг бий болгосон бөгөөд энэ хууль нь харьцангуй хураангуй буюу зарим ажиллагааны талаар процессын зхицуулалт байхгүй зэргээс Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлөөс гаргасан “Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны тухай” журам нь эрх зүйн хэм хэмжээ тогтоох зэрэг асуудлыг үүсгэж байж болохоор байна.

3. Төрийн болон төрийн бус байгууллага дахь эвлэрүүлэн зуучлагчийн талаар.

Манай улсын хувьд шүүх дэх эвлэрүүлэн зуучлал болон шүүхээс гадуур бусад байгууллага дахь эвлэрүүлэн зуучлал байх холимог тогтолцоог хуульчилсан. Өнөөдрийг хүртэл тус хуулийн хэрэгжилтийн гол цөм нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх, сайжруулахад чиглэгдсэн байна. Өөрөөр хэлбэл шүүхээс гадуурх төрийн болон төрийн бус, мэргэжлийн холбоод дахь эвлэрүүлэн зуучлалын бодит хэрэгжилт хангалтгүй байна гэж дүгнэв.

Учир нь судалгааны үр дүнгээс үзэхэд шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаас гадна нийт 3 байгууллагад эвлэрүүлэн зуучлах бүтцийг байгуулсан боловч эвлэрүүлэн зуучлал тогтвортой явагдаагүй байна. Тухайлбал, MYXAYT-ын дэргэд БМЭЗТ-ийг байгуулж, эхэн үедээ хэд хэдэн хэрэг маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулж байсан ч үүрэг гүйцэтгэгч тал гэрээний үүргээ гүйцэтгээгүйгээс дахин шүүхэд хандаж хэргээ шийдвэрлүүлэх хэд хэдэн тохиолдол гарснаас БМЭЗТ нь үйлчлүүлэгчддээ эвлэрүүлэн зуучлалыг санал болгохоо больсон байна.

Өөрөөр хэлбэл, төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод эвлэрүүлэн зуучлагч ажиллаж, талуудын маргааныг амжилттай шийдвэрлэсэн ч тус эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулдаггүй нь тухайн маргаанаар дахин шүүхэд хандах нэмэлт зардал үүсгэх, цаг хугацаа алдах зэрэг сөрөг нөлөөллийг үзүүлж байжээ.

Мөн шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын улсын тэмдэгтийн хураамж 30000 төгрөг байгаа бол төрийн бус байгууллага дахь эвлэрүүлэн зуучлалын хураамж үнээс хэд дахин өндөр үнийн дүнтэй байжээ. Төрийн бус байгууллага дахь эвлэрүүлэн зуучлал нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлалтай өрсөлдөх боломжгүй байсан байна.

Нөгөө талаас шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын улсын тэмдэгтийн хураамж тогтмол үнийн дүнтэй байгаа нь зарим хэрэг дээр шүүхэд хандаж хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхэд төлдөг улсын тэмдэгтийн хураамж (Нэхэмжлэлийн үнийн дүн 0-130 000 төгрөг бол 4550 төгрөг улсын тэмдэгтийн хураамжинд төлдөг)-аас өндөр үнийн дүнтэй байна. Иймд шүүх

дэх эвлэрүүлэн зуучлалд төлөх улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг ухаалаг байдлаар шийдвэрлэх нь төрийн бус байгууллага дахь эвлэрүүлэн зуучлалын хөгжилд нөлөөлөхөөс гадна шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаатай холбоотой улсын тэмдэгтийн хураамжийг зохистой болгох юм.

Түүнчлэн зарим төрийн байгууллагад эвлэрүүлэн зуучлалтай төстэй хэлбэрийн маргааныг урьдчилан шийдвэрлэх тогтолцоо бий болж хэвшишэн. Тухайлбал, хөдөлмөрийн маргаан таслах комисс, үнэт цаасны зах зээлд оролцогч зохицуулалттай этгээдүүдийн хооронд гарсан маргааныг шийдвэрлэх зорилго бүхий маргаан таслах зөвлөл зэрэг бүтцүүд байгаа нь шүүхээс бусад төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод эвлэрүүлэн зуучлагч ажиллаж болох зохицуулалт хэрэгжихгүй байгаатай холбоотой байх талтай.

4. Эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх маргааны онцлогийн талаар.

Эвлэрүүлэн зуучлалыг иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан, гэр бүлийн эрх зүйн маргаанд ашиглахаар заасан. Хэдийгээр эдгээр маргаан нь эрх зүйн маргаан гэдэг талаасаа адил боловч маргааны агуулга, оролцогчдын төлөв байдал, нийгэмд үзүүлэх нөлөөлөл зэргээрээ ихээхэн ялгаатай. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиар бүх маргааныг шийдвэрлэх эвлэрүүлэн зуучлагчид тавигдах шаардлага, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах хугацаа, эрх хэмжээ зэргийг нийтлэг байдлаар зохицуулснаас үүдэн иргэний эрх зүйн, хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг амжилттай шийдвэрлэсэн хувь болон гэр бүлийн эрх зүйн маргааныг амжилттай шийдвэрлэсэн хувь урвуу хамааралтай байна.

Өөрөөр хэлбэл, гэр бүлийн эрх зүйн маргааны хувьд иргэний болон хөдөлмөрийн эрх зүйн маргаантай харьцуулахад эвлэрүүлэн зуучлагчаас сэтгэл зүйн болон харилцааны нарийн ур чадвар шаардах бөгөөд олон удаагийн уулзалт хийх, оролцогчидтой ганцаарчилсан уулзалт хийх замаар сэтгэл зүйн байдлыг тогтоох зэргээр цаг хугацааны хувьд ч илүү хугацаа шаарддаг онцлогтой байна.

Иймд гэр бүлийн эрх зүйн маргаан дахь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам, эвлэрүүлэн зуучлагчид тавигдах шаардлага зэрэг эрх зүйн зохицуулалтыг эргэж харах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд

1. Эвлэрүүлэн зуучлагчид тавигдах шаардлагын талаар.

Хөдөлмөрийн эрх зүйн маргаан болон иргэний эрх зүйн маргаанд талууд өөрсдөө асуудлаа шийдэх, асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах чадвартай байдаг бол гэр бүлийн эрх зүйн маргаанд талууд өөрсдөө асуудлыг шийдэх, харилцан ярилцах нь хүндрэлтэй юм. Иймд эвлэрүүлэн зуучлагч нь гэр бүлийн харилцаагаар мэргэшсэн байх шаардлагатай тулгарч байгаа бөгөөд гэр бүлийн маргааны эвлэрүүлэн зуучлагчийг энэ төрлөөр нь дагнан мэргэшүүлэх хэрэгтэй ба гэр бүлийн эрх зүйн маргааныг шийдвэрлэх

эвлэрүүлэн зуучлагчид тавигдах шаардлагыг эвлэрүүлэн зуучлагчид тавигдах нийтлэг шаардлагаас тусад нь хуульчлах боломжтой байна.

2. Эвлэрүүлэн зуучлагчийн эрх хэмжээний талаар.

Эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа явуулахад тулгарч буй хамгийн түгээмэл асуудал нь эвлэрүүлэн зуучлагч талуудыг шүүхийн мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлэх боловч албадан ирүүлэх эрх хэмжээ байхгүйгээс талуудын аль нэг нь ирэхгүй байх гэж судалгаанд оролцогчид дүгнэсэн байна.

Гэвч эвлэрүүлэн зуучлах ажиллагааны онцлог нь талууд сайн дурын үндсэн дээр оролцож, хүсэл зоригоо илэрхийлэн эвлэрлийн гэрээ байгуулах буюу ямар нэгэн албадлагын шинж агуулдаггүй. Хэрэв эвлэрүүлэн зуучлагч талуудыг албадан ирүүлэх арга хэмжээ авах эрхтэй болбол эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зарчимтай зөрчилдэх эрсдэлтэй. Гагцхүү гэр бүлийн эрх зүйн маргаан нь сайн дурын үндсэн дээр эвлэрүүлэн зуучлах ажиллагааг сонгох бус шүүхээс гадуур хэрэг маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа гэж үздэгээс заавал эвлэрүүлэн зуучлалд хандсаны дараагаар шүүхэд хандах эрх нээгддэг. Энэ тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдах ёстой боловч талуудын хэн нэг нь ирэхгүй байх зэргээр эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд саад учруулах, цаг хугацаа алдах зэргээр маргалдагч аль нэг талд хүндрэл учруулах нөхцөлийг бүрдүүлдэг байна.

3. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хугацаа.

Гэр бүлийн маргаан нь бусад иргэний эрх зүйн болон хөдөлмөрийн ганцаарчилсан маргаантай адил хугацаанд буюу 30 хоногийн хугацаанд шийдвэрлэгдэхээр хуульчлагдсан. Гэтэл энэхүү хугацаа нь богино байх бөгөөд эвлэрүүлэн зуучлалд талуудыг албадан ирүүлэх зэрэг албадлагын арга хэмжээ авах эрх байхгүй учраас энэ хугацаанд талуудыг дуудаж уулзах, эвлэрүүлэх ажиллагаа хийх нь төдийлөн үр дүнд хүрдэггүй байна. Түүнлчэн хуульд заасны дагуу талуудын хүсэлтийн дагуу нэг удаа 30 хоногоор сунгах боломжтой байдаг ч гэрлэлт цуцлах маргаанд талуудын хэн аль нь хүсэлт гаргах тохиолдол туйлын цөөхөн учир хуульд заасан 30 хоногийн хугацааг хэрэг маргааны төрлөөс хамааран гэр бүлийн эрх зүйн маргаанд ялгамжтай тогтоох нь гэр бүлийн маргаан дахь эвлэрлийн хувь өсөх боломжийг бий болгож болох юм.

4. Хөөн хэлэлцэх хугацааны талаар

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эхэлснээр иргэний хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасалдах эрх зүйн зохицуулалттай. Энэ хүрээнд шүүх дэх эвлэрүүлэн зуучлал нь Эвлэрүүлэн зуучлалын нэгдсэн мэдээллийн системтэй болсон. Тус бүртгэлийн нэгдсэн систем нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үндсэн зарчмуудад тулгуурласан бөгөөд тухайн ажиллагааны нийт процесс буюу өргөдөл хүлээн авахаас эхлэн эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулах хүртэл ажиллагаа хамаарахаас гадна иж бүрэн хайлтын систем, хугацааны хяналт, статистик, тайлан мэдээ гаргах ажлыг боловсронгуй болгосон, мэдээллийг олон дахин оруулах шаардлагагүй буюу мэдээллийн давхардал,

зөрчлийг арилгасан, хэрэглээний хувьд хялбар, график дизайны хувьд дэвшилттэй зэрэг олон давуу талтай цогц систем болсноор эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулсан хугацааг тооцох, улмаар иргэний хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тооцоход хялбар болсон байна.

Эцэст нь судалгааны багийн зүгээс Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилт сайн гэж дүгнэж байгаа бөгөөд үүсч буй хүндрэл, бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх талаарх саналаа Зөвлөмж хэсэгт дэлгэрэнгүй танилцуулав.

5.2. ЗӨВЛӨМЖ

Эвлэрүүлэн зуучлалыг Монгол Улсад нутагшуулах, хөгжүүлэх, төсөв, санхүүгээр дэмжихэд хууль хэрэгжиж эхэлсэн эхний жилүүдэд хэрэгжсэн Японы Жайкагийн төсөл ихээхэн үүрэг гүйцэтгэжээ. Иймд цаашид Шүүхийн ерөнхий зөвлөл, түүний ажлын албаны Үүрэг, оролцоо, дэмжлэг, Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн манлайлал ихээхэн чухал байна. Мөн энэ хүрээнд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд дор дурдсан хүрээнд илүү нарийвчлан зохицуулалт хийх шаардлагатай нь харагдаж байна.

Энэхүү судалгааны дүгнэлт, агуулгад үндэслэн цаашид Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааг сайжруулах талаар

Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойши хугацаанд шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хэрэгжилт хангалттай сайн түвшинд хэрэгжиж байна. Гэхдээ эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэж буй өргөдөл, маргааны төрлөөс хамааруулан ялгамжтай зохицуулалт хийгдэх шаардлагатай гэж үзэв. Өөрөөр хэлбэл, иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн эрх зүйн маргаанаас гэр бүлийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах замаар шийдвэрлэх журмыг ялгамжтайгаар зохицуулах шаардлагатай.

Нийт эвлэрүүлэн зуучлалаар амжилттай шийдвэрлэгдэж буй маргааны дийлэнх нь иргэний эрх зүй, хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан байгаа бол гэр бүлийн эрх зүйн маргааны эвлэрлийн хувь харьцаангуй бага байна. Иймд гэр бүлийн эрх зүйн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах дараах өөрчлөлтийг оруулах нь зүйтэй.

- Гэр бүлийн эрх зүйн маргаанд эвлэрүүлэн зуучлал явуулах эвлэрүүлэн зуучлагчид хуульд заасан шаардлагаас гадна нэмэлт шаардлага тавих. Тухайлбал, сэтгэл судлалын чиглэлээр тодорхой мэргэжсэн, сургалтад хамрагдсан эсхүл мэргэшсэн байх нь чухал. Гэр бүлийн эрх зүйн маргааны дийлэнх нь гэрлэлт цүцлалттай холбоотой байдаг тул гэрлэгчдийн сэтгэл зүйн байдлыг тодорхойлж, түүнд тохирсон арга барилаар эвлэрүүлэн зуучлалыг явуулах нь зүйтэй.
- Гэр бүлийн эрх зүйн маргаанд мэргэжлийн сэтгэл судлаач, шинжээчийг оролцуулдаг байх.
- ИХШХШТХ-ийн 132.4-д зөвхөн "гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй эсхүл учирсан байх" тохиолдолд талуудыг эвлэрүүлэх арга хэмжээ авахгүй буюу эвлэрүүлэн зуучлалаар

дамжихгүйгээр гэрлэлтийг цуцлах боломжтой байдлаар хуульчилсан. Гэвч тус хэсэгт сэтгэл санааны болон эдийн засгийн дарамтад байгаа тохиолдлыг хамруулаагүй. Шүүгч нарын хувьд сэтгэл санааны болон эдийн засгийн дарамт зэрэг үндэслэлд анхаарал хандуулдаггүй, бие махбодийн дарамт гэдэгт гэмтэл учруулсан байх, цагдаад тэмдэглүүлсэн байх зэрэг нотлох баримт шаардах нь түгээмэл болох нь судалгааны явцад нийтлэг ажиглагдсан. Иймд сэтгэл санааны болон эдийн засгийн дарамтанд байгаа, эсхүл олон жил тусдаа байгаа, тус тусын амьдралтай болсон бөгөөд нэгэнт эвлэрэхгүй нь тодорхой гэрлэгчдийг заавал эвлэрүүлэн зуучлалаар дамжихгүйгээр гэрлэлтээ цуцлуулдаг болох зохицуулалтыг холбогдох хуульд оруулах.

- Гэр бүлийн эрх зүйн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах хугацааг уртасгах. Гэрлэлт цуцлалттай холбоотой маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахад талуудтай ганцаарчилсан болон хамтарсан уулзалт хийх, сэтгэл зүйч оролцуулах зэргээр хуульд заасан хугацаанд ажиллагаа хийж амжихгүй байх тохиолдол багагүй хэмжээтэй гарч байна. Иймд заавал хоёр талын хүсэлтээр бус нэмэлт ажиллагаа хийхэд эвлэрэх магадлалтай байгаа тохиолдолд эвлэрүүлэн зуучлагч санаачилгаараа хугацаа сунгах боломжтой байхаар зохицуулах.
- ИХШХШТХ-ийн 132 дугаар зүйлийн 132.4-т зааснаас бусад гэр бүлийн эрх зүйн маргаан нь шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журмын дагуу явагддаг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа буюу хуулиар заавал хийгдэх ажиллагаа учраас хариу тайлбар гаргагчийг шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд албадан ирүүлэх арга хэмжээг шүүхээр дамжуулан авдаг болгох.
- Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааны улсын тэмдэгтийн хураамжийг хэмжээг өөрчлөх, шүүхээс эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээний адилаар үнийн дүнтэй уялдаж нэмэгдэх байдлаар хуульчлах

2. Төрийн (шүүхийн бус) болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод дахь эвлэрүүлэн зуучлагчийн талаар

Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод дахь эвлэрүүлэн зуучлагч ажиллах эрх зүйн зохицуулалт нээлттэй боловч хэрэгжилтийн хувьд туйлын хангалтгүй байгаатай холбоотойгоор хуульд дараах арга хэмжээг авахыг зөвлөж байна.

- Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэд эвлэрүүлэн зуучлагчтай байх зохицуулалтын хэрэгжилтийг сайжруулах, хэрэг маргааны төрлөөр дагнан мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчтай байх зорилгод хүрэхийн тулд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг тодруулах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, тус заалт нь төрийн болон төрийн бус байгууллагад эвлэрүүлэн зуучлагч ажиллах боломжийг нээж өгсөнөөс өөрөөр хэрхэн ажиллах, Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлтэй ямар харилцаатай байх, эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэхэд хэрхэн дэмжлэг үзүүлэх болон процессын зохицуулалт зэрэг суурь асуудлууд тусгагдаагүй байна.
- Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд төр, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо дахь эвлэрүүлэн зуучлал байж болно гэснээс бус хуулийн этгээдийн эрхтэй этгээд мөн эсэх, ямар хэлбэрт нь хамаарах, түүний байгуулагдах журам, үүсгэн

байгуулах байгууллага, бүтэц, дүрмийг батлах эрх бүхий этгээд байх эсэх үйл ажиллагааны зардлын эх үүсвэр гээд олон асуудал хуулиар зохицуулагдаагүй байна. Үүний тулд нэн тэргүүнд шийдвэрлэх асуудал нь байнгын тогтвортой үйл ажиллагаа явуулахын тулд санхүүжилтын эх үүсвэрийг бий болгох, энэ төрлийн эвлэрүүлэн зуучлал явуулахад дэмжлэг үзүүлэх боломжтой байдлаар зохицуулах.

- Түүнчлэн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д Эвлэрүүлэн зуучлагчдийн зөвлөлийн бүрэн эрхэд а. Эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх, давтан сургах сургалтын хөтөлбөрийг боловсруулах, сургалт зохион байгуулах; б. Эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулах, эрхийн гэрчилгээ олгох, эвлэрүүлэн зуучлагчийг бүртгэх, нэrsийн жагсаалтыг олон нийтэд нээлттэй зарлах ажлыг зохион байгуулах; в. Эвлэрүүлэн зуучлагчийн эрхийг түдгэлзүүлэх, хасах, гэрчилгээг хүчингүй болгох, нэrsийн жагсаалтаас хасах эдгээрээс өөрөөр аливаа үйл ажиллагаанд нь оролцох боломжгүй байна. Иймд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-д “Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч ачаалал нэмэгдсэн, тусгай мэргэжлийн эвлэрүүлэн зуучлагч шаардлагатай болсон, эсхүл талууд өөр эвлэрүүлэн зуучлагч сонгосон тохиолдолд тухайн маргаанд орон тооны бус эвлэрүүлэн зуучлагчийг оролцуулна” гэсэн заалтыг хэрэглэж, төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын эвлэрүүлэн зуучлалтай хамтран ажиллах боломж байж болно. Гэхдээ эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зардал, ажлын хөлсний хувьд шүүхийн журмаар маргаан шийдвэрлэх зардлаас бага байх ёстойг анхаарах.
- Түүнчлэн зарчмын хувьд Эвлэрүүлэн зуучлагчдийн зөвлөлөөс төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод дахь эвлэрүүлэн зуучлагчийн үйл ажиллагаанд аттестачлал хийх, ёс зүйн болон үйл ажиллагааны дүрэм, журам зөрчиж хариуцлага хүлээсэн эвлэрүүлэн зуучлагчийг олон нийтэд мэдээлэх, тус байгууллагууд дахь эвлэрүүлэн зуучлагчийн үйл ажиллагаанд зөвлөмж өгөх зэргээр оролцдог байхаар зохицуулах боломжтой.
- Төрийн болон төрийн бус байгууллага дахь Эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг шүүгч хянан үзсэний үндсэн дээр шүүгчийн захирамжаар баталгаажуулдаг болох.
- Төрийн байгууллагуудад нэгэнт бий болсон маргааныг урьдчилан шийдвэрлэх бүтцэд эвлэрүүлэн зуучлагч орж ажиллах, эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх боломжийг судлах.

3. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуультай холбоотой бусад санал

- Цаашид Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн процесс ажиллагааны зохицуулалтыг илүү дэлгэрэнгүй байдлаар хуульчлахгүй бол эвлэрүүлэн зуучлалаар маргааныг шийдвэрлэх процессын асуудлыг үндсэндээ үйл ажиллагааны журмаар зохицуулж байна.
- Эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх сургалт болон давтан сургалтын стандартыг бий болгох замаар сургалтын хөтөлбөр, агуулгын чанарыг сайжруулах.
- Эвлэрүүлэн зуучлагчийг хэрэг маргааны төрлөөр дагнан мэргэшүүлэхээс гадна эвлэрүүлэн зуучлагчийн ур чадварыг дээшлүүлэх.

- Банк, санхүүгийн байгууллага, иргэд хоорондын зээлийн гэрээтэй холбоотой маргааныг шийдвэрлэдэг бие даасан эвлэрүүлэн зуучлал байх боломжийг судлах нь зүйтэй.
- Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үе шатуудыг хуульчлах буюу процесс тодорхой болгох.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

Хууль тогтоомж

1. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль 2012 он.
2. Иргэний хууль 2002 он.
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2002 он.
4. Гэр бүлийн тухай хууль 1999 он.
5. Хөдөлмөрийн хууль 1999 он.
6. Арбитрын хууль 2017 он.
7. Монгол Улсын Шүүхийн тухай хууль 2012 он.
8. Шүүхийн захиргааны хууль 2012 он.
9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он.
10. Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн дүрэм
11. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам
12. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны ажлын байрны стандарт

Судалгааны материал

1. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн мониторингийн судалгаа 2015 он
2. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн онол, арга зүйн тайлбар. 2015 он
3. 2014-2019 оны Иргэний хэргийн Шүүн таслах ажиллагааны дүн мэдээлэл
4. Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн тайлан 2013-2019 он
5. Монголын Олон улсын Арбитраас авсан хэрэг шийдвэрлэлтийн тоон мэдээлэл. 2017-2019 он.
6. ШУА-ийн ФСХ, УБИС. Монголын гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, Улаанбаатар: 2010.
7. Үндэсний статистикийн хороо. Өрх, гэр бүлийн байдал, гэрлэлт сэдэвт судалгааны тайлан, Улаанбаатар: 2010.
8. НЗДТ, ШХА “Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөний судалгаа”, 2018
9. YCX, (2011) Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын нэгдсэн дүн, Улаанбаатар

